УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

ТАЙЛАН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2021 он

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

Эрхлэн гаргасан: **УИХ дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын алба**

Хянасан: **УИХ дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны дарга Д.Амарбаясгалан**

Эхийг бэлтгэсэн: **Г.Энхчулуун**

Цаасны хэмжээ: **B5 (176мм x 250мм)**

АГУУЛГА

Өмнөх үг	04
Гишүүдийн танилцуулга	08
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн байр суурь	10
Ковидын үеийн сөрөг хүчин	16
Үйл явдлын мэдээ	19
Хариуцлага	27
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдийн байр суурь, үйл ажиллагаа	31
УИХ-ын гишүүн Дашдондогийн Ганбат	32
УИХ-ын гишүүн Буланы Бейсен	34
УИХ-ын гишүүн Наянтайн Ганибал	36
УИХ-ын гишүүн Ширнэнбандийн Адьшаа	38
УИХ-ын гишүүн Амгалангийн Адъяасүрэн	40
УИХ-ын гишүүн Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ	42
УИХ-ын гишүүн Жамбын Батсуурь	44
УИХ-ын гишүүн Салдангийн Одонтуяа	46
УИХ-ын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж	48
УИХ-ын гишүүн Цэвэгдоржийн Туваан	50
УИХ-ын гишүүн Одонгийн Цогтгэрэл	52
Хэлэлцсэн гол хуулиуд	54
Байнгын хороо, ажлын хэсэгт ажилласан байдал	55
Хуулийн төслийн хэлэлцүүлэг	58
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдийн хамтдаа санаачлан боловсруулсан хуулийн төслүүд	64
Бүлгийн гишүүдийн санаачлан боловсруулсан хуулийн төслүүд	68
Бүлгээс гарсан шаардлага, мэдэгдэл	73
Бүлгээс гарсан санал, дүгнэлт	88
УИХ-ын гишүүний тавьсан асуулга, асуулт	109
УИХ-ын 2020 оны намрын чуулганаар хэлэлцсэн гол хуулиудын танилцуулга	125
УИХ-ын 2020 оны намрын ээлжит чуулганаар батлагдсан хууль, УИХ-ын бусад шийдвэрийн жагсаалт	147
2020 оны макро эдийн засгийн дүн	155
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын алба	159
Фото мэдээ	160



Өмнөх үг

Монгол Улсын Их Хурлын найм дахь удаагийн ээлжит сонгуулийн дүнгээр Ардчилсан нам 11 гишүүнтэйгээр бүлэг байгуулан ажиллаж ирлээ. Ардчилсан намын бүлэг УИХ-ын 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд нийтдээ 16 удаа хуралдаж, хууль, УИХ-ын шийдвэрийн бусад төсөл зэрэг нийт 79 асуудал хэлэлцэж хууль тогтоох үүргээ биелүүлэн, эрх баригчид болон Гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэхтэй холбоотойгоор 2020 оны намрын чуулганаар хэд хэдэн хуулийн төслийг хэлэлцэн баталлаа. Тухайлбал, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /МУЗЗНДНТУт/ хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Шүүхийн тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг томоохон хуулиудыг хэлэлцэн, зарим хуулийн төслийг баталжээ.

Коронавирусын халдварт /Ковид-19/ цар тахлын үед УИХ-ын намрын чуулганаар нийт 82 хоногийн хугацаанд УИХ-ын чуулган 131 удаа, Байнгын хорооны хуралдаан 114 удаа хуралдаж, 87 хууль, 45 тогтоолын төслийг хэлэлцэн баталж, цаг үеийн болон шаардлагатай олон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

УИХ-аар хэлэлцэж буй хуулийн төслийг чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хорооны ажлын хэсэгт Ардчилсан намын бүлгийн гишүүд оролцон, идэвх санаачилга гарган ажилласан. МУЗЗНДНТУт хуулийн ажлын хэсэгт Ж.Батсуурь, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай

хуулийн ажлын хэсэгт А.Адъяасүрэн нарын гишүүд ажиллаж, олон зүйл, заалтын хүрээнд зарчмын зөрүүтэй саналуудаа хуульд тусгуулжээ. Мөн бид Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, МУЗЗНДНТУт хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслүүд дээр Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран ажиллаж санал, дүгнэлт гарган нэгтгэж Байнгын хороонд хүргүүлэн төсөлд тусгуулсан. Шүүхийн хараат бус байдал, засаглалын тэнцвэрт байдлыг хангахад Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн бөгөөд энэхүү хуулийн төслийг хэлэлцэн батлахад Ардчилсан намын бүлэг өөрийн байр сууриа илэрхийлэн ажиллалаа.

Ардчилсан намын бүлгийн гишүүд “Шилэн дансны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Өндөр настны тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай” хуулийн төслийг хамтдаа санаачлан өргөн барьсан. Мөн Ц.Туваан болон бүлгийн гишүүд хамтдаа “Коронавируст халдвар/Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн, засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан өргөн барьсан нь УИХ-ын бусад гишүүдээс уг хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн бусад төсөлтэй нэгтгэгдэн, хэлэлцэгдэн батлагдсан юм.

УИХ-ын гишүүн Д.Ганбат “Монгол Улсын Их Хурлын /МУИХ/ тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Зөрчлийн хэрэгт шийтгэгдсэн иргэн, хуулийн этгээдэд өршөөл үзүүлэх тухай”, “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслүүд, УИХ-ын гишүүн Ш.Адьшаа “Коронавируст халдвар / Ковид-19/-ын цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэх явцад халдвар авсан төрийн албан хаагчид нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай” хуулийн төсөл, УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл боловсруулж тус тус өргөн барьсан бөгөөд зарим хуулийн төсөл намрын чуулганаар хэлэлцэн батлагджээ. Мөн УИХ-ын гишүүн Н.Ганибал “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийн төслийг УИХ-ын бусад гишүүдийн хамт санаачлан боловсруулж өргөн бариад байна. УИХ дахь Ардчилсан намын бүлэг УИХ-аар хэлэлцэж буй зарим асуудал болон төсөв, мөнгөний бодлогын төслийг хэлэлцэх, мөн Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан нийт долоон удаа санал дүгнэлт хүргүүлж, чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулан зөв зүйтэй зүйлсийг дэмжихийн зэрэгцээ алдаа, дутагдалтай асуудлуудаа засах шаардлага хүргүүлж ажилласан байна. Бүлгийн гишүүдийн зүгээс Ерөнхий сайдад болон салбарын сайд нарт салбарын хөгжил, цаг үеийн асуудлаар асуулга, асуултыг найман удаа тавьж, асуулгын хариу мэдээллийг чуулганы нэгдсэн хуралдаанд хүлээн аван сонсжээ.

Чуулганы хугацаанд бүлгийн гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах чиглэлээр УИХ-ын Тамгын газарт санал хүргүүлэн ажиллав. УИХ-аар хэлэлцэгдэж буй зарим хуулийн төслүүдээр Ардчилсан намын ҮБХ-ны дэргэдэх Бодлогын зөвлөлийн гишүүд, Ардчилсан намаас сонгогдон ажиллаж байсан үе үеийн УИХ-ын гишүүд, эрдэмтэн мэргэжилтнүүдтэй хамтран 14 хоног тутамд цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг хуулийн төсөл хэлэлцэх үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

Ардчилсан намын бүлэг Засгийн газар, Улсын онцгой комиссын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, намрын чуулганы хугацаанд нийт найман салбарын сайдыг бүлгийн хуралдаанд дуудан мэдээлэл хийлгэж, үйл ажиллагаанд нь санал дүгнэлт өгчээ. Шинэ Засгийн газрын тэргүүнийг томилох асуудлаар УИХ-ын түүхэнд анх удаа бүлэг завсарлага авч, Ерөнхий сайдад нэр дэвшигчийг хүлээн авч уулзан байр суурια илэрхийлж, шаардлагатай санал зөвлөмжийг өглөө.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг МУИХ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан өргөн барьж батлуулан, бүлгийн ажлын албаны бүтэц орон тоог нэмэгдүүлж, санхүүжилт, үйл ажиллагааны хувьд илүү чадавхжуулан, Ардчилсан намын бүлгийг тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж чадлаа.

Ардчилсан намын бүлэг ард түмний хяналтыг төрийн эрх барих, хууль тогтоох байгууллагад хэрэгжүүлж, ардчиллын үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөө, чөлөөт зах зээл, хувийн өмчийг хамгаалахын төлөө байр суурια илэрхийлэн, шударга ёсны төлөө дуу хоолой болж, УИХ болон Засгийн газрын үйл ажиллагаа, тэдгээрийн хууль хэрэгжүүлэх үйл явцад хяналт тавих үүргээ гүйцэтгэж байна. Цаашид хуулийн хэрэгжилт, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих үйл хэрэгт төрийн аудит, хяналт шалгалтын болон хууль хүчний байгууллагууд, төрийн бус байгууллагууд, салбар бүрийн шинжээч, экспертүүдийн оролцоог ханган, хамтран ажиллах болно.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг чуулганы хуралдааны ээлжит хугацаанд ажилласан үйл ажиллагааны тайлангаа эмхэтгэл хэлбэрээр нэгтгэн нийт сонгогчид, намын гишүүд, ард түмэндээ тогтмол хүргүүлж байх болно.

УИХ дахь Ардчилсан намын
бүлгийн дарга **Д.Ганбат**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

УИХ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ардчилсан намын бүлэг



Бүлгийн дарга Дашдондогийн Ганбат

Баянхонгор аймаг, гуравдугаар тойрогт нэр дэвшиж сонгогдсон. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны гишүүн.



Дэд дарга Буланы Бейсен

Баян-Өлгий аймагт, хоёрдугаар тойрогт нэр дэвшиж ялалт байгуулсан. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны гишүүн.



Дэд дарга Наянтайн Ганибал

Сүхбаатар аймаг, 12 дугаар тойрогт дэвшиж олонхийн санал авснаар УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүн.



УИХ-ын дэд дарга Салдангийн Одонтуяа

26 дугаар, тойрог буюу Баянгол дүүрэгт нэр дэвшиж хоёр дахь удаа УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны гишүүн.



УИХ-ын гишүүн Амгалангийн Адъяасүрэн

Баянхонгор аймаг, гуравдугаар тойрогт нэр дэвшин УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүн.



УИХ-ын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа

Ховд аймаг, 16 дугаар тойрогт нэр дэвшиж сонгогдсон. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны гишүүн.



УИХ-ын гишүүн Жамбын Батсуурь

Сүхбаатар аймаг, 12 дугаар тойрогт нэр дэвшиж сонгогдсон. Төрийн байгуулалтын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны гишүүн.



УИХ-ын гишүүн Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ

Өмнөговь аймаг, 11 дүгээр тойргоос УИХ-д сонгогдсон. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүн.



УИХ-ын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж

Ховд аймаг, 16 дугаар тойрогт нэр дэвшиж сонгогдсон. Төрийн байгуулалтын байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны гишүүн. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга.



УИХ-ын гишүүн Цэвэгдоржийн Туваан

Төв аймаг, 14 дүгээр тойрогт нэр дэвшиж сонгогдсон. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүн.



УИХ-ын гишүүн Одонгийн Цогтгэрэл

Увс аймаг, 15 дугаар тойрогт нэр дэвшиж сонгогдсон. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүн.

Төсөв, мөнгөний бодлого



Ардчилсан намын бүлэг төсвийг хэлэлцэх үеэс эхлэн идэвхтэй оролцож олон ажил хэрэгч санал гаргасан боловч эрх баригчид сөрөг хүчнийхээ дуу хоолойг сонссонгүй. Тиймээс УИХ дахь Ардчилсан намын бүлэг мөнгөний бодлогын алдааг эсэргүүцэж буйгаа УИХ-ын нэгдсэн чуулганы үеэр удаа дараа илэрхийллээ. Гишүүд УИХ-ын чуулганы хуралдаанд оролцохдоо “Монгол Улсын иргэн бүр 27 сая төгрөгийн өртэй”, “Тэвчиж болох зардлаа тана”, “Төрийн мөнгө гэж байхгүй, татвар төлөгчдийн мөнгө гэж л бий” гэх зэргээр эсэргүүцлээ илэрхийлсэн. Мөн төгрөгийн ханшийн уналтыг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнээр илэрхийлсэн үзвэрүүдийг УИХ-ын чуулганы хуралдааны танхимын үүдэнд дэлгэн үзүүллээ. Тухайлбал, 2016 онд нэг кг цагаан будаа 2400 төгрөг байсан бол өнөөдрийн байдлаар ийм хэмжээний мөнгөөр ердөө 0.65 кг цагаан будаа авдаг болсоныг бодитоор харуулах зорилготой. Мөн онд нэг л сүү 2176 төгрөг, тухайн өдөр дээрх мөнгөөр 0.68 литр сүү худалдан авна. Элсэн чихэр 1561 төгрөг, 2020 онд 0.52 кг элсэн чихэр буюу талыг нь худалдан авахаар байгааг эрх баригчдад энгийнээр нотлон харуулахыг зорилоо.

Ардчилсан намыг эрх барьж байх үедээ нэг ам.доллар 17 боодол нэгтийн дэвсгэрттэй тэнцэхүйц болсон гэж эрх баригчид шүүмжилж, төгрөгийн ханшийн уналтыг зогсооно гэж амлан сонгуульд ялалт байгуулж байсан. Харамсалтай нь, нэг ам.доллар аль хэдийн 29 боодол нэгтийн төгрөгтэй тэнцэх хэмжээнд ирлээ. Монгол Улсын үндэсний валют болох төгрөгийн ханш сүүлийн дөрөвхөн жилийн хугацаанд дөчин хувиар үнэгүйдэж, суларчээ. Ингэж ханшаа алдсан улс дэлхийн хаана ч байхгүй гэж Ардчилсан намын бүлэг дүгнэлээ.



Ам.долларын ханшийн чангаралтаас шалтгаалж импортын болон өргөн хэрэглээний барааны үнэ өсөв. Энэ нь иргэдийн амьдралд хүнд цохилт болж байна.



Монгол Улсын нийт гадаад өр 2020 оны байдлаар 30.8 тэрбум ам.долларт хүрсэн. Үүнийг хүн амдаа хуваавал нэг хүн 27 сая төгрөгийн өртэй гэсэн үг юм.



ОЙРЫН ГУРВАН ЖИЛД ТӨСВИЙН АЛДАГДАЛ 10 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЭХЭЭР БАЙНА

2020 оны төсөв 13 их наяд 872 тэрбум. 2021 оны төсөв бараг 14 их наяд төгрөгийн зарлагатай байхаар оруулж ирсэн нь дөрвөн жилийн өмнөхөөс даруй хоёр дахин их хэмжээнд төсвийн зарлагыг тэлсэн.

Засгийн газрын өр 7 тэрбум 891 сая ам.доллартхүрсэн. Тиймээс ядаж төсвийн алдагдлыг өр хэлбэрээр үлдээж нэмэгдүүлэхгүй байж энэ алдаагаа засах ёстой.




10 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛ


2021 оны төсвийн алдагдал 2.1 их наяд, 2022 онд 1.6 их наяд, 2023 онд 1.4 их наяд байхаар төлөвлөсөн нь 2020-2023 оны хооронд Монгол Улсын төсөв 10 их наяд төгрөгийн алдагдал хүлээхээр байна.

ИХ НАЯД 653 САЯ ТӨГРӨГ



Халамжийн бодлого хэтэрхий хавтгайрч хяналтаа алдлаа. Манай улс 2.6 сая хүнд 73 төрлийн нэг их наяд 653 сая төгрөгийн халамж өгдөг. Халамжийн бодлогоо цаашид зөв шийдвэрлэхгүй бол халамж “Ядуурлаас аврах биш ядуурал уруу түлхэх” бодлого боллоо.





Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үеийн төсөвт ул суурьтай хандах, тэвчиж болох, хойшлуулж болох зардлуудыг эрэмбэлэх, төсвийг тэлэх бус эдийн засгийг тэлэх чиглэлд бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчид, ЖДҮ эрхлэгчдээ дэмжих бодлогод түлхүү анхаарах шаардлагатай.



Хоригтой төсөв



Эрх баригчид Төсвийн тухай хуулийн олон заалтуудтай зөрчилдсөн, 2021 онд 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар боловсруулсан төслөө хүч түрэмгийлэн батлалсан. Хэдхэн сарын өмнө УИХ-ын ээлжит бус чуулганы хуралдаанаар мөн өмнөх оны төсөвт тодотгол хийхдээ мөн 4.8 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв батлаж байв.

Ийнхүү хоёр жилийн хугацаанд төсөв, санхүүгийн буруу шийдвэрийн үр дүнд Засгийн газрын өрийг 6.9 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэв. УИХ дахь Ардчилсан намын бүлэг 2020 оны арваннэгдүгээр сарын 13-нд энэ хүнд цаг үед, ард түмний эрх ашгийг эн тэргүүнд тавьж, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төслийг эцэслэн хэлэлцэх үед “Төсвийн тухай хуулийн төслийг хуулийн хугацаанд нь эцэслэн батлах үйл явцыг хялбаршуулсан горимоор хэлэлцэж, улмаар нэн даруй төсвийн тодотгол хийх” горимын санал гаргаж олонхийн саналаар дэмжигдсэн. Гэвч эрх баригчид гаргасан шийдвэрээсээ буцаж, төсвийн тухай хуулиа тодотгож алдаагаа засах ёстой байтал элдэв шалтаг тоочин хойшлуулсаар он гарч чуулган завсарлууллаа. Тухайн үед Ардчилсан намын бүлгээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан хуулиудад бүхэлд нь тавьсан хоригийг дэмжиж байсан юм. Түүнчлэн Ерөнхийлөгчийн хоригийг УИХ алдаагаа засах боломж гэж ойлгож хүлээн авах ёстой гэсэн байр суурь илэрхийлсэн.

Мөн 2021 оны төсөв нь Төсвийн тухай хуулийн 14 заалтыг зөрчиж байгааг хуульд нийцүүлэх, тэвчиж болох зардлуудыг 20 хүртэл хувиар бууруулж, “Эрсдэлийн сан”-г байгуулах, эдийн засгийг сэргээхэд зориулан 0 хувийн хүүтэй урт хугацаатай зээлийг иргэн, аж ахуйн нэгжид олгох ёстой. Түүнчлэн вакцин худалдан авах төсвийг гадаадын зээлийн хөрөнгөөр бус улсын төсөвт суулгаж шийдвэрлэх, Ерөнхийлөгчийн санаачилсан “Төрөөс өрх бүрд нэг сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ёстой гэсэн байр суурьтай байлаа.



Д.Ганбат:
Ардчилсан намын бүлэг санал хураалтад оролцохгүй

МАН-ын бүлэг хариуцлагагүй байдлаасаа болж ард түмнийг ийм байдалд оруулчихаад мөнгө байхгүй гэсэн шалтгаанаар Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсангүй. “Ухаалаг, зөв шийдвэр гаргаж ард түмнээ авч яваа улс орон олон байна. Та бүхэн удирдаж байгаа цагт Монгол Улс тэдгээр орны тоонд багтахгүй бололтой. Ийм хариуцлагагүй зүйлд Ардчилсан намын бүлгийн гишүүд оролцохгүй” гэдгээ бүлгийн дарга Д.Ганбат хэлж санал хураалтыг орхин гарав.



Ш.Адьшаа:
Иргэний зориг гарган хоригийг хүлээж авъя

Ерөнхийлөгчийн хоригийг дэмжих шаардлагатай. Энэ бол Монгол Улсын 897424 өрхийг нийтэд нь дэмжих бодлого. 800 мянган төгрөгийн эрхийн бичгээр үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж, ажилгүй болсон иргэнээ өрхөөр нь дамжуулан дэмжих санаа юм. Ийм туршлагыг амжилттай хэрэгжүүлсэн улс орон олон байна. Засгийн газраас хүүхдийн мөнгөөр дамжуулан өрх бүрийг дэмжиж байгаа гэдэг. Гэтэл хүүхэдтэй 541 мянган, хүүхэдгүй 366400 өрх байна. Өрх толгойлсон 34 орчим мянган, өдрийн орлогоороо амьдардаг 180 мянган өрх байдаг гэсэн судалгаа байна. Нийт өрхийн чинь 40 хувь нь хүүхэдгүй байхад өрх бүрийг хүүхдийн мөнгөөр дэмжиж байгаа гэж ярихаа болих хэрэгтэй.



Ж.Батсуурь:
Сонгуулийн өмнө хүсээгүй байхад мөнгө тараагаад байсан. Гэтэл одоо зайлшгүй шаардлага тулгарлаа

Ерөнхийлөгчийн “Өрх бүрт нэг сая төгрөг өгөх” санаачилгыг улс төржилт гээд байх юм. Гэтэл эрх баригчид сонгуулийн өмнө хүсээгүй байхад нь мөнгө тараагаад байсан биш үү. Сүүлийн үед өдрийн орлогоороо амьдардаг иргэд тэвдэж байна. Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас, тэвдэж явахад тэвнээр тусла гэдэг. Энэ үед нь төр туслах үүрэгтэй. Нөхцөл байдлыг хурдан шийдье гэвэл Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах ёстой.



О.Цогтгэрэл:
2021 оны төсөв сууриараа буруу болсон

Төсөв боловсруулж байхад “Угтан ирж байгаа нөхцөл байдалд тохироогүй төсөв боллоо” гэдгийг би сануулсан. Бодит эдийн засаг есдүгээр сарын 30-ны байдлаар долоо орчим хувь буурсан байсан. Гэтэл эдийн засагт сэргэлт ажиглагдаж байгаа гэсэн дүгнэлт дээр үндэслэн төсвийг боловсруулсан гэж тайлбарлаж байв. 2021 оны төсөв сууриараа буруу болсон. Тиймээс Ерөнхийлөгчийн хоригийг алдаагаа засах боломж гэж үзэж хүлээж авах хэрэгтэй. 2021 оны төсөвт 800 тэрбумын санхүүжилттэй 457 шинэ ажил хийхээр тусгасан. Үүнийг одоо засаад явахгүй бол төсвийн тодотголоор засах боломжгүй. Учир нь аль хэзээний эдгээр ажил эхэлчихсэн, урьдчилгаагаа төлж ажлын гэрээгээ хийчихсэн байна. Энэ нь төсөв боловсруулагчдын заль ч байж магадгүй учраас хоригийг хүлээж авах бас нэг үндэслэл мөн.



Н.Ганибал:
Ерөнхийлөгчийн хориг цагаа олсон зөв бодлого


Ерөнхийлөгчийн хориг тавьж байгааг улс төржүүлж байгаад харамсаж байна. Бид бодит нөхцөл байдлаа дүгнэж, зөв төлөвлөж зайлшгүй арга хэмжээгээ яаралтай авах ёстой. Бусад улс орнууд аж ахуйн нэгжээ дэмжсээр байна. Үүнтэй ижил Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг бол цагаа олсон зөв асуудал.



Ц.Туваан: Иргэддээ дэмжлэг үзүүлэх асуудлыг яагаад хэн ч ярихгүй байгаа юм

Ерөнхийлөгчийн “Өрх бүрт сая төгрөг өгөх” саналыг улс төр, сонгууль гэж хараад байгаа бол та нар өөрсдөө оруулж ир л дээ. Яагаад айл өрхүүдэдээ дэмжлэг үзүүлэх асуудлыг хэн ч ярихгүй байгаа юм бэ. Засгийн газарт 5.1 их наяд төгрөгийг зарцуулах онцгой их эрхийг УИХ-аас өгсөн. Гэтэл гаднын зээл тусламжийг хэрхэн зарцуулснаа маш тодорхойгүй тайлбарлаж байна. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга аа, Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сангийн мөнгө байна уу. Энэ 5.1 их наяд төгрөгийн зарцуулалттай хамт дуусчихсан уу.

Ковидын үеийн сөрөг хүчин



Монгол Улс 2020 оны арваннэгдүгээр сарын 11-нд коронавирусний халдварыг дотооддоо алдсан түгшүүрт мэдээг зарлаж хатуу хөл хорио тогтоосон. УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд нөхцөл байдалд тохируулан бүлгийн хуралдаанаа цахимаар зохион байгуулж ажиллав. Түүнчлэн эрх баригчдын зүгээс авч хэрэгжүүлж буй бодлогын алдааг хэлж шүүмлэхээс гадна хамтран ажиллаж цар тахлын хүнд үеийг хамтдаа даван туулахыг хичээн ажиллаж байна.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлд дүгнэлт хийж зөвлөмж хүргүүлэн, цар тахалтай тэмцэхдээ хүний эрхийг хамгаалах, хангах асуудалд онцгой анхаарахыг удаа дараа сануулж байв. Ардчилсан намын бүлэг Засгийн газар, Улсын онцгой комиссын ажлыг урьдчилсан бэлтгэлгүй, стратеги төлөвлөгөөгүй, хангалтгүй гэж үзэж 17 зүйл заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулан өргөн барьж 2021 оны нэгдүгээр сард багтааж УИХ-аар эцэслэн батлуулав. Мөн УИХ дахь Ардчилсан намын бүлэг цар тахалтай тэмцэх ажилд хариуцлага алдаж эрдэнэт хүний ам нас эндэх хэмжээнд удаа дараа алдаа гаргасан УОК, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн онцгой комиисын удирдлагатай хариуцлага тооцож, огцруулах хүртэл арга хэмжээ авахыг Засгийн газрын тэргүүнээс шаардан, хариуцлага тооцуулж ажиллав.

Шадар сайдад зөвлөмж хүргүүлэв



Вирусний тархалтыг дотооддоо алдсанаас хойшхи хугацаанд халдварыг илрүүлэх, тархалтыг зогсоох чиглэлд Засгийн газар, Улсын онцгой комисс шаардлага хангахуйц ажиллаж чадаагүй. Тухайлбал, орон нутгийн иргэдээс шинжилгээ авах, тэднийг буцаах, нөөцийн махны худалдаа явуулахдаа зохион байгуулалтын алдаа гаргаж иргэдийг чирэгдүүлэх, бөөгнөрөл үүсгэх, халдвар тарах нөхцлийг өөрсдөө бүрдүүлж байсан зэргээс дүгнэж болно. Тиймээс цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа тусгах зөвлөмж боловсруулж бүлгийн дарга Д.Ганбат, бүлгийн дэд дарга Н.Ганибал, УИХ-ын гишүүн Ц.Туваан нар Шадар сайд Я.Содбаатарт 2020.12.2-ны өдөр хүлээлгэн өгөв. Зөвлөмжид, чанаргүй зээлийг худалдан авах зэргээр санхүүгийн оновчтой бодлого боловсруулах, хот суурин газарт эмзэг бүлгийн айл өрхүүдийг түлшээр үнэ төлбөргүй хангах асуудлыг тусгасан. Мөн хот хооронд зорчих иргэдийн шинжилгээ, хяналтад улсын болон орон нутгийн Онцгой комисс уялдаатай ажиллах, цар тахлын голомт, эрсдэлтэй бүст ажиллагсадыг халдварт өртөхөөс сэргийлэх, экспортын гол түүхий эдийн олборлолт, тээвэрлэлт, тэнд ажиллаж буй ажилтан, жолооч нарын эрүүл мэндийг хамгаалах тусгайлсан арга хэмжээ авч ажиллахыг сануулав. Мөн түүнчлэн ямар ч нөхцөл байдал үүссэн хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх зэргийг үйл ажиллагаандаа анхаарах нь зүйтэй гэв.

Цахилгаан эрчим хүчний шинэ эх үүсвэрээ нэм!



Засгийн газраас цахилгааны үнийг тэглэх шийдвэр гаргаснаас хойш хэрэглээ огцом нэмэгдэж ачаалал 1300 МВт хүрвэл эрчим хүчийг хэсэгчлэн хязгаарлахаас аргагүйд хүрэхээр нөхцөл байдал үүссэн. Хэт их ачааллаас хамааран, ТЭЦ-IV-ийн нэг эх үүсвэрт гэмтэл гарлаа гэхэд 15 аймаг цахилгаангүй болох эрсдэлтэй байгаа. Тиймээс цахилгааны эх үүсвэрээ яаралтай өргөтгөх, цаашдаа өндөр хүчин чадал бүхий цахилгаан станц барих шаардлагатай гэж УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд байр сууриа илэрхийлэв.



Д.Ганбат:
Дандаа олонхийн зөв байдаггүй

Монгол хүний амь нас, эрүүл мэнд яригдаж байгаа энэ нөхцөлд та бүхэн алдах эрхгүй хүмүүс. Тиймээс шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргаж, шийдвэртээ бат зогсдог баймаар байна. Хариуцлагүй байдлаас халдварыг дотроо алдсан албан тушаалтнуудын өмнөөс би иргэдээсээ уучлал хүссэн. Та нар хэзээ уучлал гуйх гэж байна вэ. Эсвэл шаардлагагүй гэж үздэг юм уу. Миний хувьд улс орныг ийм нөхцөл байдалд оруулсан буруутнууд бол та нар гэж бодож байна. УИХ дахь Ардчилсан намын бүлэг эрх баригчдад 14 зүйлийг тусгасан шаардлага хүргүүлсэн. Олонхи эх орныхоо эрх ашгийг нэн тэргүүнд тавьж бидний шаардлагыг цаг тухайд нь анхаарч ажилдаа тусгаад явсан бол ийм байдалд хүрэхгүй ч байх магадлалтай байлаа. Дандаа олонхийн зөв байдаггүй. Ийм нөхцөл байдалд сөрөг хүчний үгийг сонсож байх хэрэгтэй.



Ш.Адьшаа:
Зээл, зээлийг хүүг хойшлуулах ажил хэрэгжихгүй байна

Зээлийн үндсэн төлбөр, хүүг хойшлуулах асуудал одоо ч бүрэн утгаараа хэрэгжихгүй байгаа талаар иргэдээс гомдол их ирж байна. Үүнд арилжааны банкуудад төр төмөр нүүрээ яагаад гаргаж болдоггүй юм бэ. Онцгой байдлын энэ үед тал зассан шийдвэр гаргаж болохгүй.



О.Цогтгэрэл:
Эдийн засгийн “хугарлын цэг”-ээ тодорхойлъё

Хөл хорио, ковид-19 цаашид хэр удаан, хэрхэн үргэлжлэхийг бид мэдэхгүй. Тэгэхээр жижиг дунд бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжүүдийн байдал цаашид улам хүндэрнэ. Аливаа байгууллага эдийн засгийн хугарлын цэгээ тооцож дүгнэж ажилладаг. Улсын онцгой комиссын хувьд улсынхаа эдийн засгийн хугарлын цэгийг хаана хүрээд цааш үргэлжлэх боломжгүй болно гэж үзэж байна вэ. Хугарлын цэгээ тодорхойлж түүндээ тохирсон арга хэмжээ авах шаардлагатай.



Б.Пүрэвдорж:
Одоо л үнэт цаас бонд гаргаж эдийн засгаа дэмжих үе

Тодорхой арга хэмжээ яаралтай авахгүй бол ковидоос хамаарч эдийн засгийн хямрал боллоо. Одоо яг үнэт цаас гаргадаг цаг нь юм. Монголбанк яг энэ хүнд хэцүү үед үнэт цаас эсвэл бондоо гаргаад аж ахуйн нэгжүүдээ дэмжих санхүүгийн эх үүсвэр босгох, муу зээлийг нь худалдаж авахад зарцуулж ажиллах ёстой.

Үйл явдлын мэдээ

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалттай танилцлаа



Тавантолгой-Зүүнбаян чиглэлд нийт 414.6 км төмөр зам барих бөгөөд гишүүд орон нутагт очиж ажлын явцтай танилцах үед /2020.10.25/ 166.93 км-ыг нь бүрэн угсарч, үлдсэн хэсгийн газар шорооны болон хоолойн ажил бараг дуусч байв. Өртөөний барилга 63 орчим хувийн гүйцэтгэлтэй бол зөрлөгийн барилгын ажил ч дуусах тун дөхжээ. Энэхүү бүтээн байгуулалтад “Тавантолгой төмөр зам” компани захиалагчийн хяналт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байгаа бол 6153 хүн, 2871 техник, 104 аж ахуй нэгж хамтран ажиллажээ. Коронавируст цар тахалтай холбоотой онцгой дэглэмтэй холбоотой гүүрийн ажлыг зуун хувь дотоодын компаниуд гүйцэтгэснээрээ онцлог байв.

Тус чиглэлийн төмөр зам баригдаж, ашиглалтад орсноор жилдээ 30 сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрсийг тээвэрлэн экспортлох боломжтой болно. Ингэснээр Тавантолгой бүлэг орд орчмын уурхайн олборлолтын хэмжээ 2-3 дахин нэмэгдэнэ гэж тооцоолжээ. УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд төмөр замын бүтээн байгуулалтад гар бие оролцож байгаа баг, хамт олонд амжилт хүсч, түүх бүтээж байгаад нь талархал илэрхийлж, урам нэмлээ.

Ардчилсан намын бүлгийн гишүүд Дэлхийн банкны төлөөлөлтэй уулзав



УИХ дахь Ардчилсан намын бүлгийн урилгаар Дэлхийн банкны төлөөлөгчид Төсөв, мөнгөний бодлогын асуудлаар бүлгийн гишүүдтэй уулзалт хийж, санал солилцов.

УИХ-ын дэд дарга С.Одонтуяа: Дэлхийн банк Монгол Улсад байнга тусалж, олон төрлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг, мөн цар тахлын хүнд үед санхүүгийн өгөөмөр дэмжлэг үзүүлсэнд Монголын ард түмнийг төлөөлөн талархаж байна.

УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж: “Манай улсад ядуурал төдийлөн буурахгүй байгаа нь Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ төдийлэн оновчтой бус байгаатай холбоотой.

Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Андрей Михнев:

“Олон улсад ажлын байрыг шинээр бий болгох, иргэдэд бизнес эрхлэх боломжийг олгох замаар ядуурлыг шийддэг”.

Дарханчуудын сонгох, сонгогдох эрхийг хангахын төлөө ажиллав



УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд Дархан-Уул аймгийн ИТХ-ын сонгуульд тус намыг бүртгээгүй асуудлаар мэдээлэл хийлээ. /2020.10.06/

Дархан-Уул аймгийн Ардчилсан нам 2020 оны ИТХ-ын сонгуульд оролцож чадаагүй. Учир нь Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газар сонгуулийн дансыг нь баталгаажуулж өгөөгүй.

Дарханчууд сонгох, сонгогдох эрхээ эдэлж чадахгүйд хүрч буйг эсэргүүцэж, тэдний гаргасан гомдлыг Ерөнхийлөгчид хүргүүлэв.



Баялгаа бүтнээр нь авч үлдсэнд талархах ёстой

Ерөнхий сайд айл өрхийн хэрэглээний зарим төлбөрийг тухайлбал цахилгаан, дулаан, усны мөнгийг Эрдэнэт үйлдвэрийн орлогоос төлүүлэх шийдвэр гаргасан. Тус шийдвэртэй холбоотой үүсч болох эрсдэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар Ардчилсан намын бүлэг хэлэлцэв. Энэ үеэр Ардчилсан нам засгийн эрхийг барьж байх үедээ Эрдэнэтийн 49 хувийг монголдоо авах шийдвэрийг гаргаж байсан. Үүний үр дүнг өнөөдөр нийтээрээ хүртэж байна. Баялгаа эх орондоо үлдээж, үр шимийг нь хүртэх боломж гаргасан тухайн үеийн Ерөнхий сайд, ардчилсан намын гишүүд өнөөдөр буруутан болж байгаад харамсаж байгаагаа илэрхийллээ.


Ардчилсан намын бүлэг намын гишүүддээ хандан уриалга гаргав

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд хууль тогтоох, сөрөг хүчний үндсэн үүргээс гадна Ардчилсан намаа дэмжин, гишүүдтэйгээ хамтран ажилладаг. Энэ хүрээнд намын Их хурлын өмнө гишүүддээ хандан уриалга гаргав. Уриалгад,

“Улсын Их Хурлын сүүлийн хоёр удаагийн сонгуульд амжилтгүй оролцсон нөхцөл байдалдаа дүгнэлт хийж, намын дүрмээ өөрчлөн шинэчлэх, үйл ажиллагаагаа сайжруулах үүднээс дүрмийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан дүрмийн төсөлд гишүүдээс санал авч тусган Үндэсний бодлогын хороогоор 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хэлэлцүүлэн, улмаар 12 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд товлогдсон намын Их хурлаар эцэслэн батлахаар бэлтгэл ажлыг хангасан байна. Энэхүү эрсдэлтэй хүнд цаг үед улс төрийн намуудаас анхдагч нь болж цахимаар Их хурлаа зохион байгуулж үлгэр жишээ үзүүлж байгаа нь Ардчилсан намын нийгмийн хариуцлагын тод илэрхийлэл болно.

Ардчилсан намын гишүүд бид коронавируст халдварт цар тахлын үеийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг тогтоосон хөл хорионы энэ цаг үед танхимд цуглаж Үндэсний бодлогын хорооны хурал болоод намын Их хурлыг зохион байгуулах боломжгүй байгааг харгалзан, мэдээллийн технологийн шийдлийг ашиглан хурлаа зохион байгуулан, намын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах цаашдын үйл ажиллагаагаа цаг алдалгүй сайжруулах шаардлагатай цаг үед ирээд байна. Иймд Үндэсний бодлогын хорооны гишүүдийг хуралдаандаа идэвхтэй оролцон намын дүрмийг хэлэлцэх, мөн анхан, дунд шатны намын байгууллагуудыг бүх шатандаа санаачилга гарган, Их хурлын төлөөлөгчдийг хуралдаандаа цахимаар оролцох боломжоор ханган, ажиллахыг уриалж байна”.

Тэтгэврийн доод хэмжээг 500 мянган төгрөг болгохыг зорив



Өнөөдөр 441 мянган иргэн тэтгэвэр авч байгаагаас бараг 300 мянга гаруй ахмад 500 мянгаас доош төгрөгийн тэтгэвэр авдаг. Гэтэл өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өдөр хоногоор өсч буй. Энэхүү нөхцөл байдал ахмад настнуудын амьжиргаанд хүндээр тусах болсон. Иймд ахмадуудын амьдралын чанарыг бага боловч сайжруулахын тулд тэтгэврийн доод хэмжээг 500 мянган төгрөг болгох хуулийн төслийг Ардчилсан намын бүлгийн гишүүд боловсруулж өргөн барив.

Тэтгэврийн 500 мянгаас доош орлого амьжиргаанд хаанаа ч хүрэлцэхгүй мөнгө. Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгаагаар нэг өрхийн дундаж зарлага 1.5 сая төгрөг гэж тооцоолсон. Тэгэхээр хоёр ахмад нийлээд тэтгэврийн мөнгөөрөө амьжиргааны өртгийн гуравны нэгийг ч бүрдүүлж чадахгүй хэмжээнд хүрсэн. Энэ нь өндөр настнуудыг ядууралд хүргэж байгаа том шалтгаан. Байгалийн нөөцөөр баян орон атал ахмадуудаа ядуу амьдруулж болохгүй гэж тэд хуулийн төсөл санаачлагчид үзэж буй.

Шилэн дансны тухай хуулийг “шилэн” болгоно

Шилэн дансны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл өргөн барив. Энэхүү хуулийг анх Ардчилсан нам эрх барьж байх үедээ санаачлан өргөн барьж УИХ-аар 2014 оны долоодугаар сарын 1-ний өдөр баталж, 2015 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Гэвч хууль хэрэгжих явцад шилэн данс хөтлөхгүй байх эсвэл буруу, худлаа хөтлөх, шилэн дансанд мэдээлснээ засах, илэрхий зөрчил гаргасан ч хариуцлага хүлээхгүй байх зэрэг асуудал гарч байна.

Тиймээс одоо мөрдөж байгаа хуулиар төсвийн хөрөнгөөс 5 сая төгрөгөөс дээш хийсэн гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлнэ гэснийг 1 сая төгрөг болгон бууруулах, зөрчил гаргасан албан тушаалтанд тооцох хариуцлагыг тодорхой болгож, хуулийн хэрэгжилтийг илүү үр дүнтэй байхаар төсөлд тусгав.

Ямар ч хүндрэл бэрхшээлийн үед төр иргэнийхээ эрхийг зөрчих эрхгүй

Ардчилсан намын бүлэг Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулав. Хуулийн төслийн гол зорилго хувь хүний эрхийг хуулиар баталгаажуулж өгөх юм. Үүнд,

- Гадаадаас буцах хүсэлт гаргасан иргэдийн эх орондоо ирэх, улсын хилээр нэвтрэх үндсэн эрхийг баталгаатай болгох,
- Короновирусний халдвар авч өвчилсөн иргэдийн хувийн мэдээллийг нууцлах,
- Ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг үндсэн болон хүүгийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хойшлуулах, зээлийн гэрээг сунгах,
- Өмчийн хэлбэр үл харгалзан сургалтын төлбөрөөс гадна дотуур байрны төлбөрийг хойшлуулах, дараагийн төлбөрт шилжүүлэх,
- Хатуу хөл хорионы үеэр иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулах,
- Үндэсний цахим мэдээллийн сан бүрдүүлэх, гаднын зээл тусламжийг Засгийн газар тусгай сан байгуулан байршуулж Тусгай сангийн тухай хуулийн дагуу зарцуулж ашигладаг байх заалтуудыг тусгав.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар УИХ-ын гишүүдээс 4 өөр төслийг санаачлан өргөн барьсныг хэлэлцүүлгийн явцад нэгтгэн хэлэлцэж 2021 оны нэгдүгээр сарын 29-ний өдөр эцэслэн батлав.

Хэлэлцүүлгийн явцад УИХ-ын гишүүдээс зарчмын зөрүүтэй саналууд гаргаж УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдийн өргөн барьсан хуулийн төслийн зарим заалт хасагдсан ч голлох заалтууд батлагдснаар хуульд тусгалаа олж хэрэгжих боллоо.

Цар тахалтай тэмцэх амаргүй хүнд үед хуулийн үйлчлэх хүрээг тэлэх зорилгоор өөрчлөлт оруулж, улмаар хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахаа сөрөг хүчний зүгээс илэрхийлж ажиллав.

“Нэгжийн” тухай хуулийн шинэчилсэн найруулга



Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шинэчлэхээр өргөн барьсан Монголы улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг намрын чуулганаар хэлэлцэн баталлаа. Аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Иргэдийн хурлын төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн тодруулж, Ерөнхий сайдад санал болгон батламжилдаг байсан. Хуулийн өөрчлөлтөөр аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд Иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал болгоно. Аймаг, нийслэлийн Засаг дарга хамтран ажиллах сум, дүүргийн Засаг даргаа харьяа Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаа санал болгосноор томилно гэж тусгасан юм.

Хэлэлцэх явцад УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, тус хуулийн төсөлд Монгол Улсын тусгаар тогтнолыг алдагдахад хүргэх гурван заалт байна. Энэ заалтууд батлагдвал би Үндсэн хуулийн Цэцэд хандах болно гэв. Тэрээр орон нутгийн эдийн засаг, бусад эрх мэдлийг дагасан улс төрийн босоо удирдлагын тогтолцоо үүсгэж байна хэмээн эсэргүүцлээ илэрхийлэв.

УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл, Ерөнхий сайд аймгийн Засаг даргыг томилохгүй шалтгаанаа тайлбарлах ёстой. Тухайлбал Ерөнхий сайд Увс аймгийн Засаг даргад нэр дэвшигчийг “Дэмжих боломжгүй” гэсэн ганцхан өгүүлбэр бичээд буцаасан. Ядаж нутгийн иргэд нь ямар зүйл заалтаар буцаагдаж байна гэдгийг мэдэх эрхтэй. Тиймээс дэмжихгүй шалтгаанаа тайлбарладаг байх заалт оруулах ёстой гэв. Харин УИХ-ын гишүүн Н.Ганибал, бага Үндсэн хууль гэгдэх Засаг захиргаа, нэгжийн тухай хуульд ардчиллын зарчмаасаа ухарсан заалтууд оруулаа. Төсөлд Ерөнхий сайд томилох хүнээ өөрөө санал болгох заалт оруулж ирсэн нь ардчилсан ёсны гол зарчмыг зөрчсөн. Шууд утгаараа Намын төв хороо аймгийн Засаг даргаа томилж байсан коммунизмын үе рүүгээ ухарлаа. МАН олонхи байхдаа баталсан энэ заалтынхаа хохирогч болно. УИХ-ын гишүүн Ш.Адьшаа энэ удаагийн хуулийн өөрчлөлтөөр 30 жилийн турш хуримтлагдсан орон нутгийн засаг захиргаа, улс төрийн намууд, иргэдийн дунд үүссэн улс төржилтийг

шийдэх хэмжээний цогц бодлого оруулах ёстой байлаа. Гэтэл дээд шатны болон Ерөнхий сайд Засаг даргыг санал болгож болно гэх мэтийн Үндсэн хуулийн зөрчилтэй заалтууд оржээ. Үүнээс гадна орон нутагт улс төржилт хэрээс хэтэрсэн. Хэн олон ах дүүтэй нь хурлын төлөөлөгч болдог. Тэр нь намаараа дамжуулж хувийн амьдралаа зохицуулдаг байдал газар авсан. Үүнд цэг тавих хууль болж чадсангүй гэж дүгнэсэн. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл, орон нутагт бие даасан байдлыг олгох нь зөв. Гэхдээ эрх мэдэл шилжихийн зэрэгцээ үүрэг хариуцлага, чадамж нь нэмэгдэх ёстой. Цаашид засаг захиргааны бүтцийн хувьд нэгдэн нийлэх, илүү томрох, эрх ашгаа нэгтгэх нь чухал. Ядаж засаг захиргаа тусдаа нутаг дэвсгэр, эдийн засгийн бүсчлэлээр нэгдэх хэрэгтэй гэлээ. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсантай холбоотой Ерөнхийлөгч Х.Баттулга хэд хэдэн заалтад хориг тавив. Хоригийг УИХ-ын чуулганаар хэлэлцээд 56.8, 56.5.1 дэхь заалтад тавьсан хоригийг хүлээн авахаар /2021.01.28/ шийдэв.



Н.Ганибал:
Ашиг сонирхлын зөрчилтэй хүнийг хууль батлалцахад оролцуулахгүй байхыг ярих цаг болсон

1990-ээд оны эхэн үеийн Их хурлаас эх оронч, ардчилсан, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргадаг байжээ. Тэр үед монголын ард түмэн ижил гараанаас мэдлэг чадвар, хөрөнгө мөнгө ижил гарч байсан байх. Өнөөдөр тухайн цаг үеийг бодоход үндэсний хөрөнгөтөн, бизнесмэнүүдтэй, уул уурхайн эзэд, олигархи оффшорчидтой ч болж. Засгийн газрыг огцруулдаг далдын хүчтэй ч болов. Үүнийг яагаад тодруулж хэлээд байна гэхээр бэлчээр, газрын тухай ярихаар далдын хүч үйлчлээд эхэлсэн. Эх оронч үзэлд нөлөөлөл орж ирээд байна. 65.1.3 гэсэн энэ заалтад ч далдын хүч оржээ. Тиймээс энэ хоригийг хүлээж авах нь эх орон иргэдийнхээ төлөө заавал хийх үйлдэл шүү. Цаашид эрх ашгийн зөрчилтэй хүнийг хууль батлалцахад оруулахгүй байх асуудлыг сөхөж яриг цаг болсон.



Ц.Туваан:
Иргэдийн сонголт руу шууд халдаж байна

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад эрх мэдлийг үлдээ л дээ. Системтэй дайраад байх юм. Засаг даргыг томилох асуудалд Ерөнхийлөгч хориг тавьж түүнийг нь хүлээгээд авах нь гээд харж суутал, огцруулах асуудлыг нь хэвээр үлдээж байх жишээтэй. Засаг дарга нарыг ажлыг нь хийлгэмээр байна. Засаг дарга дүүрч гэхэд иргэдийн сонголт руу шууд халдаж байна. Иргэд нь саналаа өгөөд байгуулсан ИТХ-ыг 60 хоног хуралдаагүй бол тарсанд тооцно гэнэ. Үүнийг эргэж хараач ээ. Газар нутгийг тусгай хамгаалалтад авах дор юм нуугаад байна. Одоо үүний дараа иргэдийн санал ИТХ-ын саналгүйгээр уул уурхайн лицензтэй холбоотой асуудал босоод ирнэ. Үүнийг чинь бид мэдэж байна. Уул уурхайн лицензтэй холбоотой ухсан газар хөдөөгүүр их байгаа.



Б.Пүрэвдорж:
Сонгох, сонгогдох эрхэд халдаж болохгүй

Малчид, орон нутагт амьдарч буй иргэд ээ. Та бүхний эдэлж байсан маш олон эрх энэ хуулиар байхгүй боллоо. Тухайлбал, Багийг хооронд нь нийлүүлэх эрхийг аймгийн ИТХ мэддэг болох нь. Сумын иргэд дэмжсэн эсэхээс үл шалтгаалан аймгаас шийдвэрлэх боломжтой болж байна.

1. Сум хоорондын хилийн заагийг шийдвэрлэх асуудлыг аймаг, Засгийн газар мэдэлдээ авсан. Өмнө нь сумын ИТХ-аар шийдвэрлэдэг байсныг болиуллаа. Одоо үүнээс шалтгаалан малчдын өвөлжөө, хаваржааны бөөн маргаан үүснэ.
2. Байгалийн баялагт шунасан этгээдүүдээс газар нутгаа хамгаалах үүргийг сумын ИТХ гүйцэтгэдэг. Гэтэл одоо энэ эрхийг хасаж ашигт малтмалын газраас дураараа лиценз олгодог болно.
3. Байгаль орчинд хортой үйл ажиллагаа явуулсан бол сумын ИТХ тодорхой арга хэмжээ авдаг байсан. Гэтэл төрийн эрх гэдгээр дээш нь татаж сумаас арга хэмжээ авах боломжгүй болгож байна.
4. Ашигт малтмалын лиценз авахдаа багийн иргэд сумын ИТХ-аас зөвшөөрөл авдаг байсныг болиуллаа. Тун удахгүй алт ухсан хүмүүс газар нутгийг чинь ухаж эхэлнэ гэсэн үг.
5. Сумын ИТХ-ын гуравны нэг нь төрийн алба хашиж болох заалт оруулсан боловч МАН хассан. Сумын иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон хүмүүс ажил хийхгүйгээр МАН-ын сонгуульд л ажиллаж болох нь.
6. Сумын ИТХ-ын төлөөлөгчийг тодорхойгүй саналаар татах боломжтой болж байна. Сумын Засаг дарга, намын даргад таалагдахгүй л бол ямар ч үндэслэлгүйгээр татах нь. Сонгох, сонгогдох эрхэд халдаж болохгүй.
7. Сумын Засаг дарга төрийн хүн биш төрийн үйл хэргийг гэрээгээр төлөөлүүлэн хийдэг хүн болж байна. Ингэснээр нутгийн өөрөө удирдах ёсонд маш бүдүүлгээр халдлаа. Сум дахь төрийн үйл ажиллагааг саармагжуулсан хууль баталж байна.



О.Цогтгэрэл:
Бүхлээрээ ухралт болсон хууль болсон, тиймээс Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зөв

Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хууль бол их чухал хууль. Зарим нэг дэвшил байгаа ч бүхлээрээ ухралт болсон. Хуулийн гол үзэл баримтлал болох монголын хөдөө, орчин үеийн зах зээлийн эдийн засаг хоёр огтлолцохгүй байгааг шийдвэрлээгүй. Орчин үеийн зах зээлийн эдийн засаг төвлөрөл, масс үйлдвэрлэл, өртөг зардлын хямдралыг шаарддаг. Нүүдлийн мал аж ахуй, уламжлалт соёлтойгоо зөрчилдөөд байна. Энэ хуулиар гарц гаргалгаа гаргаагүй. Зөвхөн удирдлагыг хэн, хэрхэн томилохыг ярьсан. Орон нутгийн бие даасан байдлыг хангана гэж байгаа ч улс төрийн бие даасан байдал уу, эдийн засгийн бие даасан байдал уу гэдэг хоёр өөр.

Хариуцлага

Ардчилсан намын бүлэг Я.Содбаатар, Д.Сумьяабазар, Т.Мөнхсайхан нарыг огцруулахыг шаардав



Коронавирусны халдвар авсан нь шинжилгээгээр илэрсэн дөнгөж амаржсан эх, нярай хоёрыг “Өргөө” амаржих газраас ХӨСҮТ-рүү шилжүүлэхдээ /2021.01.19/ өвлийн хүйтэнд гадуур хувцасгүй гэрийн шаахайтай нь зөөвөрлөсөн. Энэ үйлдэл нь иргэдийн бухимдлыг төрүүлж маргааш нь буюу нэгдүгээр сарын 20-нд Чингисийн талбайд иргэд жагсав. УИХ дахь Ардчилсан намын бүлэг иргэдийг дэмжиж, тэдэнтэй санал нийлж байгаагаа талбай дээр гарч илэрхийлсэн. Түүнчлэн ажилдаа удаа дараа хариуцлагагүй, сэтгэлгүй хандсан Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, нийслэлийн онцгой комиссын дарга Д.Сумьяабазар, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарыг огцруулахыг шаардаж Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд шаардлага хүргүүлэв. Шаардлагад “Үндсэн хуульд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулна хэмээн заасаар байтал коронавирусын халдварт цар тахлын эсрэг Засгийн Газар, Улсын онцгой комиссоос өнгөрсөн нэг жилийн хугацаанд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь зохион байгуулалтгүй, иргэн, ард түмнээ гэсэн сэтгэлгүй, хүмүүнлэг бус байна. УИХ дахь Ардчилсан намын бүлэг удаа дараа санал, шаардлага хүргүүлж, Засгийн газар цар тахалтай тэмцэх бүх нийтийн хөл хорионы үеэр хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, авч хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээ нь хуулийн дагуу, хүмүүнлэг, үр дүнтэй байх ёстойг сануулсаар ирсэн ч сайд, дарга нарын хариуцлагагүй үйлдлийн улмаас эрдэнэт хүний амь нас үрэгдэж, иргэддээ хандах хүнлэг ёс гээгдсээр байна” гэж онцолж холбогдох албан тушаалтнуудыг огцруулахгүй бол УИХ тарах хүртэлх арга хэмжээг авна гэдгээ илэрхийллээ. Гэвч Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох улс төрийн шийдвэр гаргаж, Л.Оюун-Эрдэнийг Ерөнхий сайдад дэвшүүлж, томилсон юм.



Д.Ганбат:
Энэ Засгийн газар коронавируст ялагдлаа

У.Хүрэлсүх та хариуцлага хүлээж огцорч байна уу, хариуцлагаас зугтав уу.

Ардчилсан намын бүлгээс ажилдаа хариуцлагагүй, хүнлэг бус хандсан, Монгол Улсын иргэдийг амь нас, эрүүл мэндээрээ хохирох нөхцөлд оруулсан Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан болон нийслэлийн Онцгой комиссын дарга бөгөөд нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт хариуцлага тооцож, нэн даруй огцруулахыг шаардаж байна гэж нэр цохон хэлсэн. Гэтэл Ерөнхий сайд та эдгээр хүмүүстээ хариуцлага тооцохгүйгээр, монголын ард түмнээ бодолгүй Засгийн газраа огцруулж засаглалын дутагдалд оруулаа.



С.Одонтуяа:
МАН-ын дотоод тэмцэл дээд цэгтээ хүрч цуврал жүжиг тавьж байна

Бүх зүйлд Ардчилсан нам буруутай болж байгаад гайхаж байна. Сүүлийн хоёр парламентад дараалан МАН 62-65 гишүүнтэй байсан. Гэтэл эдийн засгийн асуудалд Ардчилсан намыг буруутгадаг. Одоо бүр Ерөнхийлөгчийн буруу болж байна.

Энэ бүхэн урдаас төлөвлөсөн жүжиг. Солонгос кино шиг цаашдаа ч олон анги гарна. Үүнд Ерөнхийлөгч болон Ардчилсан нам буруугүй. Монгол Улсын стратегийн ордын төлөөх тэмцэл, эрчүүд эзэгнэсэн улс төрийн өмнөх хойдох өшөө авалт, албан тушаалын тэмцэл бүхэн эцэстээ тулсаны илрэл.



Б.Пүрэвдорж:
У.Хүрэлсүх ерөнхийлөгч болох гэж хариуцлагаас зугтаж байна

Ерөнхий сайд У.Хүрэлсүх огцорч байна. Үүнтэй зэрэгцээд УИХ тарах ёстой. Яагаад гэвэл У.Хүрэлсүхийн Засгийн газар коронатай сайн тэмцсэн, хариуцлага тооцох юм байна гэсэн их итгэл дээр 2020 оны УИХ байгуулагдсан. Харамсалтай нь ард иргэдийн энэ их итгэлийг хаяад явж байна. Тиймээс өндөр рейтингтэй байсан улстөрчийн нэр дээр гарч ирсэн энэ Их Хурал чадамжгүй. У.Хүрэлсүх хариуцлагаас зугтаж сурсан хүн. 2012 онд улс төрийн оноо авах гэж улс төрөөс зугатаж, намаа хаяад Австрали явсан. Ард үлдсэн 20 гаруй хүн нь олуулаа болсон хойно эргэж ирээд Шадар сайд болсон. Одоо бол ерөнхийлөгч болох гэж зугтаж байна. Нэг мэхээр хоёр явдаггүй юм. Ковидтой холбоотой хаврын синдромыг дийлэхгүй гэдгээ мэдээд зугтлаа. Ард түмэн ухаантай үүнийг чинь ойлгож байгаа.



Н.Ганибал:

Долдугаар сарын 1-ний жагсаал МАН-ыг 10 тэрбумын намын байртай болгосон. Харин энэ удаагийнх У.Хүрэлсүхийг Ерөнхийлөгчид дэвшүүлэх нь

Ерөнхий сайд энэ асуудлыг далимдуулан ажлаа өгч байгаа, Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулж байгаа энэ асуудал 2008 онд болсон тэр жагсаал цуглааны дараа болсон үр дүнтэй ижил байдалтай, үнэхээр танил технологи харагдаж байна. Тухайн үед долдугаар сарын 1-нд иргэд өөрсдийнхөө эрхийн төлөө жагссаны төлөө тухайн үеийн эрх баригчид иргэдийг хүчээр тарааж, таван хүний алтан амь эрсдэж байсан түүхтэй. Тэр жагсаал цуглаанаас хэн хожсон бэ. Тэр жагсаал цуглаанаас эрхээ хамгаалах гэсэн, үгээ хэлэх гэсэн иргэдийн жагсаал цуглааныг МАН –ын 10 тэрбум төгрөгийн өртөгтэй цагаан ордон баригдсанаар өндөрлүүлж байсан.



Д.Ганбат:

Огцорсон Засгийн газрын ХЭГ-ийн дарга Ерөнхий сайд болж ард түмнийг доромжиллоо

“Алдаа гаргаж огцорсон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байсан хүн Ерөнхий сайдад дэвшихийг дэмжихгүй гэдгээ Ардчилсан намын бүлэг албан ёсоор илэрхийлсэн. Бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорлоо гэчихээд нэг гишүүнээ Ерөнхий сайд болгон оруулж ирж байгаа нь Монголын ард түмнийг доромжилсон хэрэг гэж үзэж байна” гэж байр сууриа илэрхийлэв. Түүнчлэн залуу хүнд алдаа оноо байж болно гэхдээ ам ажил нь нэгдэж байх хэрэгтэй. “Би албан тушаалд очихгүй” гээд жагсаж байсан хүн өнөөдөр Ерөнхий сайд болж байна. Нэг удаа худаа ярьсан, дахин бүү худал хэлээрэй.



О.Цогтгэрэл:


Та ажил хийлгүй амьдарч болдог Монгол Улсыг хэдий хэмжээний өртэй хамт хүлээж авч байна вэ

Таныг Монголын түүхэнд хэр Ерөнхий сайд болох бол гэсэн хүлээлтээс гадна У.Хүрэлсүх сайдаас үлдсэн өр хүлээж байгаа. Та хэр хэмжээний өр хүлээж авч байна вэ. Мөн та 21 дүгээр зууны ажил хийлгүй амьдарч болдог улсыг хүлээн авч байна. Өмнөх социалист системд ч хүүхдийн мөнгийг зөвхөн тав, найман хүүхэдтэй одонтой ээжид өгдөг. Ажил хийхгүй л бол амьдардаггүй байсан. Харин өнөөдөр таны өмнө зах зээлийн нийгэмд ажил хийхгүй халамжаар амьдардаг халамжийн тогтолцоо болон эдийн засаг, нийгмийн олон асуудалд шинэчлэл хийх шаардлага хүлээж байна. Намаа юу, улсаа юу гэдэг сонголт хийж таарна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

УИХ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛГИЙН ГИШҮҮДИЙН БАЙР СУУРЬ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ-ын гишүүн Дашдондогийн Ганбат





Ерөнхий сайдын яриад байдаг сахилга хариуцлагын вакцинаа өөрсдөдөө хийцгээ!

Маш их хэмжээний мөнгө зарцуулах эрхийг Засгийн газар авсан. Эрх мэдэл, мөнгөтэйгөө харьцуулахад үр дүн бага, эрүүл мэнд ч мөнгө ч үгүй боллоо. Ерөнхий сайд хаяа нэг ил гарч ирэхдээ “Сахилга хариуцлагын вакцин” ярьдаг. Тэр вакцинаа та нар өөрсдөдөө хийвэл яасан юм бэ. Ард түмэн цар тахлын үед сахилга баттай, харицлагатай байгаа. Өвлийн хүйтэнд гадаа зогсоод шинжилгээ хийлгэсэн. Автобусанд яаж чихэж байна. Хэлсэн бүхнийг чинь хийж байна. Одоо залхаж эхэллээ шүү, энэ эргэж буцсан шийдвэр ажлын араас хөөдөг арга барилаас чинь. Эрүүл мэндийн сайд, Ерөнхий сайд нь яагаад вакцины ажлын хэсгээ ахалж ажиллахгүй байгаа юм. Дараа нь буруу зөрүү хийсэн ажлаа Сангийн сайд нь “Би мэргэжлийн бус” гэдэг үгээр халхална. Ажлаа хийж чадахгүй байгаа бол Засгийн газар огцрох хэрэгтэй.



Сахилгын хорооны даргаар хүлээн зөвшөөрөгдсөн хүнийг томилох хэрэгтэй

Шүүхийн сахилгын хорооноос их юм шалтгаалах учраас анхнаасаа зөв явах хэрэгтэй. Энэ байгууллагын дарга, гишүүдээр олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хүнийг томилох ёстой. Тиймээс сахилгын хорооны гишүүнд тавих шаардлагаа эргэж хар аа. Улс төрийн намын албан тушаалтан байсан гэдэг нь зөв. Улс төрийн албан тушаал хашиж байсан гэдгийг өөрчлөх хэрэгтэй. Хүний нөөц хязгаарлагдмал ийм нөхцөлд Үндсэн хуулийн Цэцийн дарга байсан Ж.Амарсанаа, үе үеийн УИХ-ын дарга, Ерөнхийлөгч байсан хүмүүс олон удаа парламентад сонгогдсон Д.Лүндээжанцан зэрэг хүмүүс тэнд байх ёстой.



Боловсролын сайд нь таван жилд зургаа солигджээ

Боловсролын салбарын бодлогын баримт бичиг тоосонд дарагдан орхигджээ. Асуудлын мөн чанарт бус тоо, хэлбэрт анхаарсан байдал нь Монгол Улсын ирээдүйн хөгжлийг төдий хугацаагаар хойш татаж байгааг хатуу анхааруулъя. Боловсролын салбарыг 2016 оноос хойш гаргуунд гаргаж, таван жилд зургаан сайд солигджээ. 2015 онд 92-т байсан зэрэглэл долоон байраар ухарч 2019 оны үзүүлэлтээр 99-д эрэмбэлэгдэв. Энэ хэрээр залуу үеийн өрсөлдөх чадвар буурлаа. Хамгийн тулгамдсан асуудал 10-20 жилийн дараа улс орноо авч явах ирээдүйн иргэдийн мэдлэг, чадварын асуудал. Цар тахлын хөл хорионы үед цахим болон ТВ-ийн зайн сургалтын хөтөлбөрийн хүртээмж, үр өгөөж хангалтгүй байна. Энэ нь бодит амьдрал дээр айл өрх бүрд интернет, цахим төхөөрөмжийн хүрэлцээ харилцан адилгүй байгаагаас улбаатай. Иймд УИХ дахь Ардчилсан намын бүлэг цар тахлын үед боловсролын салбарт авч хэрэгжүүлэх төлөвлөгөө, шийдэлгүй байгаад харамсаж байна. Бодлогоо эргэн харж, боловсролын байгууллагын бүх шатны суралцагчдад учирч буй “сургалтын саатал”-ыг залруулах талаар төлөвлөгөө боловсруулан ажиллахыг шаардаж байна.



Монголын нийгэм тэсрэхэд бэлэн дарьтай торх шиг болчихлоо

Өнөөдрийн үүсээд байгаа нөхцөл байдал олон зүйлийг ил болгов. МАН яаж ялзарсан, улс орон ямар байдалтай байгаа, эрүүл мэндийн тогтолцоо хэрхэн унасан, авлига албан тушаалын хэрэг яаж цэцэглэсэн бүгд ил боллоо. Монголын нийгэм тэсрэхэд бэлэн болсон дарьтай торх шиг байна. Олон аж ахуй нэгж хаалгаа барьж гурван хүний нэг нь ядуу байсан бол одоо хоёр хүний нэг нь ядуу боллоо.



Ажиллах хүчний бодлогод нухацтай хандана

Өнөөдрийн нөхцөлд ажиллах хүчний асуудал тулгамдаад байгаа. Ардчилсан нам хувийн өмч, чөлөөт зах зээлийг дэмждэгийн хувьд ажиллах хүчний бодлогод нухацтай хандана. Монголчууд ажиллаж болох ажлын байранд гаднын ажилчин авахгүй, зөвхөн мэргэжилтэй боловсон хүчин, сургагч багш нарыг ажиллуулдаг байх ёстой. Мөн дотооддоо ажлын байр бий болгодог үндэсний аж ахуйн нэгжүүдээ дэмжих, намууд сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон тунхагийн шинжтэй заалтуудаа ажил хэрэг болгох цаг болсон. Үүнийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд тусгах ёстой.

УИХ-ын гишүүн Буланы Бейсен





Эмч, эмнэлгийн ажилтны хамгаалах хэрэгсэл дутмаг байна

Эмч, эмнэлгийн ажилтнууд олноороо халдвар авч байгаад эмч хүний хувьд харамсаж байна. Үүнд халдвар хамгааллын дэглэм зөрчигдөж байна уу. Эсвэл хамгаалах хэрэгсэл дутагдалтай байна уу гэдэгт дүн шинжилгээ хийх ёстой.

Эмч нар олон хоногоор, хоол унд муутай, хүйтэн байранд ачаалалтай ажиллаж байгаа учраас дархлаа нь буурч халдвар авах эрсдэл үүсгэнэ. Эмч, сувилагчдын ар гэрт төр анхаарах хэрэгтэй. Хүүхдүүдийг нь цэцэрлэг, яслид хамруулах, нийгмийн хамгааллын талд нь мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах нь зөв.



Хэт өндөр үнээр эмийг худалдаалж байгааг хянаж хязгаарыг тогтооё

Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад 370 эм байгаа гэх боловч судлаад үзэхэд 112 эм байна. Эмийг олон улсын нэршлээр биш, нэг эм гэхэд 24 төрлөөр оруулжээ. Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад эм ханган нийлүүлэх байгууллагууд өөрсдийн эмээ оруулаад байгаа юм биш биз. Үүний ард эмийн бизнес яваад байна уу гэж хардаж байна.



Баян-Өлгий аймгийн нисэхийн өргөтгөлийн ажилд анхаарал хандууллаа

Баян-Өлгий аймгийн нисэхийн өргөтгөлийн ажил юу болж байна. Зураг төсөл нь гараад удаж байгаа. Талбай дээрээс ачаагаа авдаг ганцхан манай аймаг байна. Цагааннуур, Улаан байшинт чиглэлийн олон улсын замын төсөв хэд болсон бэ?

Төмөр замын бүтээн байгуулалтыг өмнө нь овоолсон шороо гэдэг байсан. УИХ-ын зарим гишүүн монголчууд өөрсдөө төмөр зам барьж байгаатай очиж танилцсан. Цаашдаа нүүрс тээвэрлэлтэд томоохон хувь нэмэр болохуйц бүтээн байгуулалт болсон гэж дүгнэсэн.



Эмч, багш нарын орон сууцны асуудлыг анхаарч шийдэж өгөх хэрэгтэй

Орон нутгийн сурагчдийн сургалтын чанар сүүлийн хоёр жилийн хугацаанд эрс муудсан. Баян-Өлгий аймагт хос хэлний сургалттай сургуульд шинэ Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ та ямар бодлого баримтлах вэ. Телевизийн хичээл орон нутгийн хүүхдүүдэд хүртээмж, чанар талаасаа ч хүрэлцээгүй байна. Тиймээс сурагчдын боловсрол хоцрогдлоо. Багш нарын нийгмийн асуудалд ч анхаарал хандуулах шаардлагатай. Төрийн албан хаагчдын дотор хамгийн их цалингийн зээл авдаг хүмүүс нь эмч, багш. Багш, эмч нарын цалин, орон сууцны асуудал хамгийн их тулгамдаж байгаа.



PCR аппаратгүй аймаг, хилийн боомт байна

Аймгууд PCR аппаратгүй, Био аюулгүйн кабинетгүй байна. Яаралтай төсөв хөрөнгийг нь зохицуулж аймгууддаа эдгээр аппарат сууриулж өгөөч. Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомт дээр гэхэд Нэгдсэн эмнэлэг био аюулгүйн кабинетгүй учраас Гоц халдвартынхыг аваачсан байх жишээтэй. УИХ-ын гишүүд, сайд нар эмч эмнэлгийн ажилтны хамгаалах хэрэгсэл хангалттай гэж яриад байх юм. Газар дээр байдал өөр байгааг мэдэж байгаа юу.



Вирусийг өөрийг нь сайн судалбал ямар арга хэмжээ авах нь тодорхой болно

АШУҮИС бусад эрүүл мэндийн эрдэм шинжилгээний байгууллагуудад коронавирусний хэлбэрийг нь тодорхойлж байна уу? Халдвар авсан иргэдэд шинжилгээ хийхээс гадна энэ вирусний өөрийнх нь хэлбэр, шинж чанарыг судлах судалгааны ажил хийсэн үү? Вирусийг өөрийг нь сайн судалбал ямар арга хэмжээ авах нь тодорхой болно.



Шинэ Засгийн газартаа мэргэжлийн сайдыг авч үлдэх хэрэгтэй

Ковид дотооддоо, орон нутагт ч алдлаа. Одоо хүртэл вирусны талаар судалгаа хийгдээгүй байна. Хөдөө орон нутаг, аймагт халдвар авсан иргэдийг хотод буцааж авч ирж эмчилж байна. Орон нутагт эмчлэх боломжийг яагаад одоо хүртэл бүрдүүлсэнгүй вэ? Бүтэн жилийн хугацаанд бэлтгэсэн байж яагаад ийм зүйлд бэлэн биш байгаа юм. Шинэ Ерөнхий сайд та, Засгийн газартаа мэргэжлийн сайдыг авч үлдэх хэрэгтэй. Мөн багш, эмч нарын цалингийн доод хэмжээг 2.5 сая хүргэх шаардлага байгаа. Цалингийн зээл хамгийн их авдаг хүмүүс багш, эмч нар байдаг. Үүнийг та шийдвэрлэхийн төлөө ажиллаарай. Шинээр томилогдож байгаа Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ та Баян-Өлгий аймагт байдаг хос хэлтэй сургуулиудад ямар бодлого баримтлах вэ?

УИХ-ын гишүүн Наянтайн Ганибал





Шүүгч шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлах ёстой

Шүүхийн тухай хуулийг УИХ-аар хэлэлцэж байна. Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, томилох журмыг хуульчилж байна. Харамсалтай нь энэхүү Үндсэн хуулийн өөрчлөлт нь шүүгчийн сонгон шалгаруулалтыг хийдэг Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүгч нарт хариуцлага тооцох Сахилгын хороо нь дөрвөн жилээр томилогдох нь УИХ-ын сонгуулийн үр дүнгээс шалтгаалан аль нэг намын эрх мэдэлд шилжих нөхцөл бүрдүүлж байна. Эрх мэдэл бүхий хүмүүс, тодорхой бүлэглэлийн хамааралд орохгүй байхын тулд Шүүгчдийн зөвлөлд тодорхой шалгуур байх хэрэгтэй. Сахилгын хорооны үүрэг нэлээн өндөр болж байна. Шүүгч тухайн шийдвэрийг гаргасан зайлшгүй шаардлагатай үндэслэлийг огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон бол тухайн шүүгчийн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах хүртэлх арга хэмжээг авдаг болох нь. Өмнө нь шийдвэр гаргасан шаардлагатай үндэслэлийг бичдэггүй орхигдуулдаг талаар лавлахад ачаалал ихтэйгээс болоод бичдэггүй гэж байсан.



Малчид мал, махаа борлуулж чадахгүй байна

Хорио цээрийн улмаас мал, махаа зарж чадахгүй байгаа малчдад зориулсан ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Импортын бүтээгдэхүүнийхээ бодлогын асуудлаа бид шийдэж чадаж байна. Гэхдээ Монгол Улсын хэмжээнд махны нийлүүлэлтийн асуудлыг шийдэж чадахгүй юм. Малчид яг хотондоо бэлтгэсэн махаа нийслэлд хүргэж борлуулах чигээ олохгүй өдийг хүрлээ. Багаас сум, аймаг орох хөдөлгөөнийг зохицуулах арга хэмжээг энэ хорио цээрийн үед яаралтай авах хэрэгтэй.



Хүүхдүүд гэртээ сайхан байгаа мэт боловч ирээдүйд боловсролын хувьд хохирол амсана

Хорио цээрийн улмаас мал, махаа зарж чадахгүй байгаа малчдад зориулсан ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Импортын бүтээгдэхүүнийхээ бодлогын асуудлаа бид шийдэж чадаж байна. Гэхдээ Монгол Улсын хэмжээнд махны нийлүүлэлтийн асуудлыг шийдэж чадахгүй юм. Малчид яг хотондоо бэлтгэсэн махаа нийслэлд хүргэж борлуулах чигээ олохгүй өдийг хүрлээ. Багаас сум, аймаг орох хөдөлгөөнийг зохицуулах арга хэмжээг энэ хорио цээрийн үед яаралтай авах хэрэгтэй.



Боловсролын яам ХАА-н хүрээлэнгүүдэд хоноцын сэтгэлээр ханддаг

ХАА-н салбар шинжлэх ухаан, хүрээлэнгүүддээ түшиглэсэн бодлого гаргаж дэвшилтэт алхам хийгээсэй. Гучин жил энэ асуудал яригдсан. Гэвч томилгоо, төсвийн асуудал зэргээс шалтгаалаад Засгийн газарт очоод гацдаг. Хатуухан хэлэхэд, Боловсролын яам ХАА-н хүрээлэнгүүдэд хоноцын сэтгэлээр ханддаг. Энэ салбарт олон үр дүнтэй бүтээгдэхүүн, бүтээлийг гаргах боломжийг бүрдүүлдэггүй. Манай салбар бидний нүдэн дээр доройтож байна. Цөлжилт, бэлчээр, сорт, малын үржлийн асуудал бүр хүндэрсэн. Үүний нэг шалтгаан нь шинжлэх ухаан, эрдэмтэд практикаас холдсон. Бодлогын хүрээнд шинжлэх ухаан технологийн санд хуваарилагдаж байгаа төсөв маш бага. Мал эмнэлгийн хүрээлэн тодорхой хэмжээнд олон улсын төсөл хөтөлбөрийн дэмжлэг авдаг тул харьцангуй ахисан төвшинд байдаг. Японы тусгай сортын өндөр үнэтэй махны талаар ярьж байна.



Боловсролд зарцуулж байгаа мөнгө зардал биш ирээдүйд оруулах хамгийн том хөрөнгө оруулалт

Монгол Улсын 32 дахь Ерөнхий сайдаар Л.Оюун-Эрдэнийг дэмжихгүй гэдгээ Ардчилсан намын бүлэг илэрхийлсэн. Гэхдээ олонхиороо хүч түрэн батлах байх. Ковидын үед Боловсролын салбар хамгийн эмзэг байна. 1990-ээд онд олон хүүхэд сургуулиас завсардсан. Энэ үе бол монголын боловсролын салбар дахь хамгийн хар үе. Халдвар тараагүй орон нутгийн сургуулийг танхимаар хичээллүүлэх хэрэгтэй. Дотооддоо цар тахал алдаагүй байхад танхимын хичээлийг хааж асар их боломжийг алдсан. Хүүхдүүдийн бүтэн жил алдсан мэдлэгийг нөхөхийн тулд төсөв зарцуулах хэрэгтэй. Боловсролд зарцуулж байгаа мөнгө зардал биш ирээдүйд оруулах хамгийн том хөрөнгө оруулалт. Сурч боловсроход зориулсан нэг жил тутамд ирээдүйн орлого 10 хувиар нэмэгддэг гэсэн судалгаа байдаг.

УИХ-ын гишүүн Ширнэнбандийн Адьшаа





Шүүхийн тухай хуулийн төсөл Үндсэн хуулийн заалт зөрчиж байна

Шүүх хараат бус байх ёстой. ШЕЗ, Сахилгын хороо гэдэг байгууллагыг хөрөнгө, санхүү, боловсон хүчний хувьд томилдог эрхийг УИХ авч байна. Томилгооны ажлын хэсгийг УИХ-ын нэг гишүүн ахлана гэдгийг зөвшөөрөхгүй. Бүлэглэлүүд өөрсдийн хүнээ тавих боломж үүгээр нээгдэнэ. Төрийн албаны зөвлөл нээлттэй сонгон шалгаруулалт хийж УИХ томилгооны сонсгол хийх хэрэгтэй.

Шүүхийн сургалт судалгаа мэдээллийн хүрээлэн гэдэг байгууллагыг ШЕЗ-ийн дэргэд байгуулна гэж байсан. Үүнийг Дээд шүүхийн дэргэд байгуулъя гэж зарчмын зөрүүтэй санал гаргасан. Хуулийн ажлын хэсэгт санал хураагаад дэмжигдээгүй. Гэтэл Б.Энхбаяр гишүүн засаад саналыг дэмжсэнээр бичиж оруулж ирсэн байна. Ажлын хэсгийн дөрөв, таван саналыг Б.Энхбаяр гишүүн засчээ. Ер нь Шүүхийн тухай хуулийн төсөл Үндсэн хуулийн олон заалт зөрчсөн. Үүнийг цаг хугацаа нотолно.



Ерөнхий сайдад мэдээлэл хүргүүллээ

УИХ-ын гишүүн Ш.Адьшаа Ерөнхий сайдад хандав. Учир нь баруун аймгуудад хур бороогүй байснаас ган зуд үүсэх аюул нүүрлээд байна. Зуд нүүрлэхээс сэргийлэхэд өвс, тэжээлийн нийлүүлэлт маш чухал. Өнөөдөр Хэнтий, Сүхбаатар зэрэг аймгуудад өвс, тэжээлийн гол суурь бааз байдаг. Тэнд өвс, тэжээлийн үнэ өмнөх жилүүдээс огцом өссөн. 2019 онд 25 кг-тай боодол өвс 2500 төгрөг байсан бол 18 кг өвс газар дээрээ 5000-6000 төгрөгийн үнэтэй боллоо. Өвс, тэжээлийг баруун аймагт тээвэрлэх зардал нэмэхэд 20 гаруй мянган төгрөг болно. Тиймээс Засгийн газар энэ байдалд дүгнэлт хийж, малчид, мал аж ахуй эрхлэгчдээ эрсдэлээс хамгаалж, онцгой анхаарах шаардлагатай. ХХААХҮ-ийн яамнаас экспортыг хязгаарлах замаар ололтой ажил хийж байгаа ч нөгөө талдаа үнэ өсөх эрсдэл үүсэх юм.



Үүрэг гүйцэтгэж яваад халдвар авсан алба хаагчдад нэг удаагийн тэтгэмж олгох ёстой

УИХ-ын гишүүн Ш.Адьшаа Коронавируст халдвар /Ковид19/-ын цар тахлын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэх явцад халдвар авсан төрийн албан хаагчид нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай хуулийн төсөл санаачилж УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барьсан. Цар тахлын халдварын өндөр эрсдэлтэй нөхцөл бүхий орчин болох хилийн боомт, шалган нэвтрүүлэх товчоо, төмөр замын өртөө, нисэх буудлын хяналтын цэгүүд, иргэдийг тусгаарлах байр, эмнэлэг, нийтийн хэв журам сахиулах, эргүүл хяналтын чиглэлээр төрийн холбогдох байгууллагын нийт 15 мянга гаруй ажилтан, алба хаагч халдварын голомтот бүсэд үүрэг гүйцэтгэж байна. Эдгээрээс /2020.12.30-ны байдлаар/ 148 ажилтан, алба хаагч, 41 эмч, эмнэлгийн ажилтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа халдвар авчээ. Тиймээс “Албан үүргээ гүйцэтгэх явцдаа халдвар авсан эмч, эмнэлгийн ажилчид, төрийн холбогдох байгууллагын алба хаагчдад буюу төрийн албан хаагчдад нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай хуулийн төсөл” -ийг боловсруулан өргөн барьжээ.



Орон нутагт улс төржилт хэтэрсэн

Төрийн албан хаагчийг намаас ангид тогтвортой байлгахад төрийн бодлого чиглэх ёстой. Орон нутагт улс төржилт хэрээс хэтэрсэн. Цаашид засч залруулах хуулийг боловсруулах ёстой. УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн байх квотыг Үндсэн хуулиар тогтоож өгсөн атлаа орон нутагт “давхар дээл”-тэй байхыг хөхиүлэн дэмжиж намаар дамжиж төрийн албанд ордог байдлыг хуулиар баталгаажуулж байгаа нь Үндсэн хуулийг зөрчиж байна.



Орон нутагт нислэг үйлдэж байгаа компаниуд зохиомол өрсөлдөөн үүсгэдэг

Иргэний нисэхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад салбарын яам ямар бодлого барьж байгаа вэ? Орон нутагт нислэг үйлддэг, ялангуяа баруун аймгийн чиглэлд “Хүннү Эйр”, “Аэро Монголиа” хоёр компани иргэдэд хүндрэл үүсгэж байна. Тэд хоорондоо зохиомол өрсөлдөөн бий болгодог. Нэг өдөр давхацсан нислэг үйлддэг. Энэ мэт асуудалд шийдэл байна уу? Мөн гадаадын нислэгт МИАТ-аас өөр ямар компани нислэг үйлдэх вэ? Зам тээврийн яамны албан тушаалтнууд ашиг сонирхолын зөрчилтэй. Концессийн гэрээ гэх зэрэг асуудалд сайдаасаа өөр байр суурь илэрхийлдэг. Асуудлыг гацаадаг, хувийн эрх ашгийн үүднээс асуудалд хандаж иргэд аж ахуйн нэгжийг хохироодог ажилтан одоо ч байна.

УИХ-ын гишүүн Амгалангийн Адъяасүрэн





Нүүрс тээврийн жолоочийг хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд хамруулж чадлаа

УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн хөдөлмөрийн хүнд хортой нөхцөлд оруулах журам, жагсаалтад өөрчлөлт оруулж энэ ангилалд нүүрс тээврийн жолооч нарыг багтаах ёстой гэж үзсэн. Энэхүү хүсэлтээ Зам тээврийн сайд Л.Халтар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Л.Ариунзаяа нарт хүргүүлсэн байна. Салбарын яамд энэ асуудлыг хэлэлцэж нийгмийн даатгал төлдөг нүүрс тээврийн жолооч нарыг хөдөлмөрийн хүнд, хортой нөхцлөөр тэтгэвэр тогтоолгох жагсаалтад хамруулж болно гэж үзжээ. Ингэснээр арван жил нь хүнд, хортой нөхцөлд ажилласан эмэгтэй 50 настайдаа, 12 жил зургаан сар нь тус нөхцөлд ажилласан эрэгтэй 55 насандаа тэтгэврээ тогтоолгох боломжийг нээж өгөв.



Цагаан хаданд ажиллаж, амьдарч буй 20 гаруй мянган хүний эрүүл мэндэд анхааръя

Өмнөговь аймагт 17.7 мянган жолооч, 367 аж ахуй нэгж нүүрс тээвэрлэлт хийдэг байна. Ганцхан Гашуунт сухайт боомт дээр л гэхэд арван дөрөв орчим мянган жолооч ажилладаг. Гэтэл Гашуун сухайт боомтын суурьшлын бүс болох Цагаан хаданд нэг ч эрүүл мэндийн төв байдаггүй. Эмнэлгийн үйл ажиллагааг хоёрхон эмийн сан л гүйцэтгэдэг юм байна. Тиймээс УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн тэнд ажилладаг 20 гаруй мянган хүний эрүүл мэндэд төр анхаарах шаардлагатай гэж үзэж байгаа.



1000 оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ

Баянхонгор аймаг зудын эрсдэлтэй аймгуудын нэгд орсон. Тиймээс Баянхонгор аймгаас УИХ-д сонгогдсон гишүүд хамтран төр засгаас дэмжлэг үзүүлэх боломжийг судалж Засгийн газарт санал тавьж байсны дагуу улсын нөөцийн салбар цэгүүдээс нийт 580 тонн өвсийг үнэгүй, 450 тонн малын тэжээлийн үнийг 50 хувиар хямдруулан олгохоор шийдвэрлэсэн. УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн хувийнхаа зүгээс цар тахал дотооддоо алдаж хөл хорио тогтоосон үед аймгийн төвийн 10 багийн 450 өрхөд хүнсний болон ахуйн хэрэглээнд тусламж, үзүүлсэн байна. Мөн хамт сонгогдсон УИХ-ын гишүүн Д.Ганбаттай хамтран “1000 оюутны тэтгэлэг” хөтөлбөр хэрэгжүүлж, оюутнуудад сургалтын тэтгэлгийн дэмжлэг үзүүлжээ.



Баянхонгор аймгийн малчдад өвс тэжээлийн тусламж дэмжлэг хүсч шийдвэрлүүлэв

Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан дүгнэлтээр Баянхонгор аймгийг зудын эрсдэл нэн их гэсэн зэрэглэлтэй ганц аймагт оруулсан. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын 25-ны байдлаар тус аймгийн нийт нутгийн 80 хувьд 5-30 см цасан бүрхүүл тогтсон өвөлжилт цаашлаад хаваржилт хүндрэх нь илт байгаа. Тиймээс Баянхонгор аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд өнжмөл өвсийг үнэгүй, шинийг нь хямдарсан үнээр эсвэл зээлээр олгох талаар удаа дараа хүсэлт тавьж байв. Түүнчлэн аймгийн Онцгой комиссын шуурхай ажлын хэсэг болон Баянцагаан сумын ИТХ-ын даргаас ирүүлсэн хүсэлтийг УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн Шадар сайдад уламжилж өгсөн юм. Хүсэлтэд Баянхонгор аймаг дахь Улсын нөөцийн салбарт өвс, тэжээл, хүчит тэжээл нэмж олгох асуудлыг шуурхай шийдвэрлэж өгөхийг тусгажээ.



Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн ажлын хэсэгт ажиллав

УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн ажлын хэсэгт Ардчилсан намын бүлгээс орж ажиллав. Тус хуульд оруулахаар 16 тодорхой санал гаргасан байна. Тухайлбал, нэр дэвшигчид хандив өгч байгаа талд нь хариуцлага хүлээлгэж болох заалт. Зарим тохиолдолд нэр дэвшигчид албаар хохирол учруулах зорилготойгоор хандив өгдөг. Үүнийг шалгаж тогтооход цаг хугацаа их зарцуулдаг. Мөн гадаадад амьдардаг иргэд цахимаар бүртгүүлж саналаа биечлэн өгөх, сонгуулийн сурталчилгааг сүүлийн 12 сарын турш тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хэвлэл мэдээллийн байгууллагаар явуулах, хуульд заасан хугацаанд зардлын тайлангаа ирүүлээгүй бол дараагийн сонгуульд оролцуулахгүй байх зэрэг саналыг төсөлд нэмж тусгасан байна.

УИХ-ын гишүүн Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ





Ерөнхий сайдад асуулга хүргүүлэв

Сүүлийн жилүүдэд уул уурхайн олборолтын үйл ажиллагаа эрчимжиж байгаа. Өмнөговь аймагт хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин сүйдэж, иргэд малчид хохирсоор байна. УИХ-ын гишүүн Д.Бат-Эрдэнэ дээрх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий Сайд У.Хүрэлсүхэд Гурвантэс сумын Алтан ууланд үйл ажиллагаа явуулдаг “АГМ майнинг” компанийн зөрчлийн талаар, мөн 2019 онд цуцлагдсан 12 тусгай зөвшөөрлийн талбай хүлээлгэн өгөх ажил ямар шатанд явж байгаа талаар асуулга тавилаа.



УОК-ын дарга Я.Содбаатарт хүсэлт гаргалаа

УИХ-ын гишүүн Д.Бат-Эрдэнэ нийслэлд гацсан Өмнөговь аймгийн 2000 гаруй иргэдийг арванхоёрдугаар сарын 1-нээс эхлэн нутагт нь буцаах хүсэлтийг Монгол Улсын Шадар Сайд, Улсын Онцгой Комиссын дарга Я.Содбаатарт уламжлав. Тэрээр Өмнөговьд уурхайд ажиллагсадын талаар ярьж байгаа ч нутгийн иргэдийн асуудлыг хөндөхгүй байгаа талаар удаа дараа хөндөж нутгийн иргэдээ түргэн буцаах саналыг зохих байгууллагад уламжлав. Ингэснээр орон нутгийн иргэдээс шинжилгээ авч, иргэдээ нутаг буцаах асуудлыг шийдвэрлүүллээ.



Говьд ус аваачиж байж эдийн засаг тэлнэ

Монголын эдийн засаг Эрдэнэт, Оюутолгой, Тавантолгой гэсэн гурван тулгууртай. Үүний хоёр нь Өмнөговь аймагт бий. Тэнд олон мянган хүн ажиллаж байна. Хот төлөвлөлт байна уу?

Нэгэнт можаротари тогтолцоотой учраас би тойргийнхоо асуудлаа ярина. Гэхдээ Өмнөговь аймаг тойрог биш нийт Монголын асуудал болсон гэдгийг бүх хүн мэдэж байгаа. Гэтэл Өмнөговьд Тавантолгойн бүлэг орд, Оюутолгой руу очих дэд бүтцийн асуудлыг одоо хүртэл гүйцэд шийдсэнгүй.

Цогтцэций болон Шартээгийн уулзвар хүртэлх 59.6км авто замын ажлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна. Жараадхан км замыг өнгөрсөн дөрвөн жилд дуусгасангүй. Мөн Нарийнсухайтын бүлэг орд руу очих зам маш их зорчигч, тээвэртэй хамгийн эрэлттэй зам. Үүнд яагаад хөрөнгө өгөхгүй байна вэ?

Та бүхэн төсвийн хөрөнгө оруулалтыг хаанаас ихийг авна. Тэндээ ихийг зарцуулна. Өөрөөр хэлбэл төсвийн шударга зарчим барина. Нэг жилд нь бага хэмжээний төсөв тавьсан ч нийт дөрвөн жилийн нийлбэр нь ижил байхаар төсөв хуваарилна гэсэн. Гэвч Өмнөговь хамгийн бага төсөвтэй хэвээрээ.

Монгол Улс социализмын үед мал аж ахуйн бааз байсан, Харин одоо уул уурхайн түүхий эдийн бааз орон болсон. Жилд 7.7 орчим тэрбум ам.долларын түүхий эдийг гадагш гаргадаг. Тэр нь хил даваад 20-30 тэрбум долларын ашиг өгч байна. Хилийн гадна хэдэн мянган хүнийг ажлын байраар хангаж, олон үйлдвэрийг тэтгэж байгаа. Бид өөрсдөө түүхий эдээ боловсруулдаг болчихвол нэмүү өртөг шингэж эдийн засаг гурав дахин тэлэх боломжтой.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ 10 мянган ам.доллар болгочихвол ингэж улс төржиж намчирхах байдал ч аяндаа арилна. Сүүлийн 10 гаруй жил манай дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 10 тэрбум орчим ам.долларт гацчихаад байна.

Гүн боловсруулах, угаах үйлдвэр барина гэж ярьдаг ч үйл хэрэг болохгүй байна. Яагаад гэвэл говьд ус аваачих хэрэгтэй. Түүхий эд нь байгаа газраа усаа аваачиж байж л эдийн засгаа тэлнэ. Гэтэл усны ямар ч ТЭЗҮ, бодлого ярихгүй байна. Мэдээж түүхий эдээ зөөх нь зөв, гэхдээ усны хангамжийн ажлаа зэрэг хийгээд явах шаардлагатай.

УИХ-ын гишүүн Жамбын Батсуурь





Нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдал үгүй болох аюултай

Тухайн орон нутагт ажиллаж амьдардаггүй хүн аймаг, сумын ИТХ-д нэр дэвших нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад аюултай. Үүргэвчтэй хэдэн нөхөд очоод олонхи болохыг үгүйсгэхгүй. Тэд төрийн албыг наймаалцах ч боломж үүсгэнэ. Ингэвэл нутгийн өөрөө удирдах дээд байгууллага ИТХ байх зарчим сууриараа алдагдах аюултай.



Монгол адууны соёлыг устгах хулгайн хуулийг эсэргүүцэж байна

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг би дэмжихгүй. Энэ хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар 2019 онд Засгийн газраас төсөл боловсруулаад ажилласан. Үүнээс сугалж оруулж ирж байна. Тэгээд ч хэлэлцэх цаг үе нь ч биш. Цар тахал гээд иргэд нь амь наана, там цаана байхад юун адууны сэрвээний өндөр, баяр наадмын хууль вэ? Монгол үндэсний наадам бол монголын тусгаар тогтнол, соёлын асуудал. Хүн төрөлхтний соёлын өв гэж үзэж ЮНЕСКО-д 2010 онд бүртгүүлсэн. Тиймээс цахимаар хэлэлцэх асуудал ч биш. Энэ хүнд цагт өвс тэжээлийн тусламж яг малчдад очиж байна уу. Баячуудын морь малыг тэжээх, тэдний зугаа цэнгэлд очиж байгаа. Би таван наснаасаа хурдан морь унасан. Монгол наадмыг мэднэ. Наадмын үеэр сум, аймгийн төвд морь хасагдах асуудал гардаггүй. Мөнгө дагасан, бие биеэ давах гэсэн хэдхэн хүний хүслээс болж Улаанбаатарт л морь хасагддаг. Тэднийг хэн авлига авч өг, гаднаас морь оруулж ир гэсэн юм. Баячуудын, хөрөнгөтэй хүмүүсийн зугааг хуульчилж, жинхэнэ монгол адууны соёлыг устгах гэсэн хүмүүсийн хүслийг биелүүлсэн хулгайн хууль батлах гэж байна. Үнэхээр баяр наадмын хуулиа сайжруулъя гэвэл морь, бөх, сур гээд яагаад цогцоор нь оруулж ирж ярихгүй байгаа юм. Байшинд амьдардаг адууг яагаад дэмжих ёстой юм.



Хуруууны бэхэн тэмдэглэгээ хийх нь сонгуулийн луйвар, хардалт сэрдэлтийг зогсоож чадна

Одоо хамгийн гол нь сонгогчдын хуруунд бэхэн тэмдэглэгээ хийх нь хамгийн чухал асуудал. Бэхэн тэмдэглэгээ хийснээр царцаа, сонгуулийн элдэв луйвраас гадна хардалт сэрдэлт ч үгүй болно. Цаг хугацааны хувьд цуг явуулахад бэрхшээл байна гэж үзэж байгаа Сонгуулийн ерөнхий хорооны саналыг хүлээж авах нь зөв.



Хавар хэдэн сая мал хорогдлоо гэх мэдээ сонсмооргүй байна

Хавар хэдэн сая мал хорогдлоо гэх мэдээ сонсохгүйн тулд онд орохооргүй малыг төр одооноос малчдаас авах хувилбар байж болох юм. Өнгөрсөн хавар малчдын ноолуурыг төр зээлээр авсан. Үүнтэй ижил өвлийг давахгүй болсон малыг төр зээлээр авах хэрэгтэй. Жишээ нь, лаазалсан бүтээгдэхүүн болгох зэргээр борлуулсныхаа дараа малчдад мөнгийг нь өгвөл хэн хэндээ хэрэгтэй.



Сүхбаатар аймгаа зүүн бүсийн хөгжлийн тулгуур болгохын төлөө ажиллана

2020 оны сонгуулиар Сүхбаатарчууд маань Н.Ганибал гишүүн бид хоёрыг төрийн дээд байгууллага УИХ-д хамтдаа ажиллах боломжийг олгосон сайхан сонголт хийсэн. Мөн орон нутгийн сонгуульд Ардчилсан намын залуусыг хамтад нь сонголоо. Өнгөрсөн хугацаанд ард иргэдтэйгээ хамтран олон шинэ зүйл хийж, нэлээдгүй бэрхшээлийг хамт туулсан хүний хувьд ажлын төлөвлөгөөгөө нягт боловсруулсан. Монгол Улсын хэмжээнд болон Сүхбаатар аймаг, зүүн бүс нутагтаа хийх ажлаа тодорхойлж улс төр, эдийн засгийг тогтвортой байлгах дэлхий нийтэд үүсээд буй цар тахлын голомтыг хумих, түүнээс гарсан хор хохирлыг арилгахыг зорин ажиллаж байна. Цаашид эдийн засгаа тэлэх зорилгоор Сайншанд-Баруун-Урт Чойбалсан чиглэлийн төмөр замыг барьж байгуулах, Баруун-Уртыг Бичигтийн боомттой хатуу хучилттай замаар холбох, сургуулийг шаардлагатай техник хэрэгслээр хангах, бүх сумынхаа Эрүүл мэндийн төвийг иж бүрэн болгох, мөн соёлын төвийн барилгатай болгоно.



Тэтгэврийн олон тулгуурт бодлогыг дэмжиж тэтгэврийн доод хэмжээг 500 мянга болгох хэрэгтэй

Засгийн газар тэтгэврийн шинэчлэлийг хийнэ гэж мөрийн хөтөлбөртөө тусгасан. Мөрийн хөтөлбөрөө аль нь хэрэгжүүлэх юм. Чадахгүй бол “Бид ард түмэнд амласан амлалтаа биелүүлж чадахгүй нь. Буруу тооцоо хийж” гэдгээ хэлэх хэрэгтэй. Миний хувьд олон тулгуурт тэтгэврийн тогтолцоотой болох нь зөв гэж харж байгаа. Мөн нийгмийн даатгалын багц хуулийг оруулж ирж хамт хэлэлцэх ёстой гэж бодож байна.

УИХ-ын гишүүн Салдангийн Одонтуяа





Хорих ангид вирус тархах эрсдэл өндөр учраас хөнгөн ялтай хоригдлуудыг суллаж болох уу

Иргэдэд үнэн зөв мэдээлэл чухал. Ардчилсан намаас өргөн барьсан хуулийн төсөлд иргэдэд үнэн бодитой мэдээлэл хэрхэн хүргэх талаар тодорхой тусгасан. Засгийн газраас өргөн барьсан энэ хувилбарт гадаадад байгаа иргэдийн эрх зөрчигдсөн үед хэрхэн шийдэх талаар тусгаагүй байна. Нислэг гэнэт цуцлагдахад иргэд хүнд байдалд ордог. Үүнд хүний эрх зөрчигдөж байна.Үүнээс шалтгаалсан хохирлыг хэн барагдуулах вэ. БНСУ-ын түр хамгаалах байранд 12 иргэн өлсгөлөн зарласан. Үүн дотор хоёр сартай жирэмсэн эмэгтэй байна.



Эрх нь зөрчигдсөн хүмүүс хэнд хандах нь тодорхойгүй байна

Дэлхий дахинд хүний эрхийн төлөө тэмцэгчдийг хэрхэн хамгаалах талаар анхаарч байна. Манай улсад хамгийн их дутагдаж байгаа асуудал бол механизм. Онцгой нөхцөл байдлын буюу цар тахлын үед гадаадад байгаа монголчуудын эрх их зөрчигдсөн. Ийм үед хүний эрхийг хамгаалах тухай энэ хуульд тусгах хэрэгтэй. Мөн иргэдийн амьдрах орчинд эрх нь маш их зөрчигддөг. Айлын цонх таглаад барилга барьдаг. Иргэд үүнийг эсэргүүцэж дүүрэгт ханддаг боловч нийслэлээс зөвшөөрөл өгдөг.



Хүчирхийлэлд өртсөн иргэнээ маш сайн хамгаалдаг гэдгийг мэдрүүлж, ойлгуулах нь чухал

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын ажилд дэвшил гарч байгаа. Эрх зүйн орчин бүрдэж байна. Эмэгтэй гишүүд ч энэ чиглэлд төсвийг бага боловч хэмжээгээр нэмэгдүүлж чадлаа. Гэхдээ тайвширч болохгүй. Төрөл бүрийн аян зохион байгуулах хэрэгтэй. Гэр бүлийн хүчирхийлэл гэмт хэрэг юм. Төр хүчирхийлэлд өртсөн иргэнээ маш сайн хамгаалдаг гэдгээ мэдрүүлж, ойлгуулж байх нь чухал. Хүчирхийлэгч өмгөөлж хамгаалуулах чадваргүйг нь далимдуулдаг. Хэрвээ урьдчилж ойлгуулж чадвал ядаж хуулийн хариуцлага хүлээхээс эмээнэ.



Тийзээ авсан иргэдийн нислэгийг гэнэт цуцалбал амьжиргааг нь дэмжих заалт оруулъя

Тусгай үүргийн нислэгт төлбөрөө төлж цагаа тохироод иргэд хувийн бэлтгэлээ хангачихсан байдаг. Гэтэл гэнэт нислэг цуцлагдсан тохиолдол олон гарсан. Энэ үед иргэд хүнд байдалд ордог. Нислэг нь гэнэт цуцлагдсан иргэдэд тодорхой мөнгөн тэтгэмж өгөх тухай заалтыг Ковидын эсрэг хуулийн 8.1.1-р оруулсан байсныг хасчихлаа. Гишүүд энэ заалтын учрыг нь ойлгох хэрэгтэй. Гэнэт нислэг цуцлагдахад хүний эрх ноцтой зөрчигдөж байна гэж Хүний эрхийн үндэсний комисс дүгнэлт гаргасан. Дүгнэлтийг нь дагахгүй юм бол энэ байгууллагаа татан буулга. Их бага нь хамаагүй тодорхой хэмжээний дэмжлэг заавал үзүүлэх хэрэгтэй.



Эдийн засгийг хүнээр зүйрлэвэл сэхээнд орчихоод байна

Одоо бол улс төржих цаг биш. Нөхцөл байдал маш хүнд байна. Хөл хориог арванхоёрдугаар сарын нэгэн хүртэл үргэлжлүүлэхэд 152.9 мянга, он дуустал сунгавал 432.6 мянган хүн ажилгүй болно гэсэн судалгааг МҮХАҮТ-аас гаргасан байна. Аж ахуйн нэгжүүдээс авсан судалгаагаар 50 хувь нь нэг сар, 30 хувь нь гурван сар хүртэл хугацаанд хориог давах чадамжтай гэжээ. Эдийн засгийг хүнээр зүйрлэвэл сэхээнд орчихоод байна. Үндэсний үйлдвэрлэлд өгөх 800 мянган төгрөгийн ваучераар зах зээлд 20, 30 жил зүтгэсэн үндэсний үйлдвэрлэгчид, аж ахуй нэгжүүдээ дэмжих хэрэгтэй. Одоо Японоос өгч байгаа 233 сая долларыг шууд ард иргэддээ зарцуулах хэрэгтэй.



УОК-т шаардлага хүргүүлж гадаадад гацсан иргэдээ авч чадлаа

Монгол Улс дотооддоо Ковид-19 цар тахал алдсантай холбоотойгоор Сөүл-УБ чиглэлийн таван удаагийн нислэгийг цуцалсан. Үүнээс болж эх орондоо ирж чадахгүй байгаа 4000 гаруй иргэд байна. Тэдний төлөөлөл БНСУ дахь Монгол Улсын Элчин сайдын яамны гадаа жагсаал хийж, өлсгөлөн зарласан. Эдгээр иргэдийн дунд хүнд өвчтэй, жирэмсэн эхчүүд байгаа юм. БНСУ-аас иргэдээ авч ирэх нь халдвар тархаах аюултай гэж УОК үзсэн бол иргэдийн хоол хүнс, хоноглох байр, эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарч яаралтай арга хэмжээ авахгүй бол хүний амь нас ч эрсдэх аюултай юм.



Нэг шүүгч 20 төрийн албан хаагчийн ажлыг хийж байна

Нэг яаманд 80-120 мэргэжилтэн ажиллаж жилд дунджаар 1000-1200 албан бичиг гаргадаг. Гэтэл анхан шатны шүүгч нь туслах, нарийн бичгийн хамт 1800 гаруй эрх зүйн актыг гаргадаг. Нэг шүүгч төрийн захиргааны 20 албан хаагчийн хэмжээний ажлыг хийж байна. Ачааллыг тэнцүүлэх, орон тоог нэмэх, ажиллах нөхцөлөөр хангах тал дээр анхаарах хэрэгтэй.

УИХ-ын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж





Иргэдийн амьдралд бодит нөлөө үзүүлэхүйц 10 хуулийн төсөл өргөн барина

Би иргэдийн амьдралд бодит нөлөө үзүүлэхүйц 10 хуулийн төсөл санаачилж өргөн барина. Үүнд:

1. НӨАТ-ын хэмжээг 5 хувь болгон бууруулах хуулийн төсөл. Энэ татварыг эцсийн хэрэглэгч төлдөг учраас иргэдэд бодит хэмнэлт болно.
2. Хуурамч шатахуунтай тэмцэх тухай хуулийн төсөл. Нэг Швейцарийн иргэн монголчуудад хуурамч шатахуун борлуулаад 100 тэрбум төгрөг халааслачихдаг явдлыг зогсооно. Хуурамч шатахууныг хориглох нь иргэдийн эрүүл мэндээс гадна машин техникийн эвдрэл багасгахад үр дүнгээ өгнө.
3. Онцгой татвар ногдуулах замаар “Монгол тамхи Со” гэж бараг 100 хувийн хятадын хөрөнгө оруулалттай компаниас татвар авах боломж бүрдүүлнэ.
4. Зөрчлийн тухай хуулиар шийтгүүлсэн иргэдийг цар тахлын хүнд нөхцөлд өршөөнө. Энэ хууль батлагдсанаас хойш давхардсан тоогоор гурван сая иргэнээ 600 тэрбумаар торгожээ. Иргэдээ торгож төсвөө бүрдүүлдэг орон болох нь.
5. Тэтгэвэрт гарахад сүүлийн долоон жилийн шимтгэлийн дүнг тооцдог байсныг тав болгон бууруулна.
6. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн НДШ нөхөн төлөх хугацааг нэг жилээр сунгах эдгээр хуулийн төслүүдийг өргөн барьсан.

Цаашид дараах төслүүдийг өргөн барина.

7. Махны экспортод квот тогтоосныг болиулна. Ингэснээр малын үнэ 50 хувь өсөх боломж үүснэ.
8. Хамтын тэтгэврийн тухай хуулийг өргөн барина. Төсөл батлагдвал эхнэр, нөхрийнхөө тэтгэврээс багадаа 120 мянган төгрөг нэмж авахыг хуульчилна.
9. Сум хөгжүүлэх сангийн хуулийг өөрчилж суманд ЖДҮ хөгжих боломж бүрдүүлж өгнө.
10. Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулж багш нарын нийгмийн баталгааг хангуулна.



Тэтгэврийн хэмжээг цалингийн долоо биш таван жилийн дунджаар тогтоох ёстой

УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах төсөл санаачилсан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй энэ хуулиар өндөр насны тэтгэврийн хэмжээг сүүлийн долоон жилийн дундаж цалингаар тогтоож байгаа. Тэрээр энэ хугацааг таван жил болгон бууруулахаар төсөлд тусгажээ.



Олон дүрэм, журам маш их орлого хааж байсан

Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль сайн хууль. Харамсалтай нь хууль сайн ч түүнийг дагаж гардаг журмыг хариуцлагагүй хийдэг. Намайг Гадаадын иргэн, харьяатын газрын даргаар очиход 86 журам үйлчилж байсан. Үүнийг 44 болгон багасгахад дөрвөн тэрбум төгрөгийн орлого олдог байсан байгууллагын маань орлого 13 тэрбум болж нэмэгдсэн. Дүрэм журам ямар их орлогыг хааж байсны илрэл энэ. 1990 оноос хойш БНХАУ-ын 12 мянган иргэнийг албадан гаргасны 6000-ыг нь намайг даргаар ажиллаж байх хугацаанд гаргасан.



“Мон Эн Ко” компанид Засгийн газар хариуцлага тооц!

Ховд аймгийн Хөшөөтийн уурхайг ашигладаг “Мон Эн Ко” гэж даварсан компани байна. Стратегийн ордоос хулгайгаар авч үлдсэн уурхайгаар зөвхөн өөртөө ашиг олдог, нэгийг нөгөөтэй уралдуулах, монголчууд, Ховдчуудыг хагаралдуулж, манжийн аргаар ажилладаг энэ компанид Засгийн газар хариуцлага тооцох цаг болсон. Тус компани тээврээ хийлгэдэг 26 компанийн гэрээг цуцлаад өөрийн тогтоосон үнээр гэрээ хийхийг шахаж 12-той гэрээ хийсэн. Үлдсэн 14 компанийн 350 жолооч, тэдний ар гэр 3000 гаруй хүнийг хохироогоод байна. “Мон Эн Ко” цаашдаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ажиллахгүй бол улсын хөрөнгөөр нөөцөө тогтоосон уурхай учраас стратегийн ордод оруулах хуулийн төсөл оруулна.



УИХ-ын нөхөн сонгуулийг Ерөнхийлөгчийнхтэй хамт явуулж болохгүй

Сонгинохайрхан дүүрэг нийт сонгогчдын 15 орчим хувийг эзэлдэг аль ч сонгуулийн үр дүнд шууд нөлөөлөхүйц том тойрог. Тиймээс УИХ-ын нөхөн сонгуулийг Ерөнхийлөгчийнхтэй хамт явуулж болохгүй. Нэг нь улс орон даяар, нөгөөх нь орон нутагт явагддаг зарчмын хувьд өөр сонгуулиуд. Миний саналаар УИХ-ын нөхөн сонгуулийг аравдугаар сарын 20-нд болгох нь зөв. Түүнчлэн нөхөн сонгуульд нэр дэвшигчийн сурталчилгааны хугацааг багасгах нь Үндсэн хуулийн маргаан болно.

УИХ-ын гишүүн Цэвэгдоржийн Туваан





Иргэдийн хувийн мэдээллийг нууцлах, эх орондоо буцаж ирэх эрхийг баталгаажуулна

УИХ-ын гишүүн Ц.Туваан, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулахаар төсөл өргөн барилаа. УИХ дахь Ардчилсан намын бүлгээс зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох, нарийвчлан нэмж тусгах шаардлагатай гэж үзэн хуулийн төслийг санаачилж дараах заалтуудыг тусгав. Үүнд, вирусний халдвар авсан иргэний болон гэр бүлийнх нь мэдээллийн нууцлалыг хамгаалах, гаргасан шийдвэртэй нь холбоотой үүссэн сөрөг үр дагаврыг тухайн албан тушаалтан, эрх бүхий байгууллага өөрөө хариуцан арилгана. Гадаадад байгаа Монгол Улсын иргэн эх орондоо буцаж ирэх, улсын хилээр нэвтрэх эрхээ баталгаатай эдлэх, Ковид-19-тэй холбоотой үндэсний цахим мэдээллийн сан бүрдүүлж ашиглах, цар тахлын үеэр үзүүлсэн тусламж, хандивыг тусгай санд төвлөрүүлэн зарцуулалтыг олон нийтэд ил тод тайлагнах зэрэг заалтуудыг тусгасан.



Ямаанд 180 тэрбум төгрөг өгдөг хэрнээ ядарсан иргэддээ яагаад дэмжлэг өгч болдоггүй юм

Хүнд хэцүү цагт хүүхдийн мөнгө өгөөд байна гэдэг. Өрхийн судалгаа харсан нийт өрхийн 40 хувь нь хүүхэдгүй юм байна. Энэ 40 хувь санхүүгийн дэмжлэг авч чадахгүй байгаа. Улс орнуудын туршлагаас харахад аж ахуйн нэгжүүддээ бодитой дэмжлэг үзүүлж байна. Монгол Улс ямааны ноолуурт 180 тэрбум төгрөг өгдөг. Ядарсан иргэддээ өгье гэсэн бэлэн санаачилга гарч байхад хэрэгжүүлдэггүй. Энэ ямар бодлого юм бэ?



ХАА-н цогц бодлого боловсруулах цаг нь болсон

Малын тоо хэт өсч, бэлчээрийн даац хэтэрлээ. Цаашид малаас гардаг түүхий эдээ боловсруулж, үнэ цэнэтэй болгох бодлого барьж ажиллах хэрэгтэй. УИХ-ын гишүүд очиж танилцаад байсан Дарханы арьс ширний цогцолборт гэхэд улсын төсөвт мөнгө тусгахгүй байх жишээтэй. Иймэрхүү бодлогын асуудал алдагдлаа. Бодлогын хувьд цогцоор нь хандахгүй бол гал унтраах маягаар ажиллаад байна. Тиймээс цогц бодлого боловсруулж оруулж ирэх цаг болсон. Тэгэхгүй бол одоо байгаа асуудал цаашид ч арилахгүй үргэлжилсээр байх болно.



Оюутны зээл олгохгүй байгаа нь олон хүүхдийн амьдралыг хохироож байна

Ардчилсан намын санаачилж олгож байсан оюутны 70 мянгыг эрх баригчид халамж гээд зогсоож, оюутны хөгжлийн зээл гэж гаргасан. Гэтэл одоо зээл ч үгүй буцалтгүй тусламж ч үгүй боллоо. Зээл авч төлбөрөө төлөөгүй гээд төгсөх курсын оюутнууд дипломоо авч чадахгүй байна. Энэ жилийн төсөвт 24.8 тэрбум төгрөгийг зээлд тусгажээ. Үүнд нэн даруй гэрээ байгуулчихаад зээлээ авч чадахгүй байгаа хүүхдүүдийг хамруулж болох уу? Төрийн буруу, алдаатай бодлогын үр дагаварт оюутнууд хохироод байна.



Үрийн дагнасан аж ахуй үүсгэх бодлого хэрэгтэй

Газар тариаланд үрийн сортын асуудал маш чухал. Монголчууд “ямар үр тарина, түүнийгээ хураана” гэдэг. Нэг хэсэг ямар үрээр тарьж байгааг хянах боломжгүй байсан. Тус хуулиар энэ асуудал шийдэгдэнэ. Үрийн аж ахуй манайд орхигдсон. Төрөөс бодлогоор татаас дэмжлэгийг түлхүү өгч, элит, супер элит сортын үрүүдийг бэлтгэж аж ахуйн нэгжүүд нь тариалдаг байх хэрэгтэй. Үрийн сортод шинэ технологи нээж туршилт хийж нутагшуулах ёстой эрдэм шинжилгээний байгууллагын техник маш муу. Салбартаа мэргэжилдээ хайртай хэдхэн хүмүүс л энэ ажлыг хийж байна. Эдгээр хүмүүсийн нийгмийн асуудалд анхаарах цаг болсон.



Өвсний үнэ урьд хожид үзэгдээгүйгээр өслөө

Тариаланчдад 150 тэрбум төгрөгийн гурван хувийн хөнгөлөлттэй зээл олгохоор болсон. Тариланчид материалаа бүрдүүлээд өгөхөөр хөрөнгө оруулалт ороогүй гэдэг тайлбарыг хэлж байна. Тодорхой дөрөв таван аймагт зуншлага хэцүү байсан. Өвс, хивэгний үнэ урьд хожид үзэгдээгүйгээр өссөн байна. Мал аж ахуй хүндрэх нь тодорхой боллоо. Үүн дээр урьдчилан арга хэмжээ авах ёстой.

УИХ-ын гишүүн Одонгийн Цогтгэрэл





Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэлийн талаар салбарын сайдад асуулга хүргүүллээ

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад асуулга хүргүүллээ. Тэрээр ХНХ-ийн сайд А.Ариунзаяагаас хөдөлмөр эрхлэлт, зах зээлийн эрэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлд хийгдсэн болон хийхээр төлөвлөж буй ажлын талаар асуужээ. Мөн ажилд ороход хүндрэлтэй байгаа иргэд, малчид, бичил үйлдвэрлэл эрхлэгчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон нөхөрлөл хоршоодыг дэмжих чиглэлээр хийгдсэн болон цаашид хийхээр төлөвлөж буй ажлуудын талаар асуусан байна.



Иргэний эрх, эрх чөлөө гэдэг ойлголт бүдгэрсээр байна

Иргэд нь төрөө байгуулж, төр иргэндээ үйлчилдэг тогтолцоонд шилжээд гучин жил өнгөрлөө. Тодорхой үр үнд хүрсэн ч, хүний эрх бүрэн хангагдахгүй байгаа нь иргэдэд эргэлзээ үүсгэж байна. Энэ нь эргээд ардчилалд эргэлзэх нөхцлийг үүсгэсэн. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд элит, даргын, төрийн чиглэлд илүү явж иргэний эрх, эрх чөлөө гэдэг ойлголт бүдгэрчээ. Тиймээс хүний эрх иргэний эрх тал руугаа бодлогоо чиглүүлэх, хэн нэгнээр эрхээ хамгаалуулахаас илүү иргэн бүр өөрийнхөө эрхийн хамгаалагч байх хэрэгтэй. Иргэн төрөө байгуулдаг ч одоог хүртэл өөрийнхөө эрхийг мэдэхгүй олон хүн байна.



Эдийн засгаа тооцоолж ялгаатай бодлого явуулахгүй бол нийгмийн маш том хэсэг үлдэж байна

Татварын газрын сайтын мэдээллийг харлаа. Монгол орон даяар арван сарын хугацаанд хэрэгжсэн гэхэд хүртээмж хангалтгүй байна. Хүүхдийн мөнгөөр дэмжлэг үзүүлж байгаа гэдэг. Гэтэл 900 мянган өрхөөс 400 мянга гаруй нь хүүхдийн мөнгө авдаггүй. Цахилгаан, дулаан, усны мөнгийг тэглэж дэмжлэг үзүүлсэн гэж

байна. Хүүхдийн мөнгөнөөс хасагдсан 400 гаруй мянган өрхийн дундаж нь хоёр өрөө байранд амьдардаг гэж бодоход 60-70 мянган төгрөгийн дэмжлэг авч байна. Ажил орлого нь зогсчихоод байхад сард энэ хэмжээний хөнгөлөлт авч байгаа айлын амьжиргаа хүрэлцэх үү? Эдийн засгаа тооцоолж ялгаатай бодлого явуулахгүй бол нийгмийн маш том хэсэг үлдэж байна.



“Цаасан дээр” тариа тарьдаг тогтолцооны гажигаа нуусан хуулийн төслийг дэмжихгүй

Дотоодын хэрэглээгээ бүрэн хангах тариа тарьсан гэж хавар мэдээлдэг. Гэвч бодит байдалд оны сүүлээр хүрэлцдэггүй. Сүүлийн таван жилд 500 мянган тонн улаан буудай импортоор авчээ. Жил бүр улаан буудайны 30 хувийг гаднаас авч байна гэсэн үг. Гэтэл сүүлийн таван жилд улаанбуудайн татаасанд 150 орчим тэрбум төгрөгийг өгсөн байна. Газар тариаланг дэмжих сан олон жилийн өмнөөс дампуурсан. Яг ийм онцгой үе, хоол хүнсний асуудал гарч ирэхээр энэ сан нь мөнгөгүй. Үүнийг эрүүлээр харж тогтолцооны гажигийг засах хэрэгтэй.



Хүний эрх, хувийн өмч, шударга шүүх байхад хөгжил дэвшилд хүрнэ

Хүний эрх, хувийн өмч, шударга шүүх байхад хөгжил дэвшилд хүрнэ гэж үздэг. Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Иргэдийн төлөөлөгчийн гээд дөрвөн хуулийг яагаад нэгтгэж байгаа юм. Эдгээр хууль нь багц байдлаар явах ёстой. Шүүхийн хуулиуд эрх үүрэг заасан материаллаг шинжтэй хуулиуд гэхээсээ илүү үйл явцын шинжтэй байдаг. Процессын үйлчлэлтэй дөрвөн том хуулийг механикаар нэг хавтсанд оруулснаар ямар үр дүн гарч, яаж шударга шүүх бий болох нь тодорхой харагдахгүй байна.



Зах зээлийн эдийн засаг, чөлөөт нийгэмд иргэддээ сонголт өгдөг байх ёстой

Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний дээд хүүг гурван хувь болгох нь ард түмэнд хүндрэл үүсгэнэ. Өдрийн зээл 0.1 хувиас илүү байвал зөрчлийн хэрэг үүсгэж цагдаагаар торгуулна. Энгийн жишээ авъя. Нэг эмэгтэйд зуун мянган төгрөг хэрэг болоод ээмгээ барьцаалан зээлдүүлэх газарт тавья. Ингэхдээ 0.1 хувь гэдгээр тооцоолж 100 төгрөгийн хэлцэл хийнэ. Үүнээс илүү байвал торгодог болох нь. Зах зээлийн эдийн засаг, чөлөөт нийгэмд иргэддээ сонголт өгдөг байх ёстой. Гэтэл соёлтойгоор энэ харилцааг хааж байна. Ингэснээр өдрийн зээл, далд эдийн засаг, гэмт хэрэг илүү гарах нөхцөлийг үүсгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХЭЛЭЛЦСЭН ГОЛ ХУУЛИУД

Байнгын хороо, ажлын хэсэгт ажилласан байдал



Монгол Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хорооны ажлын хэсэгт хүсэлтээрээ, эсхүл томилсны дагуу орж ажиллах эрхтэй. Улсын Их Хурал, Байнгын хороо шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж ажилладаг. Мөн байнгын, дэд, түр хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг гишүүд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор байгуулан ажиллуулж болох бөгөөд уг ажлын хэсэг Засгийн газрын болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хяналт шалгалт хийдэг.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий 20 гаруй ажлын хэсэгт орж ажилласан. Ажлын хэсэгт орж ажилласан зарим гишүүдийн байр сууриас товч илэрхийлбэл:



УИХ-ын гишүүн Ж.Батсуурь

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. Тэрээр зарчмын зөрүүтэй олон санал гаргаснаас Засаг даргад нэр дэвшигчийг дээд шатны Засаг дарга болон Ерөнхий сайд нэр дэвшүүлэх санал гаргаж болохоор, мөн тэрээр нэр дэвшигчийг томилохоос татгалзвал өөр хүний нэрийг дэвшүүлэхээр зохицуулсан нь Үндсэн хуулийн үзэл санааг илтэд зөрчсөн, орон нутгийн өөрөө удирдах ёсыг үгүйсгэсэн заалт байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг

шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж тус тус заасан нь орон нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх баталгааг хангасан, иргэдийн Төлөөлөгчдийн, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал болох нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаараа дамжуулан тухайн орон нутгийн ач холбогдол бүхий асуудлыг хараат бусаар, бие даан шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн Үндсэн хуулийн үзэл санааг илтэд зөрчсөн заалт болсон. Засаг даргад нэр дэвшигчийг тодруулах бүрэн эрх гагцхүү тухайн шатны орон нутгийн иргэдийн Хуралд харъяалагдах учиртай тул дээд шатны Засаг дарга болон Ерөнхий сайд санал болгох нь Үндсэн хуулийн маргаан дагуулна гэж онцлон мэдэгдэж байв.



УИХ-ын гишүүн Ш.Адьшаа

“Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллалаа. Тэрээр шүүх эрх мэдэл, гүйцэтгэх засаглалын эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдлийн тэнцвэртэй бодлогыг Үндсэн хуулийн хүрээнд хангах ёстой гэвч шүүхийн багц хуулийн төсөл, ажлын хэсгийн гишүүдийн оруулсан саналууд хуулийн үзэл баримтлалаасаа тэс өөр байгаа. Түүнчлэн Монгол Улсын ерөнхийлөгч бол Монголын ард түмнээс сонгогдсон шүүх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдлийг тэнцвэржүүлэх зорилготой ийм албан тушаалтан. Гэтэл хуулийн төсөлд бүх эрх мэдлийг УИХ дээр авчирч олонхоороо 62-ын бүлгээрээ асуудлыг шийддэг ийм л бодлого концепцыг оруулж ирсэнийг хүлээн зөвшөөрч болохгүй. Хуулийн төсөлд ерөнхийлөгчийн саналыг авсан мэтээр, АН-ын бүлгийн төлөөлөл цөөнхийн дуу хоолойг сонсохгүйгээр асуудалд хандаж байна. Монгол улс парламентын засаглалтай улс олонх, цөөнх асуудлыг олон талаасаа зөвлөлдөж зөвшилд хүрч шийддэг олонхын шийдвэрийг хүндэтгэдэг цөөнхийн үгийг сонсдог ийм зарчимтай. Шүүхийг зүгээр шүдгүй арслан мэт болгох юмыг хийж байна. Монголын ард түмний эрх ашиг, шударга ёс хууль ёсыг бэхжүүлэх шинэчлэл байх ёстой гэдгийг ажлын хэсгийн гишүүний хувьд хариуцлагатайгаар хэлье, энэ МАН-ын шийдвэр биш Монголын хөгжил дэвшил хүний эрх чөлөөний түүхийг, хөгжил дэвшлийг бүтээх гэж байгаа шүү” хэмээн байр сууриа илэрхийллээ.



УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаа. Тэрээр өөрийн зүгээс 16 зарчмын зөрүүтэй санал гаргаж, 12 саналыг дэмжүүлж хуулийн төсөлд тусгуулж батлууллаа. УИХ-аар хэлэлцэж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгт УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн ажиллаж, малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээний хамтын хэлэлцээрт тусган хэрэгжүүлж байх заалтыг төсөлд оруулах талаар санал гаргаж, Байнгын хорооны түвшинд дэмжлэг авсан болно. Түүнчлэн уурхайчид болон тээврийн жолооч нарыг хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгааг нь харгалзан “Хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-д хамруулах санал гаргаж шийдүүлж ажиллаа. Тэрээр “Өмнөговь аймагт ажиллаж байгаа тээврийн жолооч нарын хувьд эмч, эмнэлгийн ажилтан байхгүй, наад захын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ ч авч чадахгүй хэдэн зуун хүн ажиллаж, амьдарч байна. Уурхайчид, нүүрс тээврийн жолооч нар бол Монгол Улсын эдийн засгийн томоохон хэсгийг нуруундаа үүрч яваа маш чухал үүрэгтэй хүмүүс. Монгол Улсын эдийн засгийн 2 том тулгуур болох зэс, нүүрсний экспорт зогсвол манай эдийн засаг маш хүнд байдалд орно. Бид нүүрсээ экспортолж чадаж байвал улсын төсвийн гол бүрдүүлэлт түүгээр улс багш, эмч нар минь цалин, халамж, тэтгэвэр олгох төсвөө бүрдүүлэх гол үндэс юм шүү дээ” хэмээн байр сууриа илэрхийлсэн юм. УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн нь төрийн өмчийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.



УИХ-ын гишүүн Ц.Туваан

Хөдөлмөрийн тухай хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллаа. Тэрээр хөдөлмөрийн тухай хуулийн төсөлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг түлхүү анхаарч, аж ахуйн нэгж байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулах хувь хэмжээ нь өмчийн хэлбэр үл харгалзан адил байх, хэрэв ажиллуулахгүй тохиолдолд ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээг нэмэгдүүлж тогтоох, уг төлбөрийг төвлөрүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгуулах, санд төвлөрсөн хөрөнгө зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихэд зарцуулагддаг байх талаар зарчмын зөрүүтэй санал гаргаж зарим заалтыг дэмжүүлж ажиллав.

Хуулийн төслийн хэлэлцүүлэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ



Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн нийгэм, эдийн засаг, хууль, эрх зүйн орчинд чухал ач холбогдол, нөлөө үзүүлж болзошгүй хууль тогтоомжийн төслүүдээр намын гишүүд, дэмжигчдийн хүрээнд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг уламжлал тогтоогоод байна. Эхний хэлэлцүүлгийг 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслөөр Төрийн ордонд зохион байгуулж, УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл удирдан явууллаа.

Энэхүү хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат, УИХ-ын гишүүн Н.Ганибал, Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны гишүүд, дэмжигчид, Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчид, мэргэжлийн холбоод, хуульч, судлаачдын өргөн бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт оролцогчид хуулийн төслийн агуулга, дэвшилттэй болон хэрэгжих боломжгүй заалтын талаар саналаа илэрхийлж, хуулийн төслийг сайжруулах тал дээр дараах олон чухал санал, дүгнэлтийг гаргаснаас товч тоймлон хүргэе.

№	Хэлэлцүүлгийн үед гарсан санал	Үндэслэл, тайлбар
1	Дээд шатны ЗД, ЕС-д буцаах эрх нь байгаа хэрнээ нэр дэвшүүлэх санал гаргах бололцоо олгосныг хасах	Хурал, намын бүлгүүд нэр дэвшүүлдэг байтал ҮХ-ийн суурь үзэл санааг зөрчсөн. ҮХ-ийн 60.2-т “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, ...” гэж заасанд нийцэхгүй.
2	Орон нутгийн иргэд ЗД-аа олонхиороо сонгох боломжийг бүрдүүлэх	Орон нутгийн удирдлагыг дээд шат нь томилж болохгүй. Эсрэгээрээ, нийт иргэдийн олонхийн санал авсан хүн ЗД болдог зарчим үйлчлэх ёстой.
3	Пропорциональ тогтолцоог Сонгуулийн тухай хуультай уялдуулж гаргаж ирэх	Орон нутгийн хуралд сонгогдож байгаа хүмүүс пропорциональ системд шилжихгүй бол жижиг нам нэг ч хүн ажиллуулахгүй намын нэрээр нийт саналын талыг авдаг байж болохгүй.
4	Нийслэлийн ИТХ-ыг дүүргийн ИТХ-аас сонгож байгуулах заалтыг хасах	Нийслэл, дүүргийн байр суурь, ашиг сонирхол өөр байдаг. Хооронд нь холихоор эрсдэлтэй байдалд хүргэнэ.
5	Сумын ИТХ-д улс төрийн нам нэр дэвшүүлэхгүй гэснийг хасах	Хуулийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдах тул ҮХЦ дээр унана. Орон нутгийн сонгуульд улс төрийн намыг оролцуулахгүй гэвэл зарчмаа хатуу барья.
6	ЗД-д нэр дэвшигч нь тухайн ИТХ-ын төлөөлөгч байна гэсэн заалт нэмэх	ЗД болох нэр дэвшигч ядаж тухайн хороо, нэгж, дүүрэг, аймагтаа сонгогдсон төлөөлөгч байх ёстой. Тэгэлгүй дээрээс шууд томилохоор нутгийн өөрөө удирдах ёс алдагдана.
7	Сум, хороо, баг хэдэн хүнтэй байхыг зааж өгөх	Сумын дайтай хороотой болсон, БГД-т 14,000-15,000 хүнтэй хороо байна. Өрхийн эмнэлэг, цагдаа, сургууль, цэцэрлэг иргэдэд хүрч ажиллах боломжгүй нөхцөл үүсдэг.
8	ЗД-ын үүрэг гүйцэтгэгчийн хугацааг 3 сараар хязгаарлах	ЗД огцроод, түүний үүрэг гүйцэтгэгч төрийн ажлыг 4 жил цалгардуулдаг.
9	“Нутгийн удирдлагын төлөөлөл” гэзд нийтийн эрх зүйн субъект бий болгосныг хасах	ҮХ-ийн бус субъект. 330 сумтай гэхээр 300 гаруй төлөөлөгчөөс бүрдсэн давхар хурал бий болно. Орон нутгийн төсөв боловсруулах хурлын эрхээ булаацалдана.
10	Дүүрэг, сумын чиг үүрэг гэхээр ЗД хэрэгжүүлэх, эсвэл ИТХ хэрэгжүүлэх эсэх нь ойлгомжгүй	“Сумын чиг үүрэг” гэзд хуулийн этгээд ч юм шиг, нэгж бол хил хязгаар байх ёстой. 61-64-р зүйлд ЗД-ын чиг үүрэг гэзд тусдаа байна.
11	“Зөвлөл” нь өмнөх хуралдааны дарга, “аравт”, “хэсгийн ахлагч” нараас бүрдэнэ гэснийг хасах	“Аравт”, “хэсгийн ахлагч” нар нь ЗД-аас томилогдсон хүнд гарууд байгаа. Гүйцэтгэх удирдлага буюу “зөвлөл”-ийг МАН-ынхан тойрон хүрээлэгчдээрээ бүрдүүлэх нь.
12	ИНХ-ын дарга, ЗД-ыг нэр дэвшүүлэхдээ сонгуулийн зарчмаар зохион байгуулах	100 хүн оруулаад хаалгаа түгжчихдэг. Цагдаагаар хамгаалуулаад, ирц бүрдсэн гэх шалтгаанаар оруулдаггүй. Бидэнд 50%-д баг, хорооны ЗД-аа нэр дэвшүүлэх асуудлыг шийдэх боломж байна.

13	АМНАТ-ын 10%-20%-ийг сум, аймагт нь олгохыг дагаж мөрдөх журмын хуулиар оруулах	ҮХ-ийн өөрчлөлтөөр 59.1-д нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг нийцүүлэн хуулиар тогтоож болно гэж заасан.
14	Орон нутгийн өмчит компаниудын засаглалыг хэрхэн удирдах чиглэлээр тусгаж өгөх	ОН-ийн өмчит компаниудын засаглалын асуудлыг бүх хуульд орхигдуулсан. Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд байдаггүй. Цаашдаа ОН-ийн өмчит компаниуд их ашигтай ажиллана.
15	Сум, хороо, баг хэдэн хүнтэй байхыг тусгаж өгөх	1000-аас доош хүн амтай 19 сум байна. Гэтэл сумдад зарцуулах ёстой бүх зардал очдог. Дорноговьд 1000-аас доош хүн амтай суманд 3 дахь соёлын төвөө барьж байна.
16	Сумын статусыг дээш, доош болгодог зохицуулалтыг шигтгэж оруулах	Сумаас иргэд нь зугтаагаад байвал муу ажилласан гээд статусыг нь доошлуулаад баг болгодог. Аятайхан хөгжүүлээд ирэхээр хөрөнгө оруулалт, бизнесийн боломжуудыг нээж өгдөг жишиг бий.
17	Орон нутгийн чиг үүрэг хэсэгт “боловсрол”-ыг нэмж оруулах	Орон нутгийн сургууль, цэцэрлэгийн дарга, эрхлэгчийг нутгийн удирдлага томилдог. Сумын сургуулийг хэний нэрэмжит болгох вэ гэдэг асуудал гарч байсан.

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ



Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүн, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн С.Одонтуяа удирдан явуулсан. Хуулийн төслийн хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны удирдлагууд, холбогдох газрын дарга нар, Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны гишүүд, Барилга, хот байгуулалтын бодлогын зөвлөлийн гишүүд, Нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, Монгол Улсын Ерөнхийлөгчийн уг асуудлыг хариуцсан орон тооны бус зөвлөх, хуульчид оролцож санал бодлоо солилцлоо.

Хэлэлцүүлэгт оролцогчид Барилга хот байгуулалтын яамны төлөөллөөс сонирхсон асуултаа асууж, хуулийн төсөлд саналаа илэрхийллээ.

Хэлэлцүүлгийн явцад гарсан санал, дүгнэлтээс

Оролцогч Б. Энхбайгаль:

Хуулийн төсөлд Улсын чанартай хот, аймгийн хоорондын уялдаа ямар байгаа, Засаг захиргааны нэгжээс ямар чиг үүргийн шилжүүлж болох тухай нарийвчилсан заасан, Тосгоны болон сумын удирдлага хоорондын чиг үүргийн уялдаа холбоо ямар байх, Хотын хил хязгаарыг яаж тогтоох, Аймгийн төвийг тойрсон том эдэлбэр газартай сумын статусыг өөрчлөх эсэх, бүс нутгийн төлөвлөлтийн асуудлыг дагаж хот, суурин хөгжих боломжийг бүрдүүлэх чадаж байгаа эсэх талаар асууж, хариулт авлаа.

Оролцогч Н.Тэгшбаяр:

Усны болон бусад аюулгүй байдлын асуудал, Олон улсын стандарттай нийцүүлэх талаар хуулийн төсөлд зүйл, заалт тусгасан эсэх, Хот суурин газрын дахин төлөвлөлтийг газар зохион байгуулалттайгаа яаж уялдуулах, хэрхэн тусгасан талаар, Хот байгуулалт, кадастр хот байгуулалтын мэдээллийн сан нь улсын мэдээллийн нэгдсэн сан болон бусад мэдээллийн сантайгаа уялдаж чадаж байгаа эсэх талаар асуулаа.

Оролцогч Г. Отгонбаатар:

Хан-Уул дүүрэг Зайсан орчим, шинэ Яармаг хороолол тэр чигээрээ суурьшлын бүс болсон боловч тэнд нэгдсэн төлөвлөлт алга тийймээс нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжууд нь дутагдаж, сургууль цэцэрлэгийн хүртээмж байхгүй болсон. Сургууль, цэцэрлэг нь ойрхон байх юм бол түгжрэлийн асуудал бас тодорхой хэмжээнд буурах учир орон сууцны хорооллыг цогцоор нь сургууль цэцэрлэгийнхээ асуудалтай нь цуг шийдээд ерөнхий төлөвлөгөөнд тусгаад батлаад явах боломжтой байна гэдэг санал дэвшүүллээ.

Оролцогч Хүрэлбат:

Төсвийн хөрөнгө оруулалтаар янз бүрийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг барьж байгуулахаар төлөвлөдөг. Гэвч газар чөлөөлөлтийн асуудлыг шийдэхгүй байж тухайн ондоо хийгддэггүй төсөл арга хэмжээг олноор төлөвлөж байгаа асуудлыг хуулийн төсөлдөө хэрхэн тусгасан талаар сонирхлоо.

Оролцогч Энхбат:

Дагуул хот, хаяа хоттой холбоотой асуудлыг зохицуулж болох эсэх, Улаанбаатар хотыг ямар концепциор хөгжүүлэх, зохион байгуулалтыг сайжруулах талаар тусгасан зохицуулалт байгаа эсэх талаар тодруулж, хотын ерөнхий төлөвлөгөө зөрчсөн этгээдийн хариуцлагыг чангаруулах талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг анхаарууллаа.

Оролцогч Д.Оросоо:

Орон сууцны бүс, үйлдвэрлэлийн бүс, хөдөө аж ахуйн, зуслан гээд энэ бүстэйгээ холбогдуулаад газар олголт нь яаж шийдэгдэх, Засгийн газар аль чиглэлийн бүсийн газруудаа, аймаг, нийслэлийн Засаг дарга аль газрыг, сум, дүүргийн Засаг дарга аль газрын асуудлыг шийдэх талаар асууж, цаашлаад газрын асуудлыг оновтой шийдвэрлэх талаар санал өглөө.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 5 дугаар сард орсон нэмэлт, өөрчлөлттэй уялдуулж Засгийн газраас Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. Шүүхийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд Үндсэн хуулийн өөрчлөлтөд нийцүүлсэн, хараат бус шударга шүүхийг бий болгох, шүүхийн тогтолцоог боловсронгуй болгох багц хуулийн төсөл боловсруулсан гэх боловч мөн чанартаа Үндсэн хуультай нийцээгүй, УИХ дахь байнгын хорооны төлөөлөл бүхий Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй буюу улс төрчдөөс хараат байх, шүүгчид нөлөөлөх бүрэн боломжтой байх төсөл өргөн барьсан. УИХ дахь Ардчилсан намын бүлэг анх өргөн барьсан төсөлд маш шүүмжлэлтэй хандаж, уг төслийг сайжруулах, шударга, хараат бус шүүх, шүүгчтэй байх, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлж чадах хуулийг батлуулахын төлөө олон талын оролцоог хангасан хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан саналуудыг нэгтгэж Шүүхийн тухай хуулийн ажлын хэсэгт хүргүүлсэн.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг 2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр Төрийн ордонд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт УИХ дахь АН-ын бүлгийн гишүүд, Шүүхийн ёс зүйн хорооны төлөөлөл, МУИС-ийн ХЗС-ийн багш, эрдэмтэд, судлаачид, хуульчид, өмгөөлөгчид, Хуульчдын холбооны төлөөлөл, Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчид, АН-ын ҮБХ-ны гишүүд оролцлоо. Хэлэлцүүлгийг УИХ дахь АН-ын бүлгийн дарга Д.Ганбат удирдан явуулж, оролцогчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, судлаачдаас сонирхсон асуултаа асууж, хуулийн төсөлд саналаа илэрхийллээ.



Хэлэлцүүлгийн явцад гарсан санал, дүгнэлтээс

Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн Т.Мөнх-Эрдэнэ:

Шүүхийн сахилгын хорооны эрх зүйн байдлыг авч үзэхдээ, бүтэц бүрэлдэхүүнийг хэрхэн бүрдүүлэх гэдэг зохицуулалтыг авч үзэхээс өмнө олон улсын байгууллагын хийсэн түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудыг зайлшгүй авч үзэх шаардлагатай. Засгийн газрын өргөн барьсан хуулийн төслийг анализ хийж судалж үзэхэд УИХ-ын байнгын хорооны оролцоог нэлээд хүчтэй байлгах мөн Засгийн газрын оролцоо байхаар

тусгаж өгсөн байгаа нь шүүхэд улс төрчийн нөлөө маш хүчтэй байхын илрэл. Тэгэхээр энэ хуулийн төсөлд судлаач хүний хувьд шүүмжлэлтэй хандаж байгаа. Монголын хуульчдын холбоо буюу төрөөс хараат бус мэргэжлийн холбооноос Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг бүрдүүлж, томилоход оролцоотой байхаар хуульчилж өгссөн нь зарчмын хувьд зөв гэж харж байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш А.Эрдэнэцогт:

Засгийн газрын төсөл дээр сайжруулах зүйл маш их байна, ярих юм ч их байна. Цаг бага байгаа учир олон юм ярьж чадахгүй байх. Шүүхийн хараат бус байдлын цаана шүүгчийн сахилга, хариуцлага дагалдаж явах ёстой байдаг. Сахилга хариуцлага гэдэг нэрийн дор шүүгчид нөлөөлөх зүйл байж болохгүй. Шүүгчийг ажлын нь хийлгэсэн шиг хийлгэж, хянасан шиг хянах ёстой. Тэгэхдээ сахилгын хорооны бүрэлдэхүүнд хууль тогтоох гүйцэтгэх эрх мэдэл түлхүү оролцоотой байхаар тусгасан. Өөрөөр хэлбэл сахилгын хороогоор дамжиж шүүгчид нөлөөлөх гэсэн оролдлого байна уу гэж хардахаар бүрэлдэхүүнийг нь бүрдүүлэхээр зохицуулж өгсөн байсан. Тэгэхээр нь энэ нь өөрөө дэвшилттэй зохицуулалт болж өгч чадахгүй байна. Шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо тэнцвэрийг хангах аль нэг улс төрийн институцээс хараат биш байлгах үзэл баримтлалыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр удирдлага болгосон гэтэл Засгийн газрын өргөн барсан шүүхийн тухай хуулийн төсөл үүний эсрэг хийсэн байгаа. Өөрийнхөө эрх мэдлийг нэмэгдүүлсэн хууль баталж болохгүй гэдгийг Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн журамд заасныг Шүүхийн хуулийн төсөл боловсруулагчид зөрчсөн байна.

Хуульч Д.Оросоо:

Хуулийн төсөлд шүүгчийн зөвлөл гэдэг шинэ ойлголтыг бий болгохдоо анхан, давж заалдах шатны шүүхээс төлөөлөл, УДШ-ийн нийт шүүгч гэсэн бүрэлдэхүүнтэй байхаар заалтууд оруулж ирсэн нь шүүх эрх мэдлийг улсын дээд шүүхийн хараат тэр дундаа УДШ-ийн ерөнхий шүүгчийн хараат байдалд оруулах байнгын ажиллагаатай механизм гаргаж ирж байгааг хүлээн зөвшөөрөхгүй. Хэрэв ийм зөвлөлтэй болох гэж байгаа бол нийт шүүгчдийг оролцуулах нь зөв. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг томилох асуудлыг хийнэ сахилгын хорооны гишүүдийг томилох ажлыг хийнэ өөр хуулиар энэ дотор шургуулаад оруулчхаар юм юу байна байнга ажиллуулаад дээд шүүхийн хэдэн шүүгчийн лоббигоор шүүхийн үйл ажиллагаа явагдахаар болоод байна. Тиймээс хэрэв шүүгчийн зөвлөл гэж байгуулах бол нийт шүүгч хамрагдах шаардлагатай гэдэг санал байна.

Хуульч Д.Отгонбаяр:

Монгол улсад нийт 520 орчим шүүгч байна тэд нараас төлөөлөл нэрээр 200 хүн суугаад ерөнхий зөвлөлийн гишүүдээ сонгодог сахилгын хорооны гишүүдээ сонгодог мэргэжлийн хорооны гишүүдээ сонгодог шүүгчийн ёс зүйн дүрмийг баталдаг ийм эрхийг эдлэх гэж байна. Манайд сонгууль яаж явагддаг билээ, манай энэ хүнийг сонго гэдэг яг улс төрийн намын их хурал шиг ийм бүтэц шүүхэд байж болохгүй. Энэ бол шүүгч нарыг хуваах асуудал үүсэж байна. Одоо тэр дүүрэг дээр манай тэрийг сонгоно шүү гээд шүүх тэр чигтээ бүлэглэлд хуваагдаад ерөнхий шүүгчийн төлөө явдаг асуудал гажуудал үүсэхээр байна.

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдийн хамтдаа санаачлан боловсруулсан хуулийн төслүүд



Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд хууль санаачлах эрхээ хэрэгжүүлж өнөөдрийн нийгэмд зайлшгүй зохицуулах шаардлага зүй ёсоор үүсээд байгаа хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж, 4 хуулийн төслийг УИХ-д хэлэлцүүлэхээр өргөн барьж, зарим хуулийн төсөлд Засгийн газраас санал авч, хуулийн төслийг хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.

ХУУЛЬ САНААЧЛАХ ЭРХТЭЙ СУБЪЕКТҮҮД МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИАС

ЕРӨНХИЙЛӨГЧ

38.2.Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилна.

УИХ-ЫН ГИШҮҮН

БҮХ ХУУЛЬ САНААЧЛАХ

38.1.Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачилна.

ЗАСГИЙН ГАЗАР

38.3.Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна.


КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл санаачлан боловсруулж өргөн барьсан.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар цар тахлын улмаас гадаадад гацсан иргэд эх орондоо буцаж ирэх эрхээ баталгаатай эдлэх, цар тахлын үед халдварт өвчнөөр өвчилсөн буюу өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал /халдашгүй байдал/-ыг хамгаалагдах баталгаа бүрдэх, цар тахлын эсрэг хэрэгжүүлж байгаа арга хэмжээ тухайн нөхцөл байдалд тохирсон, зайлшгүй, бодитой байх, иргэний үндсэн эрхийг хязгаарласан байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэх, оюутан сурагчдын дотуур байрны төлбөрийн асуудлыг шийдвэрлэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах иргэний эрхийг хөндөхгүй байх, иргэд шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авах, цар тахлын улмаас иргэдэд тулгарч буй зээлийн эргэн төлөлттэй холбоотой санхүүгийн бэрхшээлийг шийдвэрлэхэд бодлогоор дэмжих, цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орнуудаас өгч буй хандив, хөнгөлөлттэй зээл, тусламжийн зарцуулалтыг ил тод болгох, цар тахалтай холбоотой үнэн зөв, бодит мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд нэгдсэн байдлаар шуурхай, хүртээмжтэй авах талаар практикт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хууль тогтоомжийн тодорхойгүй, зохицуулалтгүй байдлыг арилгах бөгөөд үйлчлэх хугацаа дуусаж буй хуулийн үйлчлэх хугацааг сунгаж буй хуулийн төсөл юм.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



Ардчилсан намын бүлэг “Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн. Шилэн дансны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр таван сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлдэг байсныг нэг сая болгох, мөн хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зааж өгөхөөр боловсруулсан.

Ардчилсан нам шилэн дансны тухай хуулийг 2015 онд санаачлан батлуулсны үр дүнд дэлхийн аль ч өнцгөөс хүссэн хүн бүхэн төрийн болон төрийн өмчит байгууллагын төсвийн зарцуулалтыг харах, хянах, түүнтэй холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлэх боломжтой болсон хэдий ч зөрчил гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг зохицуулж өгөөгүйгээс хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна.

Тиймээс Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачилж нэг сая төгрөгөөс дээш төсвийн орлого, зарлага, мөнгөн гүйлгээ, тайлагнах үйл ажиллагаа болон өр, зээл, батлан даалт, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод, иргэдэд ойлгомжтой, шуурхай мэдээлэх, хуульд заасан үйл ажиллагаагаа хэрэгжүүлээгүй байгууллага, хариуцсан албан тушаалтанд тодорхой хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгаж өгсөн.

Хуулийн төсөл батлагдвал төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн зарцуулалтын үр өгөөж дээшилж, хариуцлага сайжирснаар татварын төлөгчдийн хөрөнгөөр бүрдэх төсөв нээлттэй ил тод болж, иргэд өөрсдөө хянах боломж бодитоор бүрдэх юм.

ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ДООД ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



Өндөр насны тэтгэврийн доод хэмжээг 500.000 төгрөг болгон нэмэгдүүлэх зорилгоор Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд хуулийн төсөл санаачлан боловсруулж Засгийн газраас санал авахаар хүргүүлээд байна.

Үндэсний статистикийн хорооноос Дэлхийн банктай хамтран хоёр жил тутамд танилцуулдаг ядуурлын төвшин 2019 оны үзүүлэлтээр Монгол Улсын нийт хүн амын 28.4 хувь буюу 904,900 хүн ядуу амьдарч байгааг тогтоожээ. Өндөр насны тэтгэврээр амьдардаг ахмадуудын олонх нь ядуу иргэдийн тоонд хамаарах болсныг амьдралын бодит нөхцөл, тэдний авч буй тэтгэврийн нь хувь хэмжээ бүрэн нотлохоор байгаа бөгөөд нөгөө талаас гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч буй энэхүү эмгэнэлтэй үзүүлэлт нь Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг салбар хуулиудаар зөв хэрэгжүүлж амилуулах, хувийн хэвшил, бизнес эрхлэгчидтэйгээ харилцан ойлголцож, байгалийн баялгаа нийт иргэдийн сайн сайхны төлөө хүртээмжтэй, зүй зохистой ашиглах туйлын шаардлага тулгарсныг нотлон харуулж байгаа юм.

Өндөр насны тэтгэврийн доод хэмжээг таван зуун мянган төгрөгт хүргэн нэмэгдүүлж олгоход шаардлагатай санхүүжилтийн эхний эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон, стратегийн ач холбогдол бүхий ордуудын төрийн эзэмших хувийг шинээр тогтоох замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, түүнээс төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргаж шийдвэрлэх бөгөөд цаашдын эх үүсвэрийг газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх эрх бүхий Үндэсний баялгийн санг хуулиар байгуулж, уг санд төвлөрсөн хөрөнгөөс тухай бүр шийдвэрлэхээр тооцож байна.

Хуулийн төсөл батлагдсанаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байхаар ашиглах тухай заасан Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн шаардлага биелэх, ахмад настнууд байгалийн баялгийн үр өгөөжөөс хүртэж амьдралын наад захын хэрэгцээгээ хангахуйц тэтгэврийн орлоготой болох нөхцөл бүрдэнэ.

Бүлгийн гишүүдийн санаачлан боловсруулсан хуулийн төслүүд:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



УИХ-ын гишүүн, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл санаачлан боловсруулж УИХ-ын даргад 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр өргөн барьсан.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой уялдуулж Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудыг шинэчлэн баталж дагаж мөрдөж байгаа. Уг хуулиудаар Улсын Их Хурлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг хэлэлцэх үе шат, байнгын хороодын тоо нэмэгдсэн учир УИХ дахь намын бүлгүүд бодлогоо боловсруулахад нь зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албаны ажлын чанар, гүйцэтгэлд нөлөөлж байна.

Улсын Их Хурлаар чанартай, зөрчил, хийдэлгүй хууль тогтоомж батлахын тулд бүлгийн ажлын алба гол үүрэг гүйцэтгэдэг тул ажлын албыг хангалттай тооны ажилтантай байлгахаар хуулийн төсөл боловсруулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл боловсруулан Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн.

Түүний санаачилсан хуулийн төслийн гол үзэл санаа нь иргэн тэтгэвэр тогтоолгохдоо тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 5 жилд төлсөн шимтгэлээс тооцож гаргасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэврээ тогтоолгох юм. Өөрөөр хэлбэл, иргэн тэтгэвэр тогтоолгохдоо аль өндөр шимтгэл төлсөн дараалсан 5 жилийн дундаж цалингаас тэтгэврээ тогтоолговол тэтгэвэр авагчид ногдох тэтгэвэр өндөр байх юм.

Эрх баригчид 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг тогтоохдоо тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн дараалсан 7 жилийн дундаж цалингаар тогтоохоор өөрчилсөн. Энэхүү өөрчлөлтөө тайлбарлахдаа 7 жилийн дунджаас тэтгэврийн дунджийг бодож тогтоовол өндөр тогтоно, олон жил шимтгэл төлснөөр авах тэтгэврийн хэмжээ нь нэмэгдэнэ гэж буруу тайлбарлаж байна.

Гэтэл бодит тооцооллоор иргэний өөрийн сонгосон 5 жилийн цалингийн дунджаас тооцоход авч байсан цалингийн хэмжээнээс хамаарч 80-160 мянга орчим төгрөгийн өндөр тогтоогдоно гэдгийг тооцоолсон зөрүүг харуулж болохоор байна.

5 жилийн дунджаар	1,218,898.31	1,151,758.29	1,102,720.36	1,033,184.81	942,033.91
7 жилийн дунджаар	1,145,536.20	1,063,729.92	992,540.93	910,241.77	816,218.94
Зөрүү	**73,362.10**	**88,028.37**	**110,179.42**	**122,943.04**	**125,814.96**
	6.02%	**7.64%**	**9.99%**	**11.90%**	**13.36%**

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГТ ШИЙТГЭГДСЭН ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж “Зөрчлийн хэрэгт шийтгэгдсэн иргэн, хуулийн этгээдэд өршөөл үзүүлэх тухай” хуулийн төсөл санаачлан Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн байна.

Ковид-19 короновирус цар тахлын улмаас иргэдийн амьдрал, эдийн засгийн хүнд байдалд байна, олон аж ахуй нэгжүүд үүд хаалгаа барьж дампуурлаа. Энэ цаг үед Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдсэн зарим иргэд, хуулийн этгээдүүд шийтгэлийн торгуулиа төлж чадахгүй эдийн засгийн хувьд хүнд байдалд байна. Иргэд өр зээл тавиад торгуулиа төлөхөд энэ нь амьдралын доройтолруу түлхэх, иргэдийн амьдралын чанарыг муутгах зэрэг олон зохисгүй үр дагавар бий болгож байна.

Монгол улсад төдийгүй дэлхий дахинд Ковид-19 короновирус цар тахлын улмаас эдийн засгийн хүнд байдалд байгаа иргэдээ туслах, аж ахуй нэгжүүдээ төрөөс нэг удаагийн бодит дэмжлэг үзүүлэх шаардлага үүссэн.

Энэхүү хуулийн төсөл нь улсад болон бусдад ноцтой хохирол учруулаагүй, нийгэмд аюул заналхийлээгүй аливаа зөрчлийн хэргийн улмаас 10 сая төгрөгөөс доош мөнгөн дүнгээр шийтгэгдэж, түүнийгээ төлж барагдуулж чадахгүй эдийн засгийн хүнд байдалд байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдэд нэг удаа өршөөл үзүүлэхээр зохицуулсан төсөл юм.

МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын амаргүй нөхцөл байдалтай зэрэгцэн 6 аймагт өвөлжилт хүндэрч, нийт нутгийн 40 гаруй хувьд зуд болох эрсдэлтэй байгааг холбогдох мэргэжлийн байгууллагаас анхааруулсан. Цар тахлын улмаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хүндээр тусч байгаа төдийгүй бүх нийтийн бэлэн байдал зарлаж, орон нутгийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан өдөр тутмын хүнсний болон ахуйн хэрэгцээний ханган нийлүүлэлтэд бэрхшээл тулгарч байна.

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг мал аж ахуйн салбар бүрдүүлдэг мөн тээвэр, худалдаа үйлчилгээ зэрэг эдийн засгийн томоохон салбарт 240.0 гаруй мянган иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгч үйл ажиллагаа явуулдаг. Эдийн засаг, хүн амын хөдөлмөр эрхлэлтэд томоохон хувь нэмэр оруулж байгаа эдгээр салбарт ажиллагсдын өдөр тутмын орлого тасарч хүнд байдалд байгаа тул төрийн зүгээс нийгмийн баталгааг нь сайжруулах чиглэлээр дорвитой арга хэмжээ авах зайлшгүй шаардлага тулгарсан.

Ийм учир Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн үйлчлэлийг 2023 он хүртэл сунгаж, малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрагдах, улмаар даатгалын үр шимийг хүртэх боломжийг үргэлжлүүлэн олгох ач холбогдолтой хуулийн төсөл юм.

ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж “Хамтын тэтгэврийн тухай” хуулийн төсөл санаачлан өргөн барилаа. Хамтын тэтгэврийн тухай хуулийн гол үзэл санаа нь олон жил хамт амьдарсан, тэтгэвэр авах эрх үүссэн эхнэр, нөхрийн хэн нэг нь нас барсан тохиолдолд үлдсэн гэр бүлийн гишүүнд эхнэр эсхүл нөхрийн авах байсан тэтгэврийн тодорхой хувийг олгох юм. Хамтын тэтгэврийн тухай хуулийг Тэжээгчээ алдсаны тэтгэврийн тухай хуультай адилтган ойлгож болохгүй. Хамтын тэтгэвэр авах эрх үүссэн иргэнд олгох хамтын тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод төвшин, үнэ ханшны өөрчлөлттэй уялдуулан Засгийн газар жил бүр тогтоох бөгөөд хамтын тэтгэвэр нь нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээний 30 хувиас багагүй байхаар хуулийн төсөлд тусгасан. Гэр бүлийн өндөр настан хамтдаа тэтгэвэр авч байгаад нэг нь нас барах тохиолдолд үлдэж байгаа ганц бие ахмад настан нэг хүний тэтгэврээр амьжиргаагаа залгуулахад хүндрэлтэй. Түлээ нүүрс, орон сууц, ус, байр, цахилгааны төлбөр, амьжиргааны наад захын зардал зэрэг нь ганц бие өндөр настныг амьжиргааны эрс доройтолд хүргэж байна. Энэ хуулийн төсөл нь өндөр настнуудыг дээрх хүнд нөхцөлд орохоос сэргийлэх зорилготой нийгмийн хамгааллын арга хэмжээ гэж дүгнэж байна. Хамтын тэтгэврийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр цаашид тогтвортой гэр бүлийн тоо нэмэгдэх, эрүүл хамтдаа өтлөх болон ганц бие ахмад настны амьжиргааны баталгаа хангагдах зэрэг олон ач холбогдолтой гэж үзэж байна

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАЛДВАРЫН ГОЛОМТОД БОЛОН ЭРСДЭЛ БҮХИЙ НӨХЦӨЛД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЯВЦАД ХАЛДВАР АВСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД НЭГ УДААГИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэх явцад халдвар авсан төрийн албан хаагчид нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай хуулийн төсөл боловсруулан 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн төслийн гол агуулга нь Коронавируст халдвар /ковид-19/ Монгол Улсад бүртгэгдэн



гарснаас хойш халдварын тохиолдлын тоо өдрөөр нэмэгдэж байгаа бөгөөд цар тахлын халдварын өндөр эрсдэлтэй нөхцөл бүхий хилийн боомт, шалган нэвтрүүлэх товчоо, төмөр замын өртөө, нисэх буудлын хяналтын цэгүүд, иргэдийг тусгаарлах байр, эмнэлэг, нийтийн хэв журам сахиулах, эргүүл хяналтын чиглэлээр төрийн холбогдох байгууллагын нийт 15.000 гаруй ажилтан, алба хаагч халдварын голомтот бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа. Монгол Улсын хэмжээнд коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах хууль тогтоомжийг Улсын Их Хурал, Засгийн газраас цаг алдалгүй батлан гаргаж байгаа боловч тархалтын өндөр эрсдэлтэй бүсэд үүрэг гүйцэтгэж буй эмч, эмнэлгийн ажилчид, төрийн холбогдох байгууллагын алба хаагчдад нэг удаагийн мөнгөн тэтгэмж өгөх эрх зүйн орчинг бүрдүүлэх, эрүүл мэндээрээ хохирсон төрийн албан хаагчдад бодитой дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг харгалзан хуулийн төсөл боловсруулж батлуулсан.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулснаа УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барилаа.

Уг хуулийн төсөл батлагдсанаар бизнес, эдийн засгийн харилцааг хурдасгах, мөн хувь хүн, хуулийн этгээдийн нууцад хамаарахгүй төрийн мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж байгууллага, компаниуд авч ашиглах боломжийг бүрдүүлэх, мэдээллийг олон нийтэд гаргаж өгөх боломж бүрдэх юм. Хуулийн төсөл батлагдсанаар иргэд, аж ахуйн нэгжүүдийн мэдэх эрхийг баталгаажуулж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дэмжих нөхцөл болно. Ингэснээр иргэдийн бизнес эрхлэх сонирхол нэмэгдэхийн зэрэгцээ уг мэдээллийг ашиглан Монголд бизнес эрхлэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг урамшуулж, эдийн засгийн солонгоролыг дэмжинэ. Боловсруулалт, шинжилгээ хийх өгөгдлийг бий болгож өгснөөр мэдээлэл боловсруулалт, өгөгдөлтэй ажиллах дата майнинг чиглэлд ахиц гарч, эдийн засгийн хямрал гүнзгийрч буй нөхцөл байдалд төсвийн орлогын нэгэн шинэ боломжийг бүрдүүлэх төсөл гэж үзэж байна.

Бүлгээс гарсан шаардлага, мэдэгдэл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-16-30
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.10.06 № 22

танай _____-ны №_____-т

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

Шаардлага хүргүүлэх тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн сурталчилгаа явагдаж байгаа бөгөөд санал хураалтын хугацаа ойртсоор байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулж явуулахад Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 15 дугаар зүйл болон Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

- Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016, 2020 оны ээлжит сонгуулиудаар гарч байсан зөрчил, дутагдлуудыг дахин гаргуулахгүй байх, арилгах;
- Сонгогч хууль зөрчин дахин санал өгдөг асуудлыг арилгах зорилгоор 1992-2012 оны сонгуулиудад ашиглаж байсан санал өгсөн сонгогчийн хуруунд бэхэн тэмдэглэгээ хийх, түүнтэй холбоотой дүрэм, журмыг нэн даруй баталж мөрдүүлэх;
- Үндсэн хуулиар баталгаажуулсан Үндсэн хуулийн байгуулал болох нутгийн өөрөө удирдах ёсыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх;
- Эрүүгийн хуулийн 14 дүгээр бүлэгт заасан “Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг” үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг болно.

Та бүхэн үйл ажиллагаа, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бусад улсын сайн туршлагаас өөрийн орны онцлогт тохируулан хэрэглэх боломжтой бөгөөд дэлхийн зарим улс орнуудад хэрэглэгддэг сонгуулийн санал хураалтын доор дурдсан сайн туршлага, харилцаа, зохион байгуулалтын арга хэмжээг Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулиас өмнө бэлтгэл ажлыг хангаж энэ удаагийн сонгуулийн санал хураалтын ажилд нэвтрүүлэн, зохион байгуулж ажиллахыг шаардаж байна. Үүнд:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.11 дэх заалтыг хэрэгжүүлэхдээ сонгогчийн гарын үсэг яг тухайн сонгогчийн гарын үсэг мөн эсэхийг нягтлах, ингэхдээ банкны баталгаат

Албан шаардлага гэж хууль, тогтоомжийг чанд мөрдөх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар шуурхай арга хэмжээ авахыг байгуулага, албан тушаалтанд мэдэгдэж хүргүүлсэн Захирамжлалын баримт бичиг юм. Мэдэгдэл Тодорхой асуудлаар үзэл бодол, байр суурия нийтэд танилцуулах зорилгоор гаргасан баримт бичиг Мэдээлэл-лавлагааны баримт бичиг юм. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтанд дараах шаардлагуудыг хүргүүлсэн.

гарын үсэгтэй нь адилхан байгаа эсэхийг нягтлан шалгадаг тогтолцоо, механизмыг бүрдүүлэх;

2. Сонгогч саналаа өгөхөөс нь өмнө санал өгөх эрхийг нь тайлбарлаж, Сонгуулийн тухай хууль, тогтоомжийг зөрчвөл эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээх хуулийн зохицуулалттай гэдгийг урьдчилан сануулж баталгаажуулах;

3. Сонгогчийн хурууны хээг сонгогчдын нэрсийн жагсаалтын цахим бүртгэлтэй тулгаж зөрчилгүй гэдгийг нь шалгах;

Хэдийгээр сонгуулийн санал авах өдөр ойрхон байгаа ч дээрх шаардлагуудыг хүлээн авч, хэрэгжүүлэх талаар идэвхи, санаачилга гаргаж ажиллана уу. Шаардлагын хариуг 2020 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Хувийг: Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга,
Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар нарт тус тус хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

БҮЛГИЙН ДАРГА Д.ГАНБАТ

ТУС Х 1396

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-16-30
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.10.08 № 23

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Анхааруулга хүргүүлэх тухай

Монгол Улсын чуулганы 2020 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн “Намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаар хийх мэдээлэл”-ийг сонсохдоо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн үйлдэл гаргалаа. Тухайлбал, дээрх хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1-д “Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон цаг үеийн тулгамдсан бусад асуудлаар Ерөнхий сайд сар бүрийн 1 болон 3 дахь долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанд тогтмол мэдээлэл хийж, Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдээс амаар тавьсан асуултад хариулна” гэж заасныг зөрчин ерөнхий сайдын мэдээллийг Шадар сайдаар хийлгэсэн, 109.2-д зааснаар Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонсохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдэд бичгээр ирүүлэх байтал цөөнхийн бүлэгт 1 хоногийн өмнө ирүүлсэн, 109.5-д ... Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөлөл 25 минутад багтаан үг хэлнэ гэж заасныг зөрчин чуулганы хуралдааны дараалалд оруулсан байсан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дүгнэлтийг бүдүүлгээр хассан, 109.6-д заасан ... Ерөнхий сайд мэдээлэл хийж, цөөнхийн төлөөлөл үг хэлсний дараа цөөнхийн төлөөлөл тус бүр 5 минутад багтаан Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс асуулт асууж, үг хэлж болно гэж заасныг зөрчин олонхийн бүлгийн гишүүдээр үг хэлүүлж, асуулт асуулгах байдлаар хуулийн үзэл баримтлалыг замхруулсан зэрэг хууль зөрчсөн үйлдлүүдийг гаргалаа.

Монгол улсад байнгын ажиллагаатай парламент үүсэж хөгжсөний 30 жил ой тохиож байгаа бөгөөд өнгөрсөн жилүүдэд бий болгосон парламентын ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэх, улам хөгжүүлэх чиглэлд бид хамтран ажиллах ёстой гэж үзэж байна.

Иймээс парламентат ёсны зарчмын дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэгт хуульчлан олгосон хяналтын чиг үүрэг бүхий зохицуулалтыг цаашид хуулийн болон зохион байгуулалтын хүрээнд хадгалан авч үлдэх тал дээр Улсын Их Хурлын дарга болон Улсын Их Хурлын тамгын газрын зүгээс анхааран, чуулганы хуралдааны дэг

зөрчигдсөн асуудлаар арга хэмжээ авч, буруутай этгээдэд хариуцлага тооцон эргэж мэдэгдэхийг хүсч байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх мэдээлэл хийх тухай Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэгт ирүүлсэн бичгийг хавсаргав.

Хувийг: Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүхэд

Хавсралт 8. хуудастай.

БҮЛГИЙН ДАРГА Д.ГАНБАТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-16-30
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020. 10. 20 № 26

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Анхааруулга хүргүүлэх тухай

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгох тухай, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэхээр төлөвлөсөн байсан.

Таны тэргүүлж буй Засгийн газрын Сангийн сайд холбогдох албан тушаалтнуудын хамт Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн хуралдаанд Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн танилцуулга хийж, гишүүдийн асуултад хариулж, саналыг хэлэлцэн Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангах ёстой байсан.

Гэтэл өргөн барьсан хуулийн төслийнхөө талаар танилцуулга хийхээр холбогдох албан тушаалтнууд бүлгийн хуралдаанд тухайн цагт байсангүй. Энэ үйлдэл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасан “Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчимд нийцсэн, бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн ... ”, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэгт заасан “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулна” гэсэн хуулийн заалтуудыг зөрчиж байна.

Өргөн барьсан хуулийн төслөө Ардчилсан намын бүлгийн хуралдаанд танилцуулах, хэлэлцүүлэх үйл явцад хайнга хандаж, хуулиар оногдсон ажил үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтнууддаа шаардлага тавьж, цаашид Засгийн газрын зүгээс хууль хэрэгжүүлж, хууль дээдлэх зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгож ажиллахыг анхааруулж байна.

Хувийг: Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт.

БҮЛГИЙН ДАРГА Д.ГАНБАТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-61-64
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.11.02 № 29

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Ёс зүйгүй сайдыг огцруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон 2018 онд “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газар /ТӨҮГ/-ын үйлдвэрлэл эрхэлсэн орлогч захирлаар ажиллаж байхдаа хувийн сургуульд суралцаж буй хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг тус компанийн данснаас төлүүлсэн ёс зүйгүй үйлдэл гаргасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох ...” гэж хуульчилсан. Гэтэл төрийн өмчит үйлдвэрийн газрын орлогч захирал хувьдаа ашигласан мөнгөө төсөвт хамаарахгүй гэж бахдалтайгаар хэвлэлийн хурал хуралдуулж байгаа нь туйлын харамсалтай үйлдэл боллоо.

Ардчилсан улс орнуудын жишгээр ёс зүйгүй үйлдэл гаргасан төрийн өндөр албан тушаалтнууд ард түмнээсээ уучлалт гуйж огцордог, тийм хүмүүсийг өндөр албан тушаалд ажиллуулдаггүй байтал Монгол Улсын Засгийн газраас ийм жишиг харагдахгүй, улам бүр албан тушаалаар шагнан дэвшүүлдэг байдал газар авлаа.

Засгийн газрын тэргүүн та ёс зүйн зөрчилтэй сайдаа өөрөөр нь огцруулах, эсхүл Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлж ёс зүйгүй байдлыг өөгшүүлэхгүйгээр нэн даруй ажлаас нь чөлөөлөх нь зүйд нийцнэ.

Хэрэв таны тэргүүлж буй Засгийн газар энэ мэт ёс зүйгүй сайдуудтайгаа хариуцлага тооцолгүйгээр ажиллах бол танай Засгийн газраас шударга ёсыг хүлээх, найдах хэрэггүй, ийм Засгийн газар цаашид ажиллах боломжгүй гэж дүгнэхэд хүрч байна.

Иймд Ерөнхий сайд танаас ёс зүйгүй Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонг нэн даруй огцруулахыг шаардаж байна.

БҮЛГИЙН ДАРГА Д.ГАНБАТ

ГУС Я 1396

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-61-64
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020. 11. 17 № 31

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР,
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ НАРТ

Шаардлага хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газар коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэж, хүн амаа аюулт өвчнөөс хамгаалах үүрэгтэй ажиллаж ирсэн боловч, харамсалтай нь Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын удирдлагын хариуцлагагүй, зохион байгуулалтын мэргэжлийн бус байдлаас болж тусгаарлалтын дэглэм алдагдсанаас дотоодод халдвар тархаж, хүн амын эрүүл мэнд, улс орон, нийгэм, эдийн засагт эрсдэлтэй ноцтой нөхцөл байдал руу орлоо.

Улсын Их Хурал /УИХ/ дахь Ардчилсан намын бүлэг коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын ээлжит 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн мэдээлэлтэй холбогдуулан дүгнэлт зөвлөмж гаргаж, тухайн үед УИХ-ын гишүүд санал, зөвлөмж өгсөөр байтал Засгийн газар болон Улсын онцгой комисс үйл ажиллагаандаа тусгалгүй, халдварын голомтыг тусгаарлах хөл хорионы дэглэмд баримтлах ёстой дэг журмыг сахиулалгүй цалгардуулж дотооддоо халдварыг алдлаа.

Коронавирус дэлхий нийтэд тархаж, цар тахлын хэмжээнд дэгдээд бүтэн жилийн хугацаа өнгөрч байхад Монгол Улсын Засгийн газраас коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр ямар ч стратеги, бэлэн байдлын төлөвлөгөөгүй, эрсдэлт нөхцөлд бэлтгэлгүй байсан нь Ерөнхий сайдыг төлөөлөн Шадар сайдын танилцуулсан мэдээллийн үед ч, улмаар хөл хорио тогтоосон өнгөрсөн 7 хоногийн хугацаанд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдээс харагдаж байна. Тухайлбал,

1. Халдвартай иргэдийг тусгаарлаж буй зарим байрууд эрүүл ахуйн шаардлага хангаагүй, Энхсаран гэх сувилал нийтийн усанд орох газар, бие засах газартай, тусгаарлагдсан хүмүүсийг өрөө хооронд орж гарах хяналтгүй орчин бүрдүүлсэн, тусгаарлаж буй байрны эрүүл ахуй хорио цээрийн дэглэм мэргэжлийн бус, хяналтгүй байсан төдийгүй Энхсаран сувиллын тусгаарлах байр нь өөрөө халдвар тархаах голомт болжээ,
2. Сэлэнгэ аймагт илэрсэн халдварын тохиолдлын голомт, эх сурвалжийг 7 хоног өнгөрөөд байхад хэзээ хаанаас халдвар тархсаныг одоо болтол тогтоогоогүй, аймгийн нэгдсэн эмнэлэг нь коронавирусын халдвар тархаах голомт болсон, мөн Оросын Холбооны Улсаас орж ирж буй галт тэргэнд зохих ариутгал халдваргүйжүүлэлт хийгээгүй,

3. Халдварт өвчний үеийн хөл хорионы дэглэм тогтоосон үед махны худалдааг зохион байгуулахдаа иргэд хоорондын зай баримтлах зэрэг хорио цээрийн дэглэм мөрдөөгүй нь халдвар дамжуулах хэмжээний эрсдэлт нөхцөл байдал бий болгосон,

4. Бүх нийтийн хатуу хөл хорио тогтоосон үед замын хөдөлгөөнд зайлшгүй оролцох иргэд, ажил үйлчилгээг урьдчилан тогтоогоогүй, улмаар тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох нэрээр эмх замбараагүй байдал бий болгож, халдвар тархаах бөөгнөрөл үүсгэсэн,

5. Халдвар болон халдвартай тэмцэх чиглэлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх Засгийн газар, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам, УИХ-ын гишүүдийн мэдээлэл зөрөөтэй,

6. Хөл хорионы горимд шилжиж бүх бизнесийг зогсоохтой зэрэгцэн улс орны нийгэм, эдийн засагт чиглэсэн нөөц төлөвлөгөө хэрэгжиж байх атал, Засгийн газар хуралдаж шийдвэрлэхээр ярьж эхэлж байгаа зэргээс тодорхой харагдаж байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1. Монгол улсын иргэн амьд явах эрхтэй..., 16.2. эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй, 16.6. эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй ... гэсэн Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг төрөөс баталгаатай эдлүүлэх тухай зохицуулалтыг энд сануулья.

Иймд УИХ дахь Ардчилсан намын бүлгээс УИХ болон Монгол Улсын Засгийн газарт дахин зөвлөмж хүргүүлж коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх чиглэлээр дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

Нэг. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээндээ хариуцлагагүй хандаж, дотооддоо халдвар алдаж, хүн амын амь нас, эрүүл мэнд, нийгэм эдийн засагт ноцтой хүндрэл учруулсан асуудлаа хүлээн зөвшөөрч Монгол Ардын Нам, Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх болон Улсын онцгой комиссыг нийт ард түмнээсээ уучлал гуйхыг шаардаж байна.

Хоёр. Улс орондоо цар тахлын халдварыг алдаж, эрсдэл учруулсан Засгийн газар, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамны буруутай этгээдүүдтэй хариуцлага тооцож, албан тушаалаас нь огцруулж, мэргэжлийн, туршлагатай, чадварлаг хүмүүсийг яаралтай томилох, цар тахалтай тэмцэх ажилд томилогдсон албан хаагчдын ажил, амралтын горимыг зохицуулах, ажиллах нөхцөл, цалин урамшууллыг сайжруулах,

Гурав. Монгол Улс дотооддоо алдсан халдвар, хавьтал, голомт, эх үүсвэрийг бүрэн илрүүлэхийн тулд хөл хорионы дэглэмийг сайтар сахиулж, дүрэм журмыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, Олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн мэргэжлийн төвшинд зохион байгуулах, хүн амын дунд тандалт судалгааны зорилгоор хийж буй Ковид-19-ийн оношлогооны тоог нэмэгдүүлж, Сэлэнгэ, дархан, Өмнөговь болон төмөр зам дагуух эрсдэлтэй аймаг сумын хүн амыг бүрэн хамруулах, бусад аймаг, сумын хүн амын 30-аас багагүй хувьд хүргэх, тандалт судалгааны тайлан мэдээллийг албан ёсны мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд ил тод мэдээлэх,

Дөрөв. Бүх нийтийн хатуу хөл хорионы үед хүнд нөхцөлд орох эрсдэлт бүлгийн судалгаанд тулгуурлан эм, хоол хүнсээр хангах, зайлшгүй тохиолдолд тусгаарлалтын болоод түр байрлах байраар хангах, тодорхой биш бол нэн даруй судалгаа хийх,

Тав. Дэлхийн бусад орнуудаас эх орондоо ирэх хүсэлтээ гаргасан иргэдээ татахаар төлөвлөсөн хуваарьт нислэгүүдийг, тухайлбал 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Франкфурт-Улаанбаатар чиглэлд хийх нислэг зэргийг цаг хугацаанд нь хүлээн авах, ариутгал, халдваргүйжүүлэлт, тусгаарлалтын дэглэмээр иргэдээ нэн яаралтай эх оронд нь татах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах,

Зургаа. Дотооддоо алдсан халдварын тархалтыг хумих, эрсдэлийг бууруулах чиглэлд онцгой анхаарч, хөл хорионы дэглэмийн үед иргэдийг амны маскаар үнэ төлбөргүй хангах зэрэг гадаад улсуудын үр дүнтэй туршлагыг авч хэрэгжүүлэх,

Долоо. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдөж, клиник туршилтаа амжилттай хийн, 90-ээс дээш хувийн үр дүн үзүүлсэн олон улсын биотехнологийн судалгааны хүрээлэнгүүдийн “COVID-19”-ийн эсрэг вакциныг нэн яаралтай сонгон захиалж, тээвэрлэн импортлох төлөвлөгөө гаргах, 2020 ондоо багтаан эмч, эмнэлгийн ажилтнууд, цар тахалтай тэмцэх ажилд оролцож буй байгууллагуудын ажилтнууд, өндөр настан, эрсдэлт бүлгийн иргэд, сэтгүүлчид болон стратегийн чухал салбарт тасралтгүй ажиллах шаардлагатай төрийн, бизнесийн салбарын ажилтнууд гэх мэтчилэн эрэмбэ хуваарь гарган эхний ээлжид вакцинд хамруулах, цаашлаад 2021 оны эхний улиралд багтаан бүх хүн амаа вакцинжуулах ажлыг мэргэжлийн төвшинд хуваарь гарган зохион байгуулах,

Найм. Эдийн засагт учирч буй хүндрэлийг хохирол багатай даван гарахад төсвийг тэлэх бус эдийн засгийг тэлэх чиглэлд тэргүүлэх татвар төлөгч шилдэг 30 аж ахуйн нэгжүүдийн удирдлага, захирлууд болон шилдэг эдийн засагчдыг оролцуулсан мэргэжлийн баг бүрдүүлж, нэн шуурхай байдлаар бодлого, хөтөлбөр боловсруулан, үйл ажиллагаа явуулж буй 60 гаруй мянган аж ахуйн нэгжүүдийг татвар, түрээс, зээлийн уян хатан бодлогоор дэмжих, тэнд ажиллаж буй 800 мянган гаруй ажилтнуудын ажлын байр, орлогыг хадгалахад чиглэсэн эдийн засгийн оновчтой арга хэмжээг яаралтай авах,

Ес. Нийтийн хөл хорио тогтоож, иргэд, бизнесийн байгууллагуудын орлого олох үйл ажиллагаа саатсантай холбогдуулан банк, банк бус санхүүгийн байгууллага, ломбард болон Засгийн газрын тусгай сангуудаас авсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн хөл хорио тогтоосон хугацааны зээлийн хүү, төлбөрийг зогсоох, Засгийн газар хариуцах,

Арав. Нүүрс болон уул уурхайн гаралтай түүхий эдийн экспортыг хэвийн явуулах чиглэлд онцгой анхаарч, олборлох, тээвэрлэх, экспортлох бүх шатанд халдвараас сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, тусгаарлалтын дэглэм, журмыг онцгой мөрдөх,

Арван нэг. 2020 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үр дүнгээр сонгогдож, хуулийн дагуу нэр дэвшүүлсэн аймаг сумдын засаг дарга нарыг яаралтай томилж ажилд нь оруулах,

Арван хоёр. Коронавирусын халдварт цар тахлын дэгдэлт нь өвөлжилттэй давхцаж буй учир төрийн онцгой объектүүд болох дулаан, цахилгаан, ус болон хүнсний хангамжийн байгууллагууд дээр өндөржүүлсэн байдал зарлаж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, халдвар тархаахгүй байх хорио цээрийн дэглэм

тогтоох, шатахууны нөөцийг цаг алдалгүй хангалттай бүрдүүлж, үнийн хөөрөгдлөөс сэргийлэх,

Арван гурав. Засгийн газрын болон Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлэх цар тахалтай тэмцэх бүх нийтийн хөл хорионы үеэр хүний эрх, эрх чөлөөнд халдахгүй байх, авч хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээ нь иргэдийн эрүүл, аюулгүй тайван амьдралын баталгааг хангахад чиглэх, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг асуудлуудад чиглэсэн зохих арга хэмжээг цаг тухай бүр хуулийн дагуу авч хэрэгжүүлэхийг тусгайлан анхааруулж байна,

Арван дөрөв. Гадаадын улс орнууд, донор байгууллагуудаас коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх чиглэлд Монгол Улсын Засгийн газарт өгсөн зээл, тусламжийг ард иргэддээ ил тод нээлттэй мэдээлж, вакцинжуулалт, эдийн засгийг аврах чиглэлд цаг алдалгүй түлхүү зарцуулах зэрэг зөвлөмжийг шаардлага хэлбэрээр тусгайлан дахин хүргүүлж байна. Цар тахалтай тэмцэх нэн хариуцлагатай үед УИХ болон УИХ дахь МАН-ын бүлгийн зүгээс Засгийн газар болоод Улсын онцгой комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийн дагуу санаачилгатай ажиллахыг сануулъя.

Цар тахлын халдвар алдагдаж, хөл хорио тогтоохтой зэрэгцэн УИХ-аас Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон дагалдах хуулиудыг цахимаар хуралдан эцэслэн батлах үед УИХ дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс горимын санал гаргаж нэгэнт эцэслэн нэгтгэсэн 2021 оны төсвийг хуулийн хугацаанд шуурхай батлуулах, улмаар нэн даруй төсвийн тодотгол хийх санаачилгыг гаргасан.

Иймд энэхүү саналыг дэмжин Монгол Улсын 2021 оны төсвийн тухайн хуулийг хуулийн хугацаанд нь батлуулсан УИХ болон УИХ-ын гишүүдэд талархал илэрхийлэхийн сацуу УИХ-аас нэн яаралтай ажлын хэсэг байгуулан Засгийн газартай хамтран ажиллаж, цар тахлаас үүдэх сөрөг нөлөөлөл түүний хор хөнөөлийг илүү судалгаатай тооцож, үр ашиггүй хөрөнгө оруулалтыг танасан, хойшлуулж болох төсөл хөтөлбөрийг тэвчсэн, эдийн засагт үр өгөөжтэй, ажлын байрыг хадгалах, шинээр бий болгох, бизнес, аж ахуйн нэгжийг дэмжсэн бодлогыг эрэмбэлсэн төсвийн төслийг тодотгон нэн яаралтай дахин хэлэлцэхийг шаардаж байна.

БҮЛГИЙН ДАРГА Д.ГАНБАТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-61-64
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.12.02 № 34

танай _____-ны №_____-т

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Монгол Улсад коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлыг дотооддоо алдсаны улмаас улс даяар бүх нийтийн бэлэн байдал зарласан билээ. Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос тогтоосон хөл хорио, цар тахалтай тэмцэх үйл шийдвэр, ажиллагааг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болоод төрийн бус байгууллагууд бүгд дагаж мөрдөхөөр хичээж байгаа боловч зохион байгуулалтын алдаа дутагдлаас болж авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн зохих түвшинд хүрэхгүй байна. Засгийн газар, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны улмаас хөл хорио тогтоосон Энхсаран сувилал, төмөр замын дагуу голомтлон алдсан цар тахал нь холбогдох байгууллагын цар тахалтай тэмцэх төлөвлөгөө, стратеги оновчтой бус байсныг нотолж байгаа бөгөөд Улсын Их Хурал /УИХ/ дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс удаа дараа мэдэгдэж, цаг тухай бүр шаардлага хүргүүлж байсан зарим зүйлийг үйл ажиллагаандаа тусгаагүйгээс болсон гэж бид үзэж байна.

Засгийн Газар, Улсын онцгой комиссоос 2020 оны 3 дугаар сараас эхлэн хөл хорионы дэглэмд шилжиж, улмаар Монгол Улс дотооддоо коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлыг алдсанаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн хатуу хөл хорио тогтоож, халдварыг илрүүлэх, тархалтыг зогсоох чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ч зохион байгуулалт шаардлагатай хэмжээнд хүрэхгүй, мэргэжлийн бус байна.

Тухайлбал, Улсын онцгой комиссоос гаргасан хөл хорионы үед зорчих иргэдийн цагийн хуваарийг эргэж буцсан байдлаар дахин дахин өөрчлөн тогтоох, махны худалдаа, хот доторх тээврийн хэрэгслийн зорчих зөвшөөрөл олгох, иргэдийг автобус нийтийн тээврээр зорчуулах, орон нутаг руу зорчих иргэдийн шинжилгээ хийх гэх мэтээр иргэдийн бөөгнөрөл үүсгэж, халдвараас хамгаалах горим журмыг зөрчих байдлаар халдварыг зогсоох бус тархаах хэмжээний эрсдэлтэй алдааг дахин давтан гаргаж байгааг нэн даруй зогсоох шаардлагатай байна. Мөн ойлгомжтой хэлбэрээр нэг сувгаар албан ёсны мэдээлэл очихгүй байгаагийн улмаас төөрөгдөл үүсгэх, та бүхний бодлого шийдвэр үл ойлгогдож, замбараагүй байдал үүсгэж байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн бүлгийнээлжит хуралдаанаараа коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн талаар Улсын онцгой комиссын мэдээллийг сонсож хэлэлцээд уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барихын зэрэгцээ хуулийн хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар болон үйл ажиллагаандаа мэдээллийн технологийг ашиглах зөвлөмжийг хүргүүлж байна.

Нэг. Цар тахалтай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, зохион байгуулалтын чиглэлээр;

1. Эдийн засагт үзүүлж буй “Ковид-19”-ийн сөрөг нөлөөг бууруулах чиглэлд тооцоо судалгаа хийж айл өрх, иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих, чанаргүй зээлүүдийг худалдан авах гэх мэт санхүүгийн оновчтой арга хэрэгсэл авч хэрэгжүүлэх бодлого боловсруулж Засгийн газар, УИХ-аар батлуулан хэрэгжүүлэх,
2. Хөл хорионд орж иргэд орлогогүй болж байгаатай холбоотойгоор хот суурин газарт эмзэг бүлгийн айл өрхүүдийг түлшээр үнэ төлбөргүй хангах асуудлыг баг хороо бүрээр нарийвчлан судалж шийдвэрлэх,
3. Хот хооронд зорчих иргэдийн шинжилгээ, хяналтын асуудалд Улсын онцгой комисс орон нутгийн онцгой комисстой үйл ажиллагаагаа нягт уялдуулж ажиллах,
4. Цар тахлын голомт, эрсдэлтэй бүсд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн болон цагдаа, онцгой байдал, мэргэжлийн хяналтын газар, холбогдох бусад байгууллагын ажилтнуудын хамгаалах хувцас, өмсгөлд анхаарч, эмч, ажилтнууд халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх,
5. Экспортын гол түүхий эдийн олборлолт, тээвэрлэлт чиглэлд онцгой анхаарч, тэнд ажиллаж буй ажилтнууд, жолооч нарын эрүүл мэнд, халдвараас хамгаалах чиглэлд тусгайлан арга хэмжээ авах,
6. Хөл хорионы дэглэм тогтоосон үед гэр бүлийн хүчирхийлэл ихсэж, архидан согтуурах байдал буурахгүй байгаа тул урьдчилан сэргийлэх, мэдээлэл, дуудлага хүлээн авах, шуурхай шийдвэрлэх чиглэлд онцгойлон анхаарах,

Хоёр. Үйл ажиллагаандаа цахим систем ашиглах чиглэлээр;

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 2.2 сая ухаалаг утас хэрэглэгч байгаа бөгөөд иргэдийн 70-80 хувь нь цар тахлын үед албан ёсны мэдээллийг гар утас ашиглан авч байгаа гэж хариулсан байна. Гэтэл мэдээллийн албан ёсны цогц аппликейшн байхгүй, одоо ашиглаж байгаа аппликейшнүүдийн мэдээлэл хоорондоо уялдаагүй, учир дутагдалтай байгаа тул цар тахлын тархалтын мэдээ, вирусний шинжилгээ өгөх болон зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээний заавар журмыг иргэд баталгаагүй эх сурвалжаас ам дамжсан байдлаар мэдээлэл авч байгаа нь

төөрөгдөл бухимдал үүсгэж, халдвараас хамгаалах горим алдагдаж байна. Иймд Улсын онцгой комисс цар тахлын үеийн бүх мэдээллийг e-mongolia.mn болон иргэний бүртгэл мэдээллийн датад тулгуурлан, цаг тухай бүр хэзээ ч, хаанаас ч харж болох цахим зохицуулалт хийж болох албан ёсны аппликейшныг боловсруулан Улсын онцгой комисс үйл ажиллагаандаа ашиглах зайлшгүй шаардлага үүсэж байна. Энэ хүрээнд дараах зохицуулалтыг тусгах боломжтой. Үүнд:

1. Аливаа дараалал үүсгэж болзошгүй зохион байгуулалтыг мэдээллийн технологи ашиглан бүртгэл явуулж цаг хуваарилах зарчмаар бөөгнөрөл үүсгэхгүй байх,
2. Анхны хавьтагчдын явсан маршрутыг газрын зураг дээр эрсдэлийн зэрэг тогтоон өнгөөр ялгаж харуулах /нэр нууцалсан байдлаар/,
3. Хот хооронд зорчих иргэдийг хот, суурингаас гарах, орох товчоон дээр бөөгнөрөл үүсгэхгүйн тулд QR код ашиглан цаг хуваарилах,
4. COVID-19 өвчний шинж тэмдгийг хянах зорилгоор олон улсад ашиглаж буй дэвшилтэт технологи шийдлийг ашиглан халдварын голомттой бүсийн иргэдийн хөдөлгөөнийг хянах,
5. Бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдал гэх мэт мэргэжлийн үг хэллэгийн тайлбар, ялгааг ойлгомжтойгоор зураг мэдээллээр хүргэх, инфографик хэлбэрээр тоо баримтыг ойлгомжтой харуулах,
6. COVID-19 холбоотой төсвийн болон бусад улс орны засгийн газар, донор байгууллагуудаас өгсөн зээл, тусламжийн зарцуулалтын “шилэн” тайланг тухай бүрд нь уг аппликейшнд хялбар байдлаар оруулдаг байх,

Цар тахлын үед авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөл хорионы дэглэм, цар тахалтай тэмцэх бүхий л үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж халдвараас хамгаалах дэглэм мөрдөгдөж, нөгөө талдаа иргэдийн эрх зөрчигдөхгүй байх үндсэн нөхцөл бүрдэх болно.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-16-30
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2021.01.20 № 04

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МОНГОЛ
АРДЫН НАМЫН БҮЛГИЙН ДАРГА
Д.ТОГТОХСҮРЭН ТАНАА

Шаардлага хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн Хуульд ...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго хэмээн заасаар байтал коронавирусын халдварт цар тахлын эсрэг Засгийн Газар, Улсын онцгой комиссоос өнгөрсөн нэг жилийн хугацаанд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь зохион байгуулалтгүй, иргэн, ард түмнээ гэсэн сэтгэлгүй, хүмүүнлэг бус байна.

Улсын Их Хурал /УИХ/ дахь Ардчилсан намын бүлэг удаа дараа санал, шаардлага хүргүүлж, Засгийн газар цар тахалтай тэмцэх бүх нийтийн хөл хорионы үеэр хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, авч хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээ нь хуулийн дагуу, хүмүүнлэг, үр дүнтэй байх ёстойг сануулсаар ирсэн ч эрхэлсэн ажилдаа хайхрамжгүй, сэтгэлгүй хандаж байгаа сайд, дарга нарын хариуцлагагүй үйлдлийн улмаас эрдэнэт хүний амь нас үрэгдэж, төрөөс иргэддээ хандах хүнлэг ёс гээгдсээр байна.

Цар тахалтай тэмцэх бүх нийтийн хөл хорионы дэглэмийг хэрэгжүүлэхдээ зохих арга хэмжээ авч чадаагүйн улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадалгүй иргэд нь улсынхаа нийслэл рүү орох босгон дээр амь үрэгдэж, эх орондоо ирэхээ хоног тоолон хүлээх зууртаа иргэн нас барж, дөнгөж төрөх орон дээрээс идэр есийн хүйтэнд тусгаарлах байр руу ачигдаж байгаа эх үр хоёрын сэтгэл эмтрэм байдал нь өнөөгийн эрх баригчид болон Засгийн Газрын ажлын бодит байдал юм. Эх орондоо ирэх иргэдээ удаан хугацаагаар хүлээлгэж, хүний нутагт өлсгөлөн зарлах хүртэл хүнд байдалд оруулжээ. Цар тахалтай тэмцэх Засгийн газрын зорилго нь иргэдийнхээ амь нас, орлого, амь амьжиргааг хамгаалах байтал иргэд нь зовж зүдэрч, амь насаа алдаж байгаад Засгийн Газар, Улсын онцгой комисс хайхрамжгүй хандаж байгаа нь иргэдийнхээ эсрэг гаргаж буй ноцтой үйлдэл, эс үйлдэхүй юм.

Иймд УИХ дахь Ардчилсан намын бүлэг Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй, хүнлэг бус хандсан, Монгол Улсын иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох нөхцөлд оруулсан Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан болон Нийслэлийн онцгой комиссын дарга бөгөөд Нийслэлийн засаг дарга Д.Сумъяабазар нарт байгуулсан Засгийн газартайгаа хариуцлага тооцон ажиллахыг УИХ дахь Ардчилсан намын бүлгээс шаардаж байна.

Цар тахлын хүнд үеийг ард иргэддээ эзлтэйгээр даван туулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадамжгүй Засгийн газартайгаа хариуцлага тооцож чадахгүй бол УИХ өөрөө тарах нөхцөл бүрдэх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Хувийг, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт.

БҮЛГИЙН ДАРГА Д.ГАНБАТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-16-30
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2021. 01. 20 № 03

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Шаардлага хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн Хуульд ...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго хэмээн заасаар байтал коронавирусын халдварт цар тахлын эсрэг Засгийн Газар, Улсын онцгой комиссоос өнгөрсөн нэг жилийн хугацаанд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь зохион байгуулалттүй, иргэн, ард түмнээ гэсэн сэтгэлгүй, хүмүүнлэг бус байна.

Улсын Их Хурал /УИХ/ дахь Ардчилсан намын бүлэг удаа дараа санал, шаардлага хүргүүлж, Засгийн газар цар тахалтай тэмцэх бүх нийтийн хөл хорионы үеэр хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, авч хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээ нь хуулийн дагуу, хүмүүнлэг, үр дүнтэй байх ёстойг сануулсаар ирсэн ч эрхэлсэн ажилдаа хайхрамжгүй, сэтгэлгүй хандаж байгаа сайд, дарга нарын хариуцлагагүй үйлдлийн улмаас эрдэнэт хүний амь нас үрэгдэж, төрөөс иргэддээ хандах хүнлэг ёс гээгдсээр байна.

Цар тахалтай тэмцэх бүх нийтийн хөл хорионы дэглэмийг хэрэгжүүлэхдээ зохих арга хэмжээ авч чадаагүйн улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадалгүй иргэд нь улсынхаа нийслэл рүү орох босгон дээр амь үрэгдэж, эх орондоо ирэхээ хоног тоолон хүлээх зууртаа иргэн нас барж, дөнгөж төрөх орон дээрээс идэр есийн хүйтэнд тусгаарлах байр руу ачигдаж байгаа эх үр хоёрын сэтгэл эмтрэм байдал нь өнөөгийн эрх баригчид болон Засгийн Газрын ажлын бодит байдал юм. Эх орондоо ирэх иргэдээ удаан хугацаагаар хүлээлгэж, хүний нутагт елсгелөн зарлах хүртэл хүнд байдалд оруулжээ. Цар тахалтай тэмцэх Засгийн газрын зорилго нь иргэдийнхээ амь нас, орлого, амь амьжиргааг хамгаалах байтал иргэд нь зовж зүдэрч, амь насаа алдаж байгаад Засгийн Газар, Улсын онцгой комисс хайхрамжгүй хандаж байгаа нь иргэдийнхээ эсрэг гаргаж буй ноцтой үйлдэл, эс үйлдэхүй юм.

Иймд Монгол Улсын Ерөнхий сайд Та эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй, хүнлэг бус хандсан, Монгол Улсын иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох нөхцөлд оруулсан Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан болон Нийслэлийн онцгой комиссын дарга бөгөөд Нийслэлийн засаг дарга Д.Сумъяабазар нарт хариуцлага тооцож, нэн даруй огцруулахыг шаардаж байна

Шаардлагыг эс биелүүлбээс цар тахлын хүнд үед иргэд, ард түмнээ хамгаалах чадамжгүй Засгийн Газрыг огцруулах хүртэл улс төрийн арга хэмжээ авахаа үүгээр мэдэгдэж байна.

Хувийг, УИХ дахь Монгол ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэнд.

БҮЛГИЙН ДАРГА Д.ГАНБАТ

Бүлгээс гарсан санал, дүгнэлт



Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Засгийн газар төрийн хууль биелүүлэх ажлаа Улсын Их Хурлын өмнө хариуцна.

УИХ-аас Засгийн газрын үйл ажиллагаа, хууль биелүүлэх ажлыг хянах нэг хяналт нь Ерөнхий сайдаас хийх мэдээлэл юм. Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон цаг үеийн тулгамдсан бусад асуудлаар Ерөнхий сайд сар бүрийн 1 болон 3 дахь долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанд тогтмол мэдээлэл хийж, Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдээс амаар тавьсан асуултад хариулна. Чуулганы хуралдаанд Ерөнхий сайд мэдээлэл хийж, сөрөг хүчин тухайн асуудлаар санал, дүгнэлтээ танилцуулна. Ерөнхий сайдын мэдээллийн цагаар зөвхөн сөрөг хүчин, цөөнхийн төлөөлөл Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс асуулт асууж, үг хэлж болдог хяналтын цаг юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тухайлан зохицуулсан харилцаа, сөрөг хүчний хяналтын гол хэрэгжүүлдэг энэ цагт зөвхөн Ерөнхий сайд мэдээллээ танилцуулах үүрэгтэй. Гэвч Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх 2020 оны намрын ээлжит чуулганы хуралдааны Ерөнхий сайдын мэдээллийн цагтаа нэг ч удаа өөрийн биеэр мэдээлэл хийсэнгүй цөөнхийг илтэд үл хүндэтгэсэн, хууль зөрчсөн үйлдлийг удаа дараа гаргасан.

Сөрөг хүчний шүүмжлэлийг хүлээн авч, хэрэгжүүлж болох санал дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байж бид хамтдаа Монгол Улсаа хөгжүүлэхийн төлөө ажиллаж шаардлагатай байна. МАН-ын Монгол Улс, Ардчилсан намын Монгол Улс гэж байхгүй гэдгээ Ерөнхий сайд ухамсарлаж Монгол Улсаа хөгжүүлэх, ирээдүй үр хойчдоо хөгжиж, дэвжсэн тусгаар Монгол Улсаа өвлүүлэх ёстой гэдэг нэг зорилгоо умартаж болохгүйг сануулсаар байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-16-30
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.08.27 № 01

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНД

Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслийн талаарх УИХ дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлт

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ!

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг нягт нямбайгаар судалж хэлэлцээд улс орон, ард иргэдийнхээ нийтлэг эрх ашгийг үндэс болгон гаргасан дүгнэлтээ танилцуулж байна.

2020 оны эхнээс гадаад зах зээлийн эрэлт буурсантай холбоотойгоор түүхий эдийн ханш буурч манай улсын хувьд эдийн засаг хүнд байдалд орох нь тодорхой болсон юм. Тухайн үед Ардчилсан намын зүгээс цаг алдалгүй төсвийн зарцуулалтын бүтцээ өөрчилж, элдэв төсөл, хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтээ эрэмбэлэн ялгаж, төсвийн тодотгол хийх ёстой гэдгийг удаа дараа анхааруулж, сануулж байв.

Гэтэл Монгол улсын Засгийн газар “Төсвийн тодотгол хийх шаардлага байхгүй. Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд маш ихээр сайжирсан” гэж иргэд, сонгогчдоо хууран мэхэлж байсан нь хэдхэн сарын өмнө билээ. Монголын төр иргэддээ үнэн бодит мэдээлэл өгөх үүрэгтэй. Сүүлийн арван жилийн турш Монгол улсын ДНБ үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр өсөж буйг шагшин магтаж ирлээ.

Гэвч үнэн хэрэгтээ бодит өсөлтгүй 10-12 тэрбум ам.долларт эргэлдсээр удаж байна. Нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээг валютаар тооцвол өсөх биш харин ч буурсан дүр төрхтэй гарна. Ядуурал, ажилгүйдлийн тоо ч буурахгүй байна. Арван жилийн өмнө 30 орчим хувьтай байсан ядуурлын хэмжээ хөөсөрсөн эдийн засаг, байгалийн болзошгүй хүчин зүйл, урагшгүй эрх баригчдын үйл ажиллагаанаас шалтгаалан Монгол улсын хоёр иргэн тутмын нэг

нь ажилгүйдэл, ядууралд өртөх нөхцөл байдалд орж магадгүй байгаагаа иргэдээсээ нуух шаардлага огт байхгүй.

Засгийн Газар энэ оны 03 дугаар сарын 27-ны өдөр ээлжит бусаар хуралдан эдийн засгийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх долоон арга хэмжээний талаар гаргасан шийдвэр нь хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдэд дорвитой дэмжлэг болж чадаагүйгээр үл барам эдийн засгийн идэвхжил буурч, авч хэрэгжүүлсэн нийгмийн халамжийн арга хэмжээнүүд нь зөвхөн сонгуулийн санал авахад чиглэгдсэн нь ийнхүү улс орны эдийн засгийг “элгээр нь хэвтүүлэх”-ийн эхлэл байжээ.

Монгол улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж төрийн үүргийг тов тодорхой зааж өгсөн байдаг. Энэ чухал үүргийг биелүүлэхийг шаарддаг “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн тусгай шаардлагын үйлчлэлийг түдгэлзүүлэх тухай хуулийн төслийг олонхийн Засгийн газраас оруулж ирснийг Ардчилсан нам хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Ийнхүү Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал 2020 онд байгуулагдсан шинэ парламентын өнгөн дээр улам хэврэгшиж эхэллээ.

Монгол улсын 2020 оны төсөвт 1.8 их наяд төгрөгөөр санхүүжүүлэх дүн бүхий 1293 төсөл арга хэмжээг хийхээр төлөвлөснөөс дөнгөж 134 төсөл арга хэмжээг хассан нь ерөнхий дүнгээрээ ердөө 53.9 тэрбум төгрөг болж байгаа нь төсөв тодотгох шалтгаан огт биш. Гэтэл төсвийн алдагдал 4.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 12.5 хувьтай тэнцэхээр оруулж иржээ. Энэ нь манай улсын валютын ханш, зээлжих зэрэглэл, хөрөнгө оруулалтад сөргөөр шууд нөлөөлөх нь гарцаагүй юм. Засгийн газрын 2020 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээг 4 их наяд 850.5 тэрбум төгрөг болгон даруй 2 их наяд 715 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь ганцхан жилийн хугацаанд 1.7 тэрбум ам.долларын өр үйлдвэрлэх асуудлыг Улсын Их Хурал дээр шийдвэрлэж байна.

Монгол улсын эдийн засаг түүхэнд байгаагүйгээр агшив

Эрх баригчид 2016 оны II улиралд 1.4 хувийн өсөлттэй эдийн засгийг хүлээж аваад өнгөрсөн дөрвөн жилийн турш "болохгүй, бүтэхгүй" гэж байнга гоншигнож ирлээ. Гэтэл 2020 оны 2-р улиралд эдийн засаг хасах 9.7 хувьд хүрч, Монгол Улсын сүүлийн гучин жилийн түүхэнд байгаагүй огцом уналт хийгээд байна. Ийм гамшигт байдалд хүргэхэд МАН-ын олонхийн Засгийн газрын “бай”-гаа оноогүй, асуудлаа зөв эрэмбэлээгүй төсөв, сангийн болон мөнгөний бодлого нөлөөлснийг энд нурших илүүц биз ээ.

Асар их хэмжээний төсвийн алдагдалтай он жилүүд үргэлжилж байна

2016 оны Улсын Их Хурлын сонгуулиар үнэмлэхүй олонхи болсон МАН-ын парламент өнгөрсөн дөрвөн жилд баталсан төсвийн алдагдал 4 жилийн нийлбэр дүнгээрээ 9 их наяд төгрөг болсон.Тэгвэл өнөөдөр өргөн барьж буй төсвийн тодотголд Нэгдсэн төсвийн тэнцлийг бас дахин 2 их наяд 771 тэрбумаар нэмэгдүүлж орж ирснийг нийт татвар төлөгчид уучлахгүй нь мэдээж. Ердөө дөрөвхөн жилийн өмнө Монгол гэдэг айлын төсвийн зарлага 6-7 их наяд төгрөгийн хэмжээнд тогтвортой эргэлдэж байсан бол 2020 оны төсөвт 13 их наяд

872 тэрбум төгрөгт хүрч хоёр дахин данхайгаад байна. Өргөн барьсан тодотголд дахин 704 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж орж ирлээ. Баялаг бүтээгч аж ахуй нэгж, иргэдийн хөлс хүчээ шавхан байж төлсөн татварын хөрөнгийг дарга нарын тансаглалд "цоорхой сав" мэт урсгаж байгааг зогсоох шаардлагатай байна.

Монгол Улсын гадаад өр дефолт зарлах хэмжээнд очлоо

Монгол Улсын нийт өр 2016 оны зургадугаар сарын 30-ны өдөр 24 тэрбум 260 сая ам.доллар байснаа 2020 оны гурван сарын 31 байдлаар 30 тэрбум 461 сая ам.долларт хүрч зөвхөн дөрөвхөн жилийн хугацаанд 6 тэрбум 201 сая ам.доллар буюу бараг 18 их наяд төгрөгөөр өссөн байна. Энэ нь та бүхнийг шүүмжлэх дуртай Чингис бондыг 4 дахин нугалах мөнгө. Иймх их хөрөнгөөр иргэдийн хамгийн их зорчдог Дархан-Улаанбаатарын хатуу хучилттай гол замыг там болгожээ.

Засгийн газрын нийт өр 1991-2016 онуудад 4 тэрбум 785 сая ам.доллар байсан бол 2020 оны эхний улиралд 7 тэрбум 235 сая ам.долларт хүрч даруй 2 тэрбум 400 сая ам.доллараар нэмэгдлээ. Ийм их хэмжээний өрийг өмнө нь аль ч Улсын Их Хурал, Засгийн газар үйлдвэрлэж байсангүй. Өрөөр хамгийн их улс төрждөг улс төрийн хүчин өнөөдөр монгол улсын эдийн засаг, тусгаар тогтнолын аюулгүй байдалд бодитойгоор аюул занал учруулах хэмжээний өртэй болгожээ.

Валютын ханш тэнгэрт хадлаа

Монгол улсын нийт импортын 70 хувийг ам.долларaар хийдэг ба хэрэглээний сагсны 40 хувь нь импортын бараа байдаг. Тиймээс ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн чангаралтаас шалтгаалж өргөн хэрэглээний барааны үнэ өсч, улмаар иргэдийн амьдралд хүндээр нөлөөлж, ажилгүйдэл, ядуурлыг улам ихэсгэж байна. Ам.долларын төгрөгтэй харьцах ханш Монгол банкны мэдээгээр 2020 оны 8 сарын 26 өдөр 2,852 төгрөгт хүрч өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд даруй 1000 төгрөгөөр нэмэгдээд байна. Ам.долларын ханшны чангаралт бизнес эрхлэгчид, төдийгүй айл өрх бүрийн амьдралд асар хүнд дарамт болж байна.

Дэлхий Монгол улсыг ингэж дүгнэж байна

Өнгөрсөн дөрвөн жилд манай улс дэлхийд байж болох эдийн засгийн бүх хоригт орж дэлхийн улс орнуудын сүүлийг мушгижээ. Ийм шившигт байдалд зах зээлийн нийгэмд шилжсэн цагаас хойш орж байсангүй.

- 2017 оны 12 сарын 5 өдөр: Европын Холбооны Татварын асуудлаар хамтран ажилладаггүй улсын жагсаалтад оров.
- 2019 оны 10 сарын 18 өдөр: Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ФАТФ-ын Саарал жагсаалтад оров.
- 2020 оны 5 сарын 7 өдөр: Европын Холбооны Хар жагсаалтад орсны үр дагавар аж ахуй нэгж, ард иргэдийн нуруун дээр даашгүй хүнд ачаа болж нэмэгдлээ. Ийм хүнд байдалд орсноор нэмэгдсэн эдийн засгийн бүхий л дарамт зөвхөн иргэд, аж ахуй нэгжийн нуруун дээр ирсэн.

Ирэх дөрвөн жилд Засгийн газар, гадаад бондын 2.9 тэрбум ам.доллар, Монгол банкны своп, бусад төрийн болон төрийн бус компаниудын 11 орчим

тэрбум ам.долларын гадаад өрийг төлөх үүрэгтэй. Ийнхүү Монгол улс гадаад өрөө төлж чадахгүй дефолт зарлах хэмжээнд ойрхон очоод байна.

Өнгөрсөн гурван жилд уул уурхайн бүтээгдэхүүний ханш хэд дахин өсөж, ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд гадаадын донор улс орон болон санхүүгийн байгууллагуудаас их хэмжээний валют манай улсын эдийн засаг орсон таатай үед Монгол Улсын эдийн засаг огцом агшиж, төсвийн алдагдал хэдэн их наядаар нэмэгдэн архагшиж, төсвийн зарлага хоёр дахин данхайж, гадаад өрөнд живж, валютын ханшаа алдаж эдийн засаг дампуурсныг дээр дурдсан эдийн засгийн макро үзүүлэлтүүд харуулж байна. Олон улсын санхүүгийн байгууллагууд ч ийм дүгнэлт хийж байна. Зах зээлийн нийгэмд шилжсэн гучин жилийн түүхэнд Монгол Улсын бие даасан эдийн засгийн дархлаа ингэж сульдаж, доройтож байсангүй.

Төсвийн тодотголоор төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжлийг дэмжих, дундаж давхаргаа хамгаалах, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой байв. Таван толгой, Оюу толгой, Эрдэнэтийн томоохон төслүүдийг урагшлуулж Экспортыг эрс нэмэгдүүлэх, эдийн засгийг тэлэх бодлогыг нэн яаралтай эрчимжүүлэх шаардлагатай байна. Мөн ХАА-н салбарын түүхий эдийг боловсруулах нэмүү өртөг шингэсэн төслүүдийг цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, коксжих нүүрс, төмрийн хүдрийг түүхийгээр нь экспортлохын сацуу ширэм, ган боловсруулах цогцолбор барьснаар эдийн засгийг дахин тэлэх боломжийг ашиглах шаардлагатай байгааг эрх баригчдыг мэдэж байгаа гэдэгт итгэж байна.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг Засгийн газраас өргөн барьсан “улс орон, бизнес эрхлэгчдээ дампуурууллж, ард түмнээ ядууруулах” төсвөөсөө цаашид татгалзаж, ирээдүйн зөв суурийг эхлүүлэх төрийн бодлоготой, тооцоо судалгаатай алдагдалгүй төсөв батлахыг шаардаж, бас уриалж байна. Монгол улсын эдийн засаг хүчирхэг байх нь Монгол улсын эрх ашигт нийцнэ. Төр бизнестэй хутгалдах биш харин хувийн хэвшлээ дэмжиж чөлөөт зах зээлийг тууштай дэмжих бодлого гаргаж байх ёстой гэдгийг дахин сануулъя.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-16-30
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.10.16 № 02

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд хийх Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн мэдээллийн талаарх УИХ дахь Ардчилсан намын бүлгийн санал дүгнэлт

Эрхэм УИХ-ын дарга, гишүүдээ!

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Дэлхий дахинаа коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэж, зарим улс орон хүндрэлийг бүх хүчээрээ даван туулж байгаа бол зарим нь халдварын хоёр дахь үе давлагаалж газар авч байгаа хүндэн цаг үеийг бид туулж байна.

Монгол Улсын хувьд коронавируст халдварт цар тахлыг дотооддоо алдалгүй хяналтдаа авч ирсэнд Монгол Улсын Засгийн газар болон цар тахалтай тэмцэх үйл хэрэгт хүчин зүтгэж буй нийт ажилтан албан хаагчдад, түүний дотроос цар тахлын халдварыг хүний эндэгдэлгүйгээр эмчлэн эдгээж буй эмч, эмнэлгийн байгууллагын албан хаагчдадаа талархал илэрхийлье.

Цар тахал гэдэг бол нэг улсаар тогтохгүй хүн төрөлхтний хэмжээнд аюул занал учруулж, хүний эрүүл мэндээс гадна улс орны эдийн засаг, улмаар нийгмийн байгуулалд хүртэл гай тарьж, мэрэн сүйтгэдэг гамшиг юм. Нэг улс дангаар тэмцэж чадахгүйн нэгэн адил нэг орны Засгийн газар ч дангаар тэмцэх боломжгүй юм. Коронавируст цар тахалтай Монгол Улсын иргэн бүр, байгууллага бүр төрийн хувийн, хэвшил гэлтгүй өргөн хүрээнд хамтран тэмцэх шаардлагатай. Бид цар тахлын эхний тархалтыг амжилттай даван гарсан ч хөрш орнууд дахь нөхцөл байдал, дахин дэгдэлт нь биднийг илүү том сорилтын өмнө авч ирж байгааг мартаж болохгүй бөгөөд илүү өндөр түвшний бэлэн байдлыг зүй ёсоор шаардаж байна.

Улсын Их Хурал /УИХ/ дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг үгүйсгэхээс илүүтэйгээр бодит шүүмжлэлийг товчхон дурдахын зэрэгцээ, зайлшгүй чухал зүйлсийг санал болгохыг зорилоо. Цөөнхийн бүлгийн зүгээс хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэн коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн эрх баригчдын өнгөрсөн хугацааны ажлуудад дараах шүүмжийг өгч байна.

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал дэгдээд бараг бүтэн жил болох гэж байхад бид өнөөдөр бэлэн байдлыг хангах чиглэлээр “ажиллаж эхэлж байгаа”-гаа тайлагнаж байгаа нь хамгийн ихээр сэтгэл түгшээж байна. Ерөнхий сайдын мэдээллээс харахад стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа, нарийвчилсан төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байгаа, бэлтгэж эхэлнэ, төлөвлөж байгаа гэх мэтээр хэрэгжүүлэх ажлууд ирээдүй цаг дээр дурдагдаж байгаа нь бид өнгөрсөн хугацаанд хөл хорио тогтоосноос өөр стратегигүй явж ирсний илрэл гэж дүгнэхээр байна.

2. Улс орны нийгэм, эдийн засгийн чухал асуудлууд цар тахлын нөлөөллөөс үл хамааран урт хугацааны бодлогын чиглэл рүү хэрэгжиж байх ёстой атал авч хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлогууд, 2020 оны төсвийн тодотгол, 2021 оны улсын төсвийн төсөл зэрэг нь эрэмбээ зөв тодорхойлоогүй, өрийг нэмэгдүүлсэн, төсвийн алдагдлыг бууруулахгүйгээр зардал хэт өндөр байгаад анхааран дотоод нөөц, үрэлгэн байдалдаа зөв менежмент хийх боломж байхад буруу төлөвлөчихөөд асуудал бэрхшээл бүрийг “Ковид” уруу чихэх нь гарц биш шүү гэдгийг анхааруулмаар байна.

3. Эдийн засгийн хүндрэлийн үе дэх Засгийн газрын үйл ажиллагаа, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний дутагдалтай асуудлуудад шүүмжлэлтэй хандсан нэгэн рүү хэт эмзэгээр хандаж, “Цар тахлыг улс төржүүлэхгүй шүү” гэх байдлаар хариуцлагаас зайлсхийх нь зөв хандлага биш юм.

4. Коронавируст цар тахлын үед дэлхий нийтийн өмнө тулгамдаад байгаа олон асуудал байгаагаас анхаарал хандуулах нэгэн чухал зүйл бол цар тахлын үеийн хорио цээрийн дэглэм нь Ардчиллын үнэт зүйлсэд заналхийлж, хүний эрх, эрх чөлөөг боомилох, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах оролдлогууд байгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас анхааруулах болсон. Ардчилсан Монгол улсын хувьд бидний эрхэмлэн нандигнах зүйл нь ямар ч хүндрэл бэрхшээлийн үед хүний эрх, эрх чөлөөг хамгаалах замаар ардчилсан тогтолцоогоо бэхжүүлэх явдал болохыг УИХ дахь Ардчилсан намын зүгээс онцгойлон мэдэгдэж байна.

5. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед гадаад дотоодын байгууллага, иргэдээс ирүүлсэн хандив, зээл, тусламж түүний зарцуулалтыг ил тод болгох нь Засгийн газрын үүрэг бөгөөд түүний зарцуулалтад хяналт тавих боломжийг иргэдэд олгох нь зүй ёсны хэрэг гэж үзэж байна. Дотоодод бий болсон хандив, тусламжийн мөнгөөр дунд шатны дарга нар нэгнээ шагнаж, гадаад орны донор байгууллагуудаас өгсөн зээл, тусламжийн хөрөнгийг хэрхсэн нь өнөөдрийг хүртэл нууц байсаар байгаад иргэд бухимдалтай байгаа. Аюулт цар тахалтай тэмцэх үед гавьяа зүтгэл гаргаж буй хүмүүсийг шагнаж урамшуулах нь зүй ёсны бөгөөд гагцхүү шагнал зөв хүндээ хүрч

буйд хяналт тавьж дарга нар, улс төрчид нэгнээ шагнаж буй асуудалд хариуцлага тооцох шаардлагатай байна.

6. Цар тахлын үед тогтоосон хөл хорооны дэглэмийг улс төрд ашиглах, нэг нам жагсаал цуглаан хийхэд үйлчлээд нөгөөд үйлчлэхгүй байх, сургууль сургалтын байгууллагын хаалга бариастай байхад бар караокэг нээдэг байдлаар илт ялгамжтай, оновчгүй зохицуулалт, нугалаа хийгдэж байсныг эргэн хараарай.

Дэлхий нийтийн өмнө тулгараад буй энэ аюулт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлд бид бүх төвшинд хамтран ажиллах ёстой. Иргэд нь хариуцлагатай, бизнес нь стратегитай, төр нь бодлоготой, гүйцэтгэлтэй, ёс зүй болоод дэг журамтай байж, олон улсын хэмжээнд хамтран ажиллах нь нэн чухал билээ. Монгол улс цар тахалтай тэмцэх бодлого, стратегийг дараагийн шатанд шилжүүлж, илүү өндөр төвшний бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн байх ёстой. Гэвч төлөвлөгөөний шатанд яваа энэ үед авч хэрэгжүүлэхүйц саналуудыг хүргүүлж байгааг хүлээн авна уу. Үүнд:

Нэг. Дотоодод халдвар алдахгүй байх стратеги төлөвлөлтийг үргэлжлүүлэх нь нэн тэргүүний зорилт гэдэгтэй санал нэгдэж байгаа ба энэ хүрээнд Монгол улсад нэвтрэх иргэдийн урсгалд дэвшилтэт технологи, зохион байгуулалттай арга хэрэгсэл нэвтрүүлэх, хүнд суртлыг бууруулахад санаачилгатай ажиллах. Хөл хорио тогтоож буй дэглэм, журмыг олон улсын стандартад нийцүүлэх, тусгаарлах байрны хоногийн тоог 21 хоногоос өндөр түвшний 14 хоногт шилжүүлэх, байр, хоолны чанарт анхаарах,

Хоёр. Цар тахлын үеийн хорио цээрийн дэглэмийн үед хүний эрх, эрх чөлөөг боомилсон арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байхад онцгой анхаарч нэг талаас иргэний үүрэг, хариуцлагыг ойлгуулах, нөгөө талаас “хорих” бус “сонгох боломж”-ийг түлхүү ашиглах,

Гурав. Дотооддоо халдвар тархаагүй энэ үед дампуурахдаа тулж, ажилчдаа цомхтгон үүдээ барьж байгаа аялал жуулчлал, үйлчилгээний зэрэг бизнесийн салбарт тохирсон оновчтой бодлого хэрэгжүүлэх, дотоодын аялал жуулчлалыг дэмжих, бизнесийг эргэлтийн хөрөнгийн эх үсвэрээр дамжих замаар орлогыг тогтвортой байлгах, ажлын байрыг хадгалах, төсвийн зардлыг тэлэхээс илүүтэй эдийн засгийг тэлэхэд анхаарах,

Дөрөв. Цар тахлын хөл хорио тогтооход хамгийн ихээр өртөж буй боловсролын салбарт өөрчлөлт шинэчлэлт, дасан зохицох оновчтой бодлогыг цаг алдалгүй авч, бэлэн байдлын зэргийг нэмэгдүүлэхийн сацуу, онлайн сургалтын үр дүнтэй хувилбарыг сонгох, цахим технологийн шилжилт хийх,

Тав. Цар тахалтай тэмцэж буй салбар, нэгжүүд, түүний дотор эмнэлгийн байгууллагуудын байр, техник хэрэгслийг сайжруулах, эмч, эмнэлгийн ажилтнуудыг сургах, бэлтгэх, эмнэлгийн чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар бэрхшээлийг боломж болгон ашиглаж, цар тахлын халдвартай амжилттай тэмцэх, цаашид Ковидын дараах үед эрүүл мэндийн гарах урсгалыг орох урсгал болгох чадавхтай салбар болгоход Ковидтой тэмцэхэд өгч буй гадаадын орнууд, донор байгууллагуудын зээл, тусламжийг бодлогоор чиглүүлэх,

Зургаа. Ерөнхий сайдын мэдээллээс харахад манай улсын хүн амын дунд халдвар тархаж, 1 хувь буюу 32,000 хүн халдварт өртвөл түүний 4.935 хүний биеийн байдал хүндрэх, 1.645 хүний биеийн байдал маш хүнд эрчимт эмчилгээнд орохоор байгааг дурджээ. Гэвч төлөвлөлтөөр орны тоо яригдсанаас бус эрчимт эмчилгээний тасаг, тэнд шаардлагатай амьсгалын аппарат зэрэг нэн чухал төхөөрөмжүүдийн бэлтгэл хангалтгүй байгаад анхаарч шийдвэрлэхгүй бол хоосон ор цар тахалтай тэмцэхгүй болохыг анхааруулъя. Ковид-19-ын вакцинд хэт найдлага тавин хүлээлт үүсгэхгүйгээр ХӨСҮТ, Зоонозын өвчин судлалын төвийг мэдрэг чадвар өндөртэй, илүү хурдан оношлох коронавирусын оношлууpаар бүрэн хангаж бэлтгэх ажлыг нэн тэргүүнд зохион байгуулах шаардлагатай байна.

Коронавируст халдварт цар тахалтай тэмцэх үйл хэрэгт Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь шат дараалсан улс төрийн сонгуульд бус иргэдийнхээ эрүүл мэнд, эдийн засгийн боломжийг хамгаалахад чиглэх ёстойг ч энэ ташрамд дурдъя.

Нийгмийн аль ч цаг үед олон нийтийн хараа хяналтыг алдагдуулахгүй байх, иргэдийн мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боомилохгүй, хөл хорио, тусгаарлалтын дэглэм нэрээр хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахгүйгээр хамтран ажиллаж, цар тахалтай бүх нийтээр тэмцэхэд бодлогын гол цөмийг чиглүүлэхийг эрх баригчдад уриалж байна.

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс коронавируст цар тахалтай тэмцэх, түүний нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой Засгийн газрын аливаа бүтээлч үйл хэргийг дэмжин, зөв чиглүүлэхэд санаачилгатай, хяналттай ажиллах болно.

Улс орон амар амгалан, иргэд маань энх тунх байх болтугай.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

УИХ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-61-64
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.10.29 № 03

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНД

"Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын тогтоолын төсөлд УИХ дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлт

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ!

Монголбанк 2021 онд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслөө УИХ-д өргөн мэдүүллээ. Тайлант оны төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийн явц, санхүүгийн зах зээлийн байдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тайлбарласан дүгнэлт, ирэх жил төлөвлөсөн үндсэн чиглэлтэй Ардчилсан намын бүлэг танилцаж, судалсны үндсэн дээр дараах дүгнэлтийг гаргаж байна.

Эрх баригчид гаргаж буй бодлогын алдаандаа үнэлэлт дүгнэлт өгч засаж сайжруулахын оронд өрсөлдөгч улс төрийн хүчиндээ тохож харлуулах, эсвэл ямар нэгэн зүйлийг онцолж булталдаг буруу зуршлаа энэ удаа ч орхисонгүй. Энэ удаа өмнөх дөрвөн жилд гаргасан алдаа, дутагдал бүхнээ Ковид-19-д наахаар шийджээ. Монголбанкнаас өргөн мэдүүлж буй мөнгөний бодлогыг эрх баригчид алга ташиж хүлээн авч болох ч, ард иргэдийн амьдралд ямар үр нөлөө үзүүлж байгааг анзаарч харахыг та бүхнээсээ хичээнгүйлэн хүсэж байна.

Мөнгөний бодлогын үндсэн зорилтыг Монголбанк хэрхэн биелүүлж, хэрэгжүүлж чадаж байна вэ? Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд "Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино" гэж маш тодорхой заасан байдаг.

Нэг ам.доллар 17 боодол нэгтийн дэвсгэрттэй тэнцсэн талаар улс орон даяар түгшүүрийн харанга дэлдэж, энэ алдаа, завхралыг даруй засаж залруулах амлалт өгсөн улс төрийн хүчин өнөөдөр ажлаа тайлагнаж байна. Харамсалтай нь, нэг ам.доллар аль хэдийн 29 боодол нэгтийн төгрөгтэй тэнцэх хэмжээнд ирлээ. Монгол улсын үндэсний валют болох төгрөгийн ханш сүүлийн дөрөвхөн жилийн хугацаанд дөчин хувиар үнэгүйдэж, суларчээ. Дэлхий улс орнуудаас ханшаа ингэж алдсан улсыг та хайгаад олохгүй. Манай улсын нийт импортын 70% ам.долларaар хийгддэг ба хэрэглээний сагсны 40% импортын бараа эзэлдэг. Тиймээс, гадаад валютын ханшийн чангаралт, тэр тусмаа ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн чангаралтаас шалтгаалж импортын болон өргөн хэрэглээний барааны үнэ өсөж улмаар иргэдийн амьдралд, ялангуяа тэтгэврийн насны ахмадууд, дундаас доош орлоготой иргэдийн амьдралд туйлын хүнд цохилт ирж байна. Мөн улс орны хүндийг нуруундаа үүрч яваа

бизнес эрхлэгчид, тэр дундаа долларын зээлтэй зээлдэгчдийн хувьд асар хүнд дарамт болж буй гэдэгтэй та бүхнийг санал нэгдэх байх гэж найдаж байна.

Монголбанк өөрөө ханшаа хөөрөгдсөн нь харамсалтай. Зах зээлийн нийгэмд шилжсэн 26 жилийн хугацаанд буюу 2016 оны 3 сард мөнгөний нийлүүлэлт (М2) нь 10.1 их наяд төгрөг байжээ. Гэтэл дөрөвхөн жилийн дотор буюу 2020 оны 9 дугаар сарын эцэст 22.3 их наяд төгрөг болж, зах зээлд хоёр дахин их мөнгө нийлүүлсэн нь эдийн засгийн макро үзүүлэлт ялангуяа ханш огцом хөөрөгдсөн гэдгийг энд нурших илүүц биз. Хамгийн хачирхалтай нь, Монголбанк ханшаа бууруулахын тулд ямар ч үр дүнгүй интервенц хийсээр иржээ. 2016 оны сүүлийн 6 сард 1 тэрбум, 2017 онд 670 сая, 2018 онд 1.5 тэрбум, 2019 онд 2.9 тэрбум, 2020 он гараад 2.3 тэрбум ам.доллар буюу нийтдээ 8 тэрбум 370 сая ам.долларыг интервенцэд зарцуулжээ.

Ийм их хэмжээний валютыг олохын тулд Монгол улс алт, мөнгө, зэс, нүүрс, төмрийн хүдэр, цайр, нефть зэрэг үнэт баялгаа бүтэн хоёр жилийн турш олборлож экспортолдог гэдгийг сануулъя. Нэг гараараа мөнгөний нийлүүлэлтийг огцом ихэсгээд нөгөө гараараа баялгаас олсон валютаа зарж үгүй хийдэг мөнгөний бодлого дэлхий аль ч улсад байхгүй гэдгийг УИХ-ын чуулганы индэр дээрээс дахин мэдэгдье.

Мөнгөний бодлогын хоёр дахь гол зорилт болох санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлж чадаж байна уу? Бас л үгүй гэж хэлнэ.

Төв банкны үнэт цаасны (ТБҮЦ) хэмжээ нийт зах зээлд эргэлдэж буй нийт мөнгөний ¼-ийг буюу 5.3 их наяд төгрөгт хүрчээ. Монголбанк жилд арилжааны банкнуудад бараг 500 тэрбум төгрөгийн (Бодлогын хүүгийн хэмжээ 10 хувь байгаад хэдэн сарын өмнөөс 8 хувь болсон) хүү төлж байгаа нь өнгөрсөн дөрвөн жилийн хугацаагаар тооцвол 2 их наяд төгрөгийг арилжааны банкнуудад өгчээ. 3 их наяд төгрөгөөр 80,000 айлыг ипотект хамруулж олон мянган аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж, олон арван мянган ажлын байрыг шийдэж хямралаас амжилттай гарсан жишээ дэргэд маань бий шүү.

Монголбанкны үйл ажиллагааны үндсэн чиглэл болох банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих функц туйлын хангалтгүй байгаа жишээ дурдвал:

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 9 дүгээр сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.6 хувийг эзэлж байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 9 дүгээр сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.4 хувийг эзэлж байна.

Дурдсан хоёр үзүүлэлтийн нийлбэр 10 хувиас дээш гарсан тохиолдолд банкны салбар хямарч байна гэж олон улсад үздэг. Тэгэхээр Монголбанк хуулиар олгогдсон чиг үүрэг, зорилтоо хэрхэн биелүүлж байгаа нь эндээс тод харагдаж байна.

Тэгвэл олон улсын санхүүгийн байгууллагууд бидэнд ямар үнэлэлт дүгнэлт өгч байна вэ?

АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас 10 дугаар сарын 14-нд Монгол дахь хөрөнгө оруулалтын орчны шинжилгээг хийж тайлан гаргасан. Тус тайлангийн банкны салбартай холбоотой хэсэгт “Монгол Улсын банкны системийн дийлэнх нь хөрөнгө оруулалтгүй хэвээр байгаа, арилжааны банкны үйл ажиллагаа, зохицуулалтын хяналт нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад хангалтгүй хэвээр байна. ОУВС-аас мэдээлснээр харьцангуй нүсэр банкны тогтолцоог

чиглэсэн макро түвшний зохицуулалт хийхгүй байгаа нь Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг 2020 оны 5-р сард амжилтгүй дуусгахад хүргэсэн" гэжээ. 2019 онд Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (FATF)-ын саарал жагсаалтад мөнгө угаахтай тэмцэх асуудлаар орсон нь корреспондент банкны үйлчилгээнд хамрагдахад төвөгтэй болж, зардал, хугацааг нэмэгдүүллээ.

Төрийн арчаагүй бодлогын үр дүнд олон мянган аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд чирэгдэл учирч, олон арван мянган иргэдийн халааснаас гарах төлбөрийн хэмжээ нэмэгдэж тэд хохирч үлдлээ. Хэнд ямар хариуцлага тооцох вэ? Мөнгөний бодлогыг улс төрчдөд, дарга нарын хүүхдүүдэд эзэлжлэн атгуулсны гор ингэж л гарч байна.

2017-2019 онуудад Монгол улсын уул уурхайн экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ ханш дэлхийн зах зээл дээр хэд дахин нэмэгдсэн, ОУВС-ын хөтөлбөрт хамрагдаж 5.5 орчим тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл тусламж хүртэж эхэлснээр санхүүгийн зах зээл тогтворжин гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх сайхан боломж нэмэгдсэн юм. Үүлэн чөлөөний нар мэт ийм ховор сайхан боломж зах зээлийн нийгэмд шилжсэн гучин жилийн түүхэнд бараг тохиолдоогүй гэдгийг онцолж байна.

Гэвч төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом суларч, мөнгөний нийлүүлэлт эрс нэмэгдэж, олон улсын санхүүгийн байгууллагуудын хар, саарал жагсаалтад бичигдэж улмаар макро эдийн засгийн тогтвортой байдал эрсдэл дагуулах хэмжээнд хүрснийг дээр дурдсан статистик үзүүлэлтүүд батлан харуулж байна. Монгол Улсын хувьд эдийн засгаа тогтвортой хөгжүүлэх, иргэдэд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох, зээлийн хүүг бууруулах зэрэгт зээлжих зэрэглэл асар чухал. Гэвч манай улсын эдийн засгийн хөрөнгө оруулалтын зэрэглэл "эрсдэлтэй" ангилалд багтаж, зээлжих чадвар сул байгаагаас хөрөнгө оруулалтын зардал өндөр дүнтэй тогтож байна.

Энэ бүхэн өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн Мөнгөний бодлого "бай"-гаа огт оноогүйн тод жишээ юм. Засгийн газар болон Төв банкны хоорондох төсөв, мөнгөний бодлогын уялдаа алдагдаж, тэнцвэртэй нэгдсэн зохицуулалт дутагдаж, арга барилаа эрс шинэчлэх, үгүй болсон төрийн хариуцлагын механизмыг энэ чухал салбарт сэргээх зэрэг улс орны эдийн засгийн амьдралд онц чухал шаардлагатай шийдлүүд бидний өмнө хүлээгдэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-61-64
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.11.05 № 04

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНД

Монгол улсын 2021 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн талаарх УИХ дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлт

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ!

Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан 2021 оны төсвийн болон дагалдаж батлах бусад хуулиудын төсөлтэй УИХ дахь Ардчилсан намын бүлэг танилцаад дараах санал, дүгнэлтийг гаргаж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас ойрын хугацаанд цар тахлын ноцтой аюул үргэлжилж зарим оронд онц аюултай хандлага илэрч байгаа тул яаралтай арга хэмжээ авахыг уриалж буй ийм үед Монгол улсын Засгийн газраас бодит нөхцөл байдалтай огт нийцэхээргүй төсөв өргөн барьжээ. 2021 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүд өнгөрсөн хоёр жил өргөн барьсан төсвүүдээс ялгагдахаргүй болсон байна. Өнгөрсөн гурван жилд гааль, татвар, газрын цахимжуулалтын шинэчлэлийг хэрэгжүүлж орлогын эх үүсвэрийг бүрэн дайчилна гэсэн ганц лоозон дэвшүүлсэн. Ингээд 2019 онд нэгдсэн төсвийн нийт орлогыг 2018 оноос 3.2 их наяд төгрөгөөр, 2020 онд 1.8 их наяд төгрөгөөр, 2021 онд 2.4 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж 13.1 их наяд төгрөг байхаар тооцсон юм. Уул уурхайгаас 2019 онд 3 их наяд, 2020 онд 3.2 их наяд, 2021 онд 3.4 их наяд төгрөг төсөвт төвлөрүүлэх зорилт дэвшүүлсэн байна. Биелэгдээгүй мөртлөө гурван жил дараалан 42 сая тн нүүрс экспортолно гэж төлөвлөжээ. Энэ нь цар тахлын эрсдэлийг тооцох нь бүү хэл валют олдог үндсэн түүхий эдийнхээ тооцоо судалгааг бодитой хийж чадаагүй байгааг харуулж байна. Ийнхүү биелэхгүй өндөр орлого төлөвлөж байгаа нь төсвийн алдагдлаа бага дүнтэй харагдуулах, өөрсдөдөө ахиухан хөрөнгө хуваарилах халхавч тэдий юм.

Сүүлийн арав гаруй жил манай улсын нэг хүнд ногдох ДНБ ойролцоогоор 4000 ам.доллар, ядуурлын түвшин 30 хувьд эргэлдэж байна. Уул уурхайн олборлолт нэмэгдэж ДНБ-ний хэмжээ төгрөгөөр нэмэгдэж байгаа боловч энэ дүнг ам.доллар-оор

тооцвол 13 тэрбумаас хэтэрсэнгүй. Энэ нь төрийн бодлого улсын төсөвт тусгалаа олохгүй байгаагийн нэг илэрхийлэл юм.

Сонгуулийн жилүүдэд буюу 2008, 2012, 2016, 2020 онд нийгмийн халамжийн зардал, хөрөнгө оруулалт, төрийн албан хаагчдын тоо, тэдэнд олгох цалин огцом өссөн дүн гарчээ. Үүнийгээ уул уурхайн орлогоос гадна гадаадын зээллэгээр санхүүжүүлэх болжээ. Дөрвөн жилийн өмнө Монгол улсын төсвийн зарлага 6 их наяд төгрөгийн хэмжээнд тогтвортой эргэлдэж байсан бол ирэх онд 14 их наяд төгрөгт хүрч хоёр дахин өссөн байна.

2021 онд 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв өргөн барилаа. Гурван сарын өмнө 2020 оны төсвийн тодотголоор 4.8 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв батлагдсан. Хоёр жилийн хугацаанд буюу зөвхөн 2020, 2021 онуудад 7 их наяд төгрөгний өртэй болох тооцоо ийнхүү хийлээ. 7 их наяд төгрөгөөр 200 мянган өрхийг шинээр байранд оруулж болно. Нэг бог малыг 150 мянган төгрөгөөр тооцвол Монгол улсын нийт малын 65 хувь буюу 46 сая толгой бог малтай дүйцэх хэмжээний хөрөнгө төсвөөр дамжин үгүй болж байна.

Улс орон авсан зээлээ дахин зээлээр санхүүжүүлэх үеэс эхлэн “өрийн хавх”-нд орсонд тооцогддог. Олон улсын санхүүгийн байгууллагууд "Монгол улс сүүлийн 20 жилд уул уурхайн салбараас орж ирсэн 100 төгрөг тутмын ердөө нэг төгрөгийг хойч ирээдүй үедээ хуримтлуулж байна. Монгол Улс хойч үедээ өр өвлүүлж байна" гэж онцгой анхааруулсан. Засгийн газрын өр зах зээлд орсон цагаас эхлэн 2016 оны 2-р улирал хүртэл 4 тэрбум 785 сая ам.доллар байсан. Гэтэл УИХ-д МАН-ын олонхи байсан өнгөрсөн дөрвөн жилд 3 тэрбумаар нэмэгдэж нийт дүнгээрээ найман тэрбумд хүрч Монгол улсын эдийн засаг, тусгаар тогтнолын аюулгүй байдалд аюул занал учруулах хэмжээнд хүрснийг анхааруулж байна.

Сүүлийн үед төсвийн хөрөнгө оруулалт нэрээр асар их хөрөнгийг үр өгөөжгүй зарцуулж ирлээ. 2016-2020 онд нийт 5 их наяд 945 тэрбум төгрөг хөрөнгө оруулалтад ашиглажээ. 2021 онд төсвийн төсөлд улсын төсвөөс 1.6 их наяд төгрөг, гадаадын зээлээр 1.2 их наяд төгрөгийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хөгжил дэвшилд хүрсэн улс орнуудын хувьд төсвийн хөрөнгө оруулалтыг, ихэвчлэн орлогын шинэ эх үүсвэр бий болгох, импортыг орлох үйлдвэрүүд, иргэдийнхээ амьдралд нэн чухал хүний хөгжилд чиглэсэн салбарыг дэмжихэд зориулж байна. Гэтэл бид татвар төлөгчдийн мөнгийг элдэв хөшөө дурсгал, шат шатны засаг дарга нарт тухлах байр, үнэтэй унаа, тансаг тавилга авах зэргээр үр ашиггүй зарцуулж байна. Төсвийн хөрөнгө оруулалтыг яаралтай эрэмбэлж, улс орны хөгжлийн бодлогод зориулах цаг болжээ.

Уул уурхайн баялгийн өгөөжийг илүү төрөлжсөн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт болгон хувиргахын оронд халамжид хавтгайруулж эхэллээ. Ирэх онд төсвөөс 1 их наяд 650 тэрбум төгрөгийн 73 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг давхардсан тоогоор 2 сая 655 мянган иргэнд өгөхөөр төлөвлөсөн байна. Бэлэн мөнгө тараах, халамжийг нэмэгдүүлж ядуурлаас гарч, ажилгүйдлийг шийдвэрлэсэн улс байдаггүй.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг сайжруулах дараах шийдлүүдийг санал болгож байна. Үүнд:

1. Үндэсний Аудитын газраас төсвийн орлого бүрдэх хүндрэлтэй, гадаад өр төлөгдөхөөр хүлээгдэж байгаа өнөө цагт тэвчиж болох зардлуудыг 20 хүртэл хувиар бууруулах шаардлагатай гэж дүгнэсэн. Харин бид энэ зардлыг 40 хувьд хүргэх боломж байгаа гэж үзэж байна. Төсвийн байгууллагын аливаа сургалт семинар, хурал зөвлөгөөн, гадаад дотоод албан томилолтыг эрс багасгах, төрөөс иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг бүх төрлийн үйлчилгээ, тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулах замаар зардлыг эрс бууруулах бүрэн боломж байна.

2. Хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлж үзэхэд 149 төслийг нэг жил царцаахад 405 тэрбум 464 сая төгрөг хэмнэж болохоор байна. Нэмээд уул уурхайгаас төсөвт ордог орлогын 20 хувийг Жижиг Дунд Үйлдвэрлэлийг дэмжих санд төвлөрүүлэх бүрэн боломжтой. Энэ хоёр хэмнэлтээс гэхэд нэг их наяд төгрөгийг импортыг орлох, ажлын байр нэмэгдүүлж буй аж ахуй нэгж, жижиг дунд үйлдвэрлэгчдийнхээ үйл ажиллагааг дэмжиж болохоор байна.

3. Төрийн албан тушаалын хийдлийг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор төрийн албыг цомхтгох, ялангуяа дэд сайд, агентлагийн дэд дарга, газрын дарга зэрэг удирдах албан тушаалын давхардлыг арилгах нь эдийн засаг хямарсан энэ үед зайлшгүй хийх ёстой арга хэмжээ юм.

4. Монгол улсын хэмжээнд 32 их наяд төгрөгийн хөрөнгөтэй олон зуун төрийн өмчит компаниуд, төрийн өмчит үйлдвэрийн газруудын үр өгөөж багатай, ашиггүй ажиллаж байна. Төрийн өмчит компаниудын үр дүнтэй удирдлагыг тогтолцоог эрс сайжруулж, хувьчлалыг хойш тавилгүй эхлүүлэх хэрэгтэй байна.

5. Улсын төсөв дарга, гишүүд, сайд нарын сонгуульд ялах хэрэгсэл огт биш. Харин улс орныг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн амьдралыг дээшлүүлэхэд чиглэгдэх ёстой юм. Монгол улсын 100 орчим сумдад нэг ч төгрөгийн хөрөнгө оруулалт тавиагүй мөртөө нэг сумын багт хоёр жил дараалан 40 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавьсан байна.

Засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөл тооцоо судалгаа бодит бус болсон төдийгүй Төсвийн тухай хуулийн 6.2.4, 6.4.1, 6.4.7, 6.4.8, 6.5.1-ээс 6.5.6, 27.1.2, 27.1.3, 28.3.10, 28.6 зэрэг олон заалтуудтай зөрчилдөж байна. Төсвийн зардлаа танаж, алдагдал багатай батлах, гадаад өрийн дарамтыг эрс багасгах, үр ашиггүй хөрөнгө оруулалтаа эрэмбэлэх зарчмууд өргөн барьсан төсөлд тусгалаа олсонгүй. Иймээс Засгийн газар өргөн барьсан төсвийн төслөө эргүүлэн татаж сайжруулан дахин өргөн барих шаардлагатай байна гэж УИХ дахь Ардчилсан намын бүлэг үзлээ.

Төрийн мөнгө гэж байдаггүй, харин төрд татвар төлөгчдийн мөнгө бий гэдгийг байнга санаж байхыг анхааруулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-61-64
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.12.04 № 05

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан хуулиудад бүхэлд нь тавьсан хоригтой холбогдуулж УИХ дахь Ардчилсан намын бүлгээс хийх санал дүгнэлт

Эрхэм УИХ-ын дарга, гишүүдээ!

Дэлхий эрүүл мэндийн байгууллагаас коронавируст халдварыг цар тахал хэмээн зарласан. Монгол Улсын Засгийн Газар, Улсын онцгой комисс 2020 оны 3 дугаар сараас эхлэн хөл хорионы дэглэм тогтоож, улмаар Монгол Улс дотооддоо цар тахлын халдварыг алдсан учир 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин хатуу хөл хорио тогтоож, дахин 10 хоногоор сунгасан энэ бүх хугацаанд өнөөдрийн байдлаар халдвар авсан нийт хүн 819, үүнээс дотооддоо халдварласан тохиолдол 436 болж нэмэгдсээр байна. 2019 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын **3 хүн тутмын 1 нь ядууралд өртсөн** гэсэн статистик байсан бол **өнөөдрийн байдлаар 2 хүн тутмын 1 нь ядууралд өртөж**, аж ахуйн нэгж байгууллагууд хаалгаа барьсны улмаас **150 мянга гаруй ажлын байр байхгүй болсон байна.** Энэ байдал үргэлжилбэл **он дуусахад 430 гаруй мянган хүн ажлын байраа алдахаар байна.** Иргэд орлогогүй болж, ажлын байраа алдсанаар цаашид амь амьжиргаагаа залгуулах боломжгүй нөхцөлд шилжиж байгаа бөгөөд 2020 оны 10 дугаар сарын байдлаар нийт айл өрхүүдийн 72 хувь нь хадгаламжгүй байгаа нь цар тахлын үеийн хөл хорионы үеийг даван туулах боломжгүй байна.

Улсын Их Хурал /УИХ/ дахь Ардчилсан намын бүлгээс 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан дээр Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийг Засгийн газар эргүүлэн татаж, төсвийн зардлыг танаж, төсвөө алдагдал багатай батлах, өсөн нэмэгдэж буй өрийн дарамтыг эрс багасгах, үр ашиггүй хөрөнгө оруулалтаа эрэмбэлэх асуудлаар тодорхой саналуудыг хүргүүлж, засаж залруулан дахин өргөн барихыг шаардсан билээ.

Гэвч эрх баригчдын зүгээс Төсвийн тухай хуулийн олон заалтуудтай зөрчилдсөн, 2021 онд **2.1 их наяд төгрөгийн алдагдалтай** байхаар боловсруулсан төслөө баталсан. Одоогоос дөрвөн сарын өмнө буюу УИХ-ын

ээлжит бус чуулганы хуралдаанаар өмнөх оны төсөвт тодотгол хийхдээ мөн **4.8 их наяд төгрөгийн алдагдалтай** төсөв баталсан. Иймхүү хоёр жилийн хугацаанд төсөв, санхүүгийн буруу шийдвэрийн үр дүнд **Засгийн газрын өрийг 6.9 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн** болохыг энд дахин сануулъя. 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр УИХ дахь Ардчилсан намын бүлэг энэ хүнд цаг үеийг ойлгон, улс төржиж намчирхалгүйгээр ард түмний эрх ашгийг эн тэргүүнд тавьж, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн төслийг эцэслэн хэлэлцэх үед *"төсвийн тухай хуулийн төслийг хуулийн хугацаанд нь эцэслэн батлах үйл явцыг хялбаршуулсан горимоор хэлэлцэж, улмаар* ***нэн даруй төсвийн тодотгол хийх****"* горимын санал гаргаж олонхын саналаар дэмжигдсэн. Гэтэл эрх баригчид нийт ард түмний өмнө гаргасан шийдвэрээсээ буцаж, төсвийн тухай хуулиа тодотгож алдаагаа засах ёстой байтал элдэв шалтаг тоочин хойшлуулсаар байна.

Иймд УИХ дахь Ардчилсан намын бүлгээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан хуулиудад бүхэлд нь тавьсан хоригийг дэмжиж байгаа болно.

Тодруулбал,

1. Ирэх оны төсвийн хөрөнгө оруулалтаас эмнэлэг, сургууль, цэцэрлэг, онцгой байдал, хил гаалийн байгууллагад хийх хөрөнгө оруулалтыг хэвээр нь үлдээж, бусдыг нь ач холбогдлоор нь эрэмбэлж үзэхэд 1 их наяд 185 тэрбум төгрөгийн өртөгтэй 149 төслийг царцааж **405 тэрбум 464 сая төгрөг хэмнэх** боломж байна. Мөн уул уурхайгаас төсөвт ордог орлогын 20 хүртэл хувийг буюу нийлбэр дүнгээрээ нэг их наяд төгрөгийг ЖДҮДСанд төвлөрүүлж импортыг орлох, ажлын байр бий болгож буй аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг дэмжих,
2. УИХ-аар батлагдсан Монгол Улсын 2021 оны төсөв нь Төсвийн тухай **хуулийн 14 заалтыг зөрчиж байгааг** эргэн харж хуульд нийцүүлэх,
3. Төсвийн орлого бүрдэхэд хүндрэлтэй, гадаад өр төлөгдөхөөр хүлээгдэж байгаа өнөө цагт **тэвчиж болох зардлуудыг 20 хүртэл хувиар бууруулж**, төсвийн хэмнэлтээр бий болсон хөрөнгөөр цар тахлын сөрөг нөлөө болон эрх баригчдын явуулж буй бодлогоос болж дампуурахад хүрсэн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилго бүхий Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт тусгагдсан "Эрсдлийн сан"-г байгуулах,
4. Засгийн газраас бонд гаргах замаар эх үүсвэр бүрдүүлж, эдийн засгийг сэргээхэд зориулан 0 хувийн хүүтэй урт хугацаатай зээлийг иргэн, аж ахуйн нэгжид яаралтай олгох,
5. Коронавиурсын халдварын эсрэг вакцин худалдан авах төсвийг гадаад улсын зээл тусламжын хөрөнгөөр бус 2021 оны улсын төсөвт суулгаж шийдвэрлэх,
6. Коронавируст халдварын цар тахлыг дотооддоо алдсаны улмаас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хатуу хөл хорио тогтоож, бизнесийн үйл ажиллагааг зогсоосноор эдийн засагт хүнд цохилт болоод зогсохгүй иргэдийн орлого эрс буурч, үйлдвэр аж ахуйн нэгжүүд хаалгаа барьж, ажилгүйдэл нэмэгдэж, айл өрхийн амьжиргаа туйлын хүнд байдалтай байгаа энэ цаг үед Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан ***"Төрөөс өрх бүрд нэг сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг яаралтай***

боловсруулж, 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны нэгдүгээр сарын 01-ний өдрийн дотор хэрэгжүүлэх, ингэхдээ 200,000 төгрөгийг бэлнээр олгож, үлдсэн 800,000 төгрөгийг зөвхөн үндэсний үйлдвэрлэгчээс архи, согтуурууллах ундаа, тамхины төрлөөс бусад бараа, бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг (ваучер) олгох" тухай саналыг хүлээн авч хэрэгжүүлэн, айл өрх бүрийг дэмжих замаар үндэсний үйлдвэрээ дэмжсэн бодлогыг гаргаж нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзэж байна.

Үүсээд байгаа нөхцөл байдал, дээр дурдсан шалтгаан зэргийг харгалзан төсөвт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгаа тул Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан хуулиудад бүхэлд нь тавьсан хоригийг алдаагаа засах боломж гэж ойлгон УИХ хүлээн авах шаардлагатай байна.

Нийт ард иргэдээ бодож асуудалд эрүүл саруул ухаанаар хандана гэдэгт итгэж байна.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН
НАМЫН БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, ш/х-9, Утас: 26-00-79, Факс: 26-61-64
Цахим шуудан: anbuleg@gmail.com

2020.12.04 № 06

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД

Зам тээврийн салбарт хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлд хийж буй УИХ дахь Ардчилсан намын бүлгийн санал дүгнэлт

Эрхэм УИХ-ын дарга, гишүүдээ!

Зам тээврийн салбарт хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсож, танилцлаа.

Монгол Улс нэгдмэл нэг улсын хувьд төрийн бодлого нэгдмэл байж, түүний залгамж чанар уламжлагдан хадгалагдаж явах ёстой билээ. Гэтэл өмнөх Засгийн газрын үед батлагдсан бодлого, дараагийн Засгийн газрын үед хэрэгждэггүй, өмнөх Улсын Их Хурал /УИХ/-аар батлагдсан хөгжлийн бодлого, дараагийн хууль тогтоох байгууллагын үед өөрчлөгдөн үгүйсгэгдэх боллоо. Энэ нь тогтвортой хөгжлийн чиг хандлагыг үл ойшоосон, аливаад улс төржилтөөр хандах хандлага газар авсныг илтгэж байна.

Зам тээврийн салбарт хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх Ерөнхий сайдын мэдээллээс харахад 2016 онд УИХ-аар батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д тусгагдсан бүтээн байгуулалтын 2016-2020 оны хооронд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн биелэлт хангалтгүй байна. Тус салбарын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого руу өөрчлөн тусгахдаа ихээхэн хийдэл гаргажээ. Энэ хэрээр дэд бүтцээс шалтгаалах эдийн засгийн боломжууд алдагдаж байгаад эрх баригчид анхаарал хандуулах биз ээ.

Мэдээлэлд дурдагдсан ихэнх ажлууд, тухайлбал аймгийн төвүүдийг нийслэл Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажил тэртээ 2012-2016 онуудад хийгдсэн гэдгийг хүн бүр мэдэж байгаа. Харин Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын барилгын ажил болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга оролцоотойгоор төмөр замын салбарт хийгдэж буй Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.2 км, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 258.4 км төмөр замын барилгын ажлаас өөр нүүр тахлах томоохон бүтээн байгуулалт харагдахгүй байгаа нь өнөөгийн Засгийн газар улс орны хөгжилд хуруугаа ч хөдөлгөх сонирхолгүй, чадваргүй байгааг харуулсан бодит баримт юм. Гэтэл хоёр сонгууль дамнан сонгогчдын дэмжлэг авч 5 жилийн турш тасралтгүй засаглаж байгаа эрх баригчид улс орны нийгэм, эдийн засгийн амин судас болсон дэд бүтцийн салбарт огт ахиц гаргасангүй.

Зам, тээвэр, дэд бүтцийн салбарт мега төсөл хэрэгжихэд хүндрэлтэй, эрх бүхий байгууллагуудын шийдвэр бүрхэг, эрх зүйн орчин дутмаг, эрх үүргийн давхцал ихтэй, ашиг сонирхол, албан тушаалын асуудалд ороцолдсон, төслийн менежментийн мэдлэг туршлага муу, гүйцэтгэл, хяналтын шатанд алдаа дутагдал ихтэй байна. Тухайлбал,

1. Төрийн эрх бүхий байгууллагууд хэн юу хийж байгаагаа мэдэхээ байтлаа хөл толгойгүй болсон, зөвхөн албан бичиг солилцох төдийхнөөр ажил хийсэн болж, хөрөнгө оруулагч, төсөл хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хүндрүүлэх, хүнд суртал гаргах нь энгийн үзэгдэл болж, зам тээврийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн болон зохион байгуулалтын боломж алдагдаж зөвхөн улсын төсөв, гаднын зээлийн санхүүжилт хүлээсэн салбар болгосныг мэргэжилтнүүд шүүмжилж байна.

2. Монгол Улсын дэд бүтцийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах бизнесийн орчны зохицуулалт хангалтгүй байна. Жишээлбэл, Монгол Улсад тарифын тухай хууль байхгүй, хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, шийдвэр гаргахад үндэслэх мэргэжлийн дүгнэлтийн нэгдсэн зохицуулалт байхгүй нь хөрөнгө оруулагч урт хугацаанд эдийн засгийн тооцоолол хийх, түүнийгээ хамгаалах боломжгүй болгож байна. Концессын гэрээ байгуулах эрх зүйн орчин байгаа ч түүнийг хэрэгжүүлэх байгууллага, шийдвэр гаргагчийн мэдлэг, чадвар дутмаг зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, зохицуулах нэгдсэн бодлогын орчин нь өөрөө эрсдэл дагуулж байна.

3. Гаднын урт хугацаатай зээлээр хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн үр ашиг өндөртэй дэд бүтцийн зарим төсөл төрийн байгууллага, түүний ажил хариуцсан хүмүүсээс шалтгаалж олон сая долларын зээлийг буцаан татуулсан асуудал хүртэл гарчээ. Тодруулбал, Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулахад бодит нөлөө үзүүлэх “Нийслэлийн нийтийн тээврийн хөрөнгө оруулалтын төсөл (BRT)” 2015 онд зээлийн гэрээ хийж, улмаар 2017 онд төслийн нэгжээ байгуулан ажиллаж эхэлсэн ч төрийн эрх бүхий байгууллагууд, албан тушаалтнуудын хариуцлагагүй байдлын улмаас гацаж Сангийн яам 2020 оны 2 дугаар сард зогсоосон байна.

4. “Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл”-ийг Япон Улсын Засгийн газраас ойролцоогоор 300 сая ам.доллартой тэнцэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж, барилга бүтээн байгуулалтын ажил хэдэн жилийн өмнө дууссан ч өнөөдрийг хүртэл ашиглалтад оруулж чадахгүй хойшлуулсаар байна.

5. Азийн авто замын сүлжээний гол магистрал болох Эй Эйч 3 (АН3) буюу Алтанбулаг-УБ-Замын-Үүд чиглэлийн хурдны авто замын асуудал олон жил гацаж байна. Улаанбаатар – Дархан чиглэлийн хоёр эгнээ авто замын өргөтгөл, шинэчлэлтийн барилгын ажлыг 2019 оны 6 дугаар сард эхлүүлж, 2020 оны хавар ашиглалтад оруулахаар төлөвлөж, хэвийн зорчиж байсан хуучин замын хучилтыг бүхэлд нь хуулж сүржигнэсэн боловч өнөөдрийг хүртэл дуусаагүй, зарим гүйцэтгэгч компани гэрээгээ цуцалсан, авто замаар зорчигчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд халтай, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн, гамшиг дагуулсан төсөл болж хувираад байна.

Иймд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал үүрэгтэй зам, тээврийн салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж, эрх үүргийн давхцлыг арилгаж, авилга, албан тушаал, ашиг сонирхлын зөрчлөөс ангижруулж, улсын төсөвт учруулах

дарамтыг бууруулах зөв зүйтэй бодлого, мэргэжлийн зохион байгуулалт хэрэгтэй байгааг анхааруулж, УИХ дахь Ардчилсан намын бүлгээс доорх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Дэд бүтцийн мега төслүүдийг хэрэгжүүлэх боловсрол, туршлагатай мэргэжлийн баг бүрдүүлж, Үндэсний хөгжлийн газар болон салбар яамдын уялдааг ханган, нэгдсэн бодлогоор чиглүүлж, сонгон шалгаруулах – гэрээ байгуулах – эхлүүлэх – хэрэгжүүлэх хугацааг хамгийн үр дүнтэй байхаар төлөвлөж ажиллах,

Хоёр. Хөрөнгө оруулалтын орчин дахь хүнд суртал, авилгын асуудалд онцгой анхаарч, дарга нарын зүгээс хөрөнгө оруулагчдад учруулдаг ашиг сонирхлын саад бэрхшээлийг арилгах,

Гурав. Зам, тээврийн салбараас төсөвт учруулж буй дарамтыг бууруулж, төрөөс төсөв мөнгө шаардахгүй хөрөнгө оруулалтын арга хэлбэрийг ашиглах, ялангуяа “барих – ашиглах – шилжүүлэх” (BOT), “зураг төсөл боловсруулах – барих – ашиглах – шилжүүлэх” (DBOT) зэрэг төрийн хувийн хэвшлийн түншлэлийн үр ашигтай хэлбэрүүдийг түлхүү ашиглах,

Дөрөв. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах чиглэлд бодит алхам хийж, хот төлөвлөлтийн бодлоготой зам, тээврийн төлөвлөлтийг нягт уялдуулан тусгай замын автобус зэрэг үр ашигтай төслийг хэрэгжүүлж, аюулгүй, тав тухтай нийтийн тээврийн үйлчилгээний бодлого руу шилжих,

Тав. Зам, тээврийн салбарт хэрэгжиж буй Улаанбаатар хот орчмын төслүүдийн уялдаа холбоог хангах, Богд хан уулыг тойрсон хурдны авто зам, шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн төмөр замын төслүүдэд хувийн хөрөнгө оруулалтыг татах замаар төсөвт дарамт учруулахгүйгээр хэрэгжүүлэх,

Зургаа. Авто замын төслийг хэрэгжүүлэхдээ дан замын шугаман байгууламжаас илүүтэйгээр түр зогсох цэг, амралт үйлчилгээний цогцолбор зэргийг стандартад нийцүүлэн цогцоор нь төлөвлөж, хамтад нь барьж байгуулах замаар зорчигчид, жолооч, тээвэрчдийн ая тухыг хангах чиглэлд төрийн бодлогыг чиглүүлэх зэрэг зөвлөмжийг хүргүүлж байна.

Цаашид УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг танилцуулахдаа тоон мэдээлэл, салбарын яамны ажлын тайлан танилцуулахаас илүүтэй салбарын хөгжлийн хандлага, төрийн бодлого, түүний хэрэгжилт, эрх зүйн орчны шинжилгээ, хэрэгжилтэд гарч буй саад бэрхшээл зэргийг мэргэжлийн түвшинд бэлтгэн танилцуулж байхыг зөвлөж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН
НАМЫН БҮЛЭГ

УИХ-ын гишүүний тавьсан асуулга, асуулт

Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын үйл ажиллагаанд асуулга, асуулт тавих байдлаар хуулийн хүрээнд хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлдэг.

Асуулга гэдэг нь Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж УИХ-ын гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад бичгээр хандсан асуудлыг ойлгоно. Асуулга хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр өгөх үүрэгтэй.



Асуулт гэдэг нь үйл ажиллагаатай нь холбогдох тодорхой асуудлаар мэдээлэл авах зорилгоор гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад бичгээр хандсаныг ойлгоно. Асуултыг хүлээн авсан албан тушаалтан 14 хоногийн дотор гишүүнд бичгээр хариу өгөх үүрэгтэй.

2020 оны Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы хугацаанд УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гурван гишүүн нийт долоон удаа асуулга, нэг гишүүн асуулт тавьж хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ЕРӨНХИЙ САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УЛСЫН ИХ ХУРАЛД АЖЛАА ШУУД ХАРИУЦАН ТАЙЛАГНАДАГ БАЙГУУЛЛАГЫН
ДАРГАД ТАВЬСАН АСУУЛГА, АСУУЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ

№	Улсын Их Хурлын гишүүний нэр	Хэнд, ямар байгууллагад хандаж тавьсан	Асуулгын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Албан бичгийн огноо	Тайлбар		
					Хүргэсэн	Ирүүлсэн	Асуулгын хариуг сонсох гишүүний санал	Асуулгын хариу ирүүлсэн эсэх
	2020-2024 ОНЫ ОНЫ ШИНЭЭР СОНГОГДСОН ПАРЛАМЕНТЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ТАВЬСАН АСУУЛГЫН ТАЛААРХ МЭДЭЭ							
1	Д.Бат-Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд	Өмнөговь аймагт хууль зөрчин уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй зарим аж ахуйн нэгжийн талаар	3	2020.08.18 №05	2020.09.17 ХЭГ/2191	2020.09.28 УИХЕ03/3877	Хүлээгдэж байна
2	Д.Бат-Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд	Монгол Улсын хэмжээнд усны харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, тэдгээрийн уялдаа холбооны талаар	5	2020.08.24 №09	2020.09.24 ХЭГ/2252	2020.09.28 УИХЕ03/3877	Хүлээгдэж байна
3	Д.Бат-Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд	Өмнөговь аймагт хэрэгжихээр төлөвлөгдөөд байгаа “Тавантолгой-Баруунаран чиглэлийн замын төгсгөлөөс Цагаандэл уул-Өлзийн боомт хүртэлх авто зам” төсөл, “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам” төсөл, “Тавантолгой-Шивээговь хүртэлх нүүрс тээврийн замын төсөл”-үүд нь хууль, эрх зүйн хүрээнээс давсан үйл ажиллагаа явуулж буй эсэх талаар	4	2020.08.28 №10	2020.09.30 ХЭГ/2296	2020.09.28 УИХЕ03/3877	Хүлээгдэж байна
4	Б.Пүрэвдорж	Монгол Улсын Ерөнхий сайд	Мөнгөний бодлого, валютын ханш болон төсвийн алдагдлын талаар	6	2020.09.09 №20	2020.10.14 ХЭГ/2413	2020.10.19 УИХ- 03/4445	Хүлээгдэж байна
5	О.Цогтгэрэл	Монгол Улсын Ерөнхий сайд	Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлж, гадаад худалдаа, экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг өсгөхөд бизнес эрхлэгч, Аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, иргэдийн орлого, ажлын байрыг өсгөхөд нөлөөлөх гадаад худалдааны талаар	5	2020.10.19 №25	2020.11.20 ХЭГ/2795	2020.12.18 УИХ-03/6666	Хүлээгдэж байна
6	О.Цогтгэрэл	ХНХСайд А.Ариунзаяа	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар	10	2020.11.27 №27			Хариу ирүүлэх хугацаа болоогүй
7	Б.Пүрэвдорж	Монгол Улсын Ерөнхий сайд	“Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх” талаар	6	2020.12.07 №29			Хариу ирүүлэх хугацаа болоогүй
	2020-2024 ОНЫ ОНЫ ШИНЭЭР СОНГОГДСОН ПАРЛАМЕНТЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ТАВЬСАН АСУУЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ							
1	Ц.Туваан	Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан	Коронавируст халдвар /КОВИД-19/ үед хандивлагч орнуудын илгээж буй хандив, тусламж хэрхэн үр ашигтай зарцуулагдаж байгаа талаар	3	2020.11.27 №28	2020.12.15 1а/5314		Хариу ирүүлсэн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020. 11. 27 № 27

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
А.АРИУНЗАЯА ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд Танд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар дараах хүрээнд асуулга тавьж байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлд хийгдсэн болон хийхээр төлөвлөгдөж буй ажлуудын талаар;
2. Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсч буй нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай зохицуулалтуудын талаар;
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих чиглэлээр хийгдсэн болон цаашид хийхээр төлөвлөж буй ажлуудын талаар;
4. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн төлөв байдал, цаашид баримтлах бодлогын талаар;
5. Ажил хайгч, ажилтан, ажил олгогчид тус бүрийн нийтлэг зан төлөв, түүнд гарч буй өөрчлөлт, чиг хандлагын талаар;
6. Ажилд ороход хүндрэлтэй иргэд, малчид, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон нөхөрлөл, хоршоодыг дэмжих чиглэлээр хийгдсэн болон цаашид хийхээр төлөвлөгдөж буй ажлуудын талаар;
7. Ажил олгогчдыг дэмжих чиглэлээр хийгдсэн болон цаашид хийхээр төлөвлөгдсөн ажлуудын талаар;
8. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, сүлжээний үйл ажиллагааны өнөөгийн байдал, үр дүн, цаашид хөгжүүлэх төлөвлөгөө, сайжруулах шаардлагатай зохицуулалтын талаар;
9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа, өнгөрсөн хугацаанд хүрсэн үр дүн, цаашдын төлөвлөгөөний талаар;
10. Үйл ажиллагаа явуулж буй хөдөлмөрийн биржүүдийн мэдээлэл, өнгөрсөн хугацааны ажлын үр дүнгийн талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛ

2020000082

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020.08.28 № 10

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Асуулга тавих тухай

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгойн бүлэг ордоос өнөөдрийн байдлаар олон улсын зах зээлд гаргах нүүрс тээвэрлэх зориулалтаар хэрэгжиж буй төмөр замын болон авто замын 4 төсөл, хэрэгжихээр төлөвлөгдөөд буй авто замын 3 төсөл байна. Дээрх төслүүд нь Өмнөговь аймгийн нийт газар нутгийн 50 орчим хувийг хамарч, тухайн нутагт ажиллаж, амьдарч буй малчид, иргэдийн аж амьдрал, байгаль орчны тэнцвэртэй байдал алдагдахад хүргэж, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгч тал, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд, малчид, иргэдийн дунд зөрчил үүсч даамжирсаар байгаа юм.

Монгол улсын нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхүйц төсөл, хөтөлбөрүүдийг Өмнөговь аймаг, тухайн бүс нутгийн малчид, иргэд тухай бүрт нь дэмжиж ирсэн ч сүүлийн жилүүдэд хэрэгжихээр төлөвлөгдөөд байгаа “Тавантолгой-Барууннаран чиглэлийн замын төгсгөлөөс Цагаандэл уул-Өлзий боомт хүртэлх авто зам” төсөл болон “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам” төсөл, “Тавантолгой-Шивээговь хүртэлх нүүрс тээврийн замын төсөл”-үүд нь хууль, эрх зүйн хүрээнээс давсан үйл ажиллагаа явуулж, тухайн бүс нутгийн иргэдийн оролцоо, саналыг үл харгалзсан үйлдэл нь иргэдийг төрийн бодлого, шийдвэрт эргэлзэх, зөрчилдөх асуудлууд гарах үндэс суурь нь болоод байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд асуулга тавьж байна.

1. “Тавантолгой-Барууннаран чиглэлийн замын төгсгөлөөс Цагаандэл уул-Өлзий боомт хүртэлх авто зам” төсөл болон “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам” төсөл нь Авто замын тухай хуулийн 18, 19, 20, 21 дүгээр зүйлүүдэд заасан шаардлага, “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 4 дүгээр хавсралтын А-д заасан шаардлага, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7, 8, 18 дугаар зүйлүүдэд заасан шаардлага, Концессын тухай хуулийн 11-19 дүгээр зүйлүүдэд заасан шаардлага, “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах

2020000055

тухай журам”-д заасан шаардлагуудыг тус тус хангаж байгаа эсэх, энэ талаар холбогдох төрийн байгууллагуудын санал, дүгнэлт гарсан эсэх талаар; /дээрх бичиг баримтуудыг асуулгын хариуд хавсаргаж ирүүлэх/

2. “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам төсөл” нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтын дагуу байгаль орчны үнэлгээнүүдэд тухайн замын трасс дагуух нөлөөллийн сумд, багуудын иргэдийн саналыг тусгаагүй байх тул холбогдох яамд, аймаг, сумдын дарга нарт чиглэл өгч иргэдийн саналыг тусгуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлж, улмаар уг авсан арга хэмжээний талаарх мэдээллийг ирүүлэх;

3. “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам” төсөл нь холбогдох бичиг баримт дутуу байж замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэн эрүүл газар хөндөж, хөрс хуулснаар их хэмжээний газар эвдэрч сүйдсэн, мөн түр хөрсийг нь хуулсан сайжруулаагүй хэсгээр одоог хүртэл нүүрс тээвэрлэн эрүүл газар эвдэж, олон салаа зам гарган бэлчээр, газар нутгийг доройтуулж, цөлжилт ихээр явагдахад нөлөөлж байгаа талаар тухайн нутгийн малчид, иргэдээс гомдол, мэдээлэл ирэх нь нэмэгдэж байна. Иймд хууль бусаар замын байгууламжийн барилгын ажил эхлүүлж, Тавантолгой-Ханги-Мандалын боомт чиглэлд шороогоор нүүрс тээвэрлэж байгаад хяналт тавьж байгаа төрийн байгууллага байгаа эсэх, аль шатны төрийн байгууллагын ямар шийдвэрээр дээрх төслийг эхлүүлсэн талаарх мэдээлэл;

4. Өмнөговь аймагт уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Терра энержи” ХХК-ийн авто зам өнөөдрийг хүртэл тавигдахгүй шороон замаар нүүрс тээвэрлэж байгаа зөрчлийг хэзээ арилгуулах талаар хариу ирүүлнэ үү.

Асуулгын заалт тус бүрт хариу тайлбарыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, улмаар хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.БАТ-ЭРДЭНЭ

2020000055

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020.08.24 № 09

Асуулга тавих тухай

Дэлхийн дулаарал, хүн амын өсөлт, байгаль, цаг уурын өөрчлөлт, техник технологийн хөгжил зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан дэлхийн цэвэр усны нөөц минут, секундээр хомсдож, зарим улс орон цэвэр усны нөөцгүй болж байгааг холбогдох олон улсын байгууллага, судлаачид анхааруулсаар байна.

Манай улсын хувьд ч сүүлийн жилүүдэд цэвэр усны зохисгүй хэрэглээ, байгаль, цаг уурын өөрчлөлт болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан усны нөөц эрс багасч байгаа талаар мэргэжлийн байгууллагууд мэдээлэх болсон. Тэр дундаа говийн бүс нутагт газрын гадаргын болон гүний цэвэр усыг зохисгүй ашиглах, уул уурхайн олборлолт дагасан томоохон дэд бүтэц, хот суурин газрууд усыг үнэ төлбөргүйгээр ашиглах, үйлдвэрлэл, үйлчилгээнд маш хямд өртөгөөр их хэмжээний гүний ус ашиглаж байгаа нь экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах, цөлжилтийг ихээр нэмэгдүүлэх, цэвэр усны хомсдолд орох, гол горхи, булаг шанд ширгэх, говийн бүсэд цөлжилт, хуурайшилт эрчимтэй явагдах гол үндэс суурь нь болоод байна.

Цаашид усыг зохистой ашиглах, дахин ашиглах, гадагш урсгалтай томоохон гол мөрөнд урсацын тохируулга хийх, хиймэл усан сангийн хуримтлал үүсгэх, томоохон хот суурин газруудын саарал усыг хөдөө аж ахуйн болон уул уурхайн олборлолт, үйлчилгээнд ашигладаг болох чухал шаардлага үүссэн байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасанг үндэслэн Монгол улсын Ерөнхий сайд Танд асуулга тавьж байна.

1. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд усны харилцааг зохицуулах Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Ус” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”, УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”, 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсаар байх боловч эдгээрт тусгагдсан усыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зорилго,

2020000044

зорилтууд хангалтгүй хэрэгжсээр өнөөдрийг хүрлээ гэж иргэд дүгнэж байна. Дээрх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд та бүхэн хэрхэн хяналт тавьж байгаа, ямар хугацаагаар үнэлэлт, дүгнэлт өгдөг, үр дүнг хэрхэн хэлэлцэж, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч байгаа болон дээрх баримт бичгүүдээс хэрэгжих хугацаа нь дууссан баримт бичгүүдийн үр дүнгийн талаар;

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6 дугаар бүлгийн 6.3.2-д “Усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамаарсан шатлан өгсөх зарчимд суурилан тогтоох, төлбөрийн орлогыг дахин хуваарилах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж 1 дүгээр үе шатанд хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Гэтэл энэхүү зорилт хэрэгжихэд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиуд нийцэхгүй байна. Холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар;

3. Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд усны төлбөр Монгол Улсын 29 ай сав газар тус бүрт 1 шоо метр усны үнийг тооцох аргачлал нь Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ”, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ”, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “ашиглалтын зориулалт тооцох итгэлцүүр”-ээр өөр өөр байгаа нь өнөөгийн нийгэм эдийн засгийн байдал, усны нөөц, эх үүсвэртэй нь уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна. Ус ашигласны төлбөрийн хэмжээг тогтоохдоо ямар үндэслэлээр тогтоосон, ямар судалгаа, шинжилгээний ажил хийсэн талаар;

4. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ”-г баталсан Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын үндэслэл болох Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт нь 2004-2012 оны үед мөрдөгдөж байсан хүчингүй болсон Усны тухай хуулийн заалттай байна. Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолыг Усны тухай хуулийн /2012 онд шинэчлэн найруулсан/ 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын дагуу шинэчлэхэд хэрэгжүүлж байгаа ажлын талаар;

5. Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар усны нөөц ашигласны төлбөрөөс хөнгөлөх хувь хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн төлбөрөөс хөнгөлөх заалтыг барьж 100 хувь усны төлбөрөөс хөнгөлөх тогтоол гаргасан нь усны төлбөрөөс чөлөөлөх боломжгүй этгээдийг чөлөөлөх хуулийн цоорхой болсон. Иймд тогтоолд өөрчлөлт оруулж, зөвхөн тодорхой хувийг нь хөнгөлж, үлдсэн хувь дээрх төлбөрийг төсөвт төвлөрүүлдэг болгох.

Асуулгын заалт тус бүрт хариу тайлбарыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, улмаар хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.БАТ-ЭРДЭНЭ

2020000044

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020.08.18 № 05

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Асуулга тавих тухай

Сүүлийн жилүүдэд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрчимтэй хөгжсөнөөр Өмнөговь аймаг улсын төсвөөс татаас авдаггүй, бусад аймгуудтай харьцуулахад илүү өндөр хэмжээний татварын орлогыг улсын төсөвт төвлөрүүлдэг стратегийн ач холбогдол бүхий аймаг болсон. Гэвч тус аймагт хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол, усны хомсдол нэмэгдэж, үр дүнд нь иргэд, малчид хохирч, байгаль орчин сүйдсээр өнөөдрийг хүрлээ.

Өвөлжөө, хаваржаа, зуслангийн газар нь уурхайн эдэлбэрийн орчинд орсон иргэд шүүхийн шийдвэрээр газар өмчлөх, эзэмших эрхээ уул уурхайн үйл ажиллагаанд алдаж, нутаглах нутаггүй, малаа бэлчээх бэлчээргүй болж, иргэд болон уул уурхайн компани хоорондын зөрчил маргаан даамжирсаар байна.

Тухайлбал, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гоёот багийн нутаг дэвсгэрт алт олборлох MV-000114917, MV-00020529, MV-000117452 тоот тусгай зөвшөөрлийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа “АГМ майнинг” ХХК нь 2018, 2019 онуудад Ашигт малтмалын тухай болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудыг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий байгууллагуудын хяналт шалгалтын дүнгээр тогтоогдсон байна. Улмаар тус компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай саналыг холбогдох төрийн байгууллагад хүргүүлсэн боловч хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ өнөөдрийг хүртэл аваагүй байгаа талаар орон нутгийн удирдлага болон иргэд байнга гомдол гаргаж байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие дээр дурдагдсан асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

2020000041

1. Өмнөговь аймгийн Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж байгаа “АГМ майнинг” ХХК-ийн үйл ажиллагаа Ашигт малтмалын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн нь холбогдох төрийн байгууллагуудын шалгалтаар тогтоогдсон. Түүнчлэн Өмнөговь аймгийн Засаг даргын 2019 оны А/1277 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тус компанийг биологийн нөхөн сэргээлт хийгээгүй, шимт хөрсний овоолго үүсгээгүй, газар, газрын хэвлийн эвдрэлийн хэмжээ талбайг тогтоох, нөхөн сэргээлт, гадаргуугийн шинжилгээнд хяналт тавих ажил хийгээгүй, Багийн Иргэдийн Нийтийн Хуралд байгаль орчны ажлын гүйцэтгэлийг нэг ч удаа тайлагнаж байгаагүй гэсэн дүгнэлт гаргаж, түүнийг нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас томилогдсон ажлын хэсэг баталгаажуулсан байхад тус компанийн үйл ажиллагаа яагаад одоо хүртэл хэвийн үргэлжилсээр байна вэ? Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар;

2. 2016-2020 онуудад Өмнөговь аймагт хууль зөрчин үйл ажиллагаа явуулсан хэдэн уул уурхайн компанийн тусгай зөвшөөрлийг цуцалсан, тэдгээр компаниудад ямар хариуцлага тооцсон талаар мэдээлэл ирүүлнэ үү. Тухайлбал, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2019 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 384 дүгээр шийдвэрээр Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж байсан MV-017038, MV019036 тоот тусгай зөвшөөрөл, 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн тушаалаар 8 аж ахуйн нэгжийн 10 тусгай зөвшөөрлийг цуцалсан. Тэдгээр талбайг чөлөөлж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, орон нутагт хүлээлгэн өгөх ажил ямар түвшинд явж байгаа талаар;

3. Өнөөдрийн байдлаар Өмнөговь аймагт уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэг ямар аж ахуйн нэжгүүд байгаа талаар болон тэдгээрээс хэд нь хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдээлэл ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.БАТ-ЭРДЭНЭ

2020000041

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020. 11. 27 № 28

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Т.МӨНХСАЙХАН ТАНАА

Асуулт тавих тухай

Дэлхий дахинд хурдацтай тархаж байгаа Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал манай улсад тархаад нөхцөл байдал хүнд байна. Цар тахлын улмаас эдийн засаг хүнд хэцүү байгаа хэдий ч дэлхийн улс орнууд Монгол Улсад тусламжийн гараа сунган хандив өгсөөр байгаа билээ.

Монгол Улсын Их Хурлын түр хорооны 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг хэлэлцэх, хяналт тавих, санал, дүгнэлт гаргах талаарх асуудлыг хэлэлцсэн. Тус түр хорооны хуралдаанаар “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын зарим гишүүдээс “халдвар авсан нэг өвчтөнг эдгээхэд зориулан зарцуулж буй мөнгөн дүнгийн талаар” асуусан асуултад Эрүүл мэндийн сайд Та нэг өвчтөнд найм орчим сая төгрөг зарцуулж байгаа тухай чуулганы танхимд мэдээлсэн.

Улсын төсөв, эдийн засаг хүнд байгаа энэ цаг үед, түүнчлэн хандивлагч орнуудын илгээж буй хандив, тусламж хэрхэн үр ашигтай зарцуулагдаж байгаатай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т тус тус заасныг үндэслэн Эрүүл мэндийн сайд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсад Коронавируст халдвар /КОВИД-19/ авсан нэг өвчтөнд зарцуулж байгаа найман сая төгрөгийн задаргааг дэлгэрэнгүй байдлаар ирүүлэх;

2. Өвчтөнд зарцуулж байгаа найман сая төгрөг нь тухайн өвчтөний хүнд, хөнгөн өвдсөн эсэхээс хамааралтай байгаа эсэх;

3. Халдвар авсан өвчтөний ойрын хавьтал болон тусгаарлагдаж байгаа иргэдийг эмчлүүлэгсдийн тоонд хамруулж байгаа эсэх талаарх мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар бэлтгэн ирүүлнэ үү.

2020000053

Асуултын заалт тус бүрээр хариу тайлбарыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8-д заасан хугацаанд бэлтгэн ирүүлж, улмаар холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ц.ТУВААН

2020000053

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020 09 09 № 20

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Асуулга тавих тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино." гэж заасан. Энэ нь Монголбанк үндсэн зорилтынхоо хүрээнд дотоодын санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлж ажиллах тухай зохицуулалт юм. Дэлхийн улс орнуудад Төв банк нь үнийн тогтвортой байдал буюу инфляцаа анхаарч, харин валютын ханшийн бодлогыг Төв банк нь Засгийн газартайгаа хамтран тодорхойлдог практик бий.

Манай улсын үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн ханш 2016 оны 06 дугаар сараас хойш 43.7 хувиар суларчээ. Монгол улсын нийт импортын 70 хувийг ам.доллар-аар хийдэг ба хэрэглээний сагсны 43.7 хувь нь импортын бараа байдаг. Тиймээс ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн чангаралтаас шалтгаалж импортын барааны болон өргөн хэрэглээний барааны үнэ өсч, энэ нь иргэдийн амьдралд шууд нөлөөлдөг. Монголбанкны 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн мэдээгээр ам.долларын төгрөгтэй харьцах хаалтын ханш 1,982.25 төгрөг байсан бол 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр 2,850.19 төгрөгт хүрч, даруй 867.94 төгрөгөөр өсөөд байна.

Энэ нь 2016 оноос хойш төгрөг 43.7 хувиар үнэгүйдсэн үзүүлэлт бөгөөд ам. долларын ханшны чангаралт гадаадын байгууллагуудтай хамтардаг Монголын бизнес эрхлэгчид, мөн ам.долларын зээлтэй зээлдэгчдийн хувьд асар хүнд дарамт болж байна. Хэдийгээр Монголбанк гадаад валютын нөөцөөсөө их хэмжээний ам.доллараар интервенц хийсээр ирсэн боловч төгрөгийн ханш улам бүр суларсаар байна. Ам.долларын ханш нэмэгдэх бүрт суурь үнээ хөөрөгдсөнөөр бага, дунд орлоготой иргэд, тэдний дотор тэтгэврийн орлоготой ахмадуудын амьдрал туйлын хүнд байдалд ороод байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-т тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Үндэсний статистикийн хорооноос гаргаж буй мэдээллээр М2 мөнгөний нийлүүлэлт 2012 оны 6 дугаар сард 7 их наяд 48 тэрбум төгрөг байсан бол 2016 оны 6 дугаар сард 11 их наяд 186 тэрбум төгрөгт, 2020 оны 7 дугаар сард 21 их наяд 356 тэрбум төгрөгт хүрч сүүлийн дөрвөн жилийн хугацаанд даруй 10 их наяд төгрөгөөр өсчээ. М2 мөнгөний хэмжээ ийнхүү асар ихээр нэмэгдсэн нь валютын ханшид хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийсэн бол танилцуулна уу?

2020000062

2. Монгол Улсын нийт өр 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр 24 тэрбум 260 сая ам.доллар байсан бол 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 30 тэрбум 461 сая ам.долларт хүрч дөрөвхөн жилийн хугацаанд 6 тэрбум 201 сая ам.доллар буюу бараг 18.0 их наяд төгрөгөөр өссөн байна. Харин Засгийн газрын нийт өр 2016 оны 2 дугаар улиралд 4,785.8 сая ам.доллар байсан бол 2020 оны эхний улиралд 7,235.4 сая ам.долларт хүрч даруй 2,449.6 сая ам.долларaар нэмэгдлээ. Монгол Улсын болон Засгийн газрын өрийн хэмжээ ийнхүү асар ихээр нэмэгдсэн нь валютын ханшид хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийсэн бол танилцуулна уу?

3. Төсвийн алдагдал 4 жил дараалан 2 их наяд төгрөгөөс давсан. Гэтэл шинээр өргөн мэдүүлсэн төсвийн тодотголд Нэгдсэн төсвийн тэнцлийг бас дахин 2 их наяд 771 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ. Төсвийн алдагдал бол өр юм. Ийнхүү Та бүхэн засаглаж байх хугацаанд нийтдээ 12 их наяд төгрөг давсан төсвийн алдагдал гаргасан байна. Түүхэн дээд амжилт тогтоож байгаа ийм хэмжээний архагшсан алдагдал бол зөвхөн дайны хөлд нэрвэгдсэн улс орнуудын төсөвт байдаг үзэгдэл юм. Ийм их алдагдал үндэсний мөнгөн тэмдэгтийн ам.доллартай харьцах ханшид хэрхэн нөлөөлж байгаа талаар тооцоо судалгаа хийсэн бол танилцуулна уу?

4. Эдийн засгийн хямрал нүүрэлсэн 2015 онд экспортод 4 тэрбум 669.3 сая ам.долларын бараа, түүхий эд гаргаж байсан бол 2019 онд 7 тэрбум 619.7 сая ам.долларт хүрч 3 тэрбум ам.доллар-аар өссөн байна. Ийнхүү эрдэс баялгийн бүтээгдэхүүний борлуулалтаас орж ирэх валют асар их хэмжээгээр нэмэгдэж байхад ам.долларын ханш ямар шалтгаанаар буурахгүй байгааг тайлбарлана уу? Монгол улс гадаад худалдаанаас орж ирэх валютаа хянаж чадаж байна уу?


5. Ханшийг тогтоох зорилгоор Монголбанкнаас хийсэн валютын интервенцийн дүнг 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд сар бүрээр тооцон гаргаж ирүүлнэ үү.

6. Монголбанкны цэвэршүүлсэн алтны мэдээг 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд сар бүрээр ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б. ПҮРЭВДОРЖ

2020000062

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020. 12. 07 № 29

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар шинэ коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед хүндэрч байгаа эдийн засгаа дэмжих зорилгоор 5.1 их наяд төгрөгийн санхүүжилттэй хөтөлбөр хэрэгжүүлэхээр зарласан. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д заасан “Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх” тухай заалтын хэрэгжилттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Танд асуулга тавьж байна. Үүнд:

1. Монгол улсад 2018 оны байдлаар бүртгэлтэй 170,166 аж ахуй нэгж бий. Үүнээс 85,749 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 68 хувь буюу 58,602 нь жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамаарч, нийт 1,256,356 ажиллах хүчний 77 хувь буюу 963,146 мянган хүн ажиллаж байна. Засгийн газрын хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад хамгийн их ажлын байрыг бий болгож, эдийн засгийг нуруундаа үүрч явдаг жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж, хичнээн ажлын байрыг хадгалж чадсан бэ?

2. 2020 оны төсвийг тодотгох асуудлыг хөндөн тавихад “Төсвөө тодотгож, хөрөнгө оруулалтын зардлаа тана гэж байгаа нь 1,500 аж ахуйн нэгж, 150,000 ажлын байраа хаа гэж байгаатай адил сонсогдож байна” гэж Сангийн сайд хариулж байсан. Тэгвэл үсчин, машин засвар, машин угаалга, томоохон зах болон үйлчилгээний төвүүдэд гар дээрээс худалдаа хийдэг иргэд, оёдолчид гэх зэрэг өдрийн орлогоороо өрхийн амьдралаа, өнөө маргаашийн хоолоо залгуулж буй 180 мянган иргэдээ дэмжихэд хэдэн төгрөг зарцуулсан бэ?

3. Монгол улсад нийт 897,427 өрх байна. Үүнээс хүүхэдтэй 531,000, хүүхэдгүй 366,427 өрх байдаг. Хүүхэдгүй өрхүүд цар тахлаас сэргийлэх Засгийн газраас

2020000092

авч хэрэгжүүлсэн хөтөлбөрт хэрхэн хамрагдсан талаар тодорхой мэдээлэл өгнө үү;

4. Монгол Улс зээлийн хүүгийн түвшнээр дэлхийд дээрээсээ 10 дугаар байрт жагсдаг. Арилжааны банкны зээлийн дундаж хүү 17%, хадгаламж зээлийн хоршооны зээлийн дундаж хүү 34.8%, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн дундаж хүү 37.2%, ломбардны зээлийн дундаж хүү 42% байна. 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаас 23 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Ерөнхий сайд ч хэвлэлийн хурал дээр Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нартай тохиролцсон учраас 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл иргэдийн бүх зээл хойшлогдсон талаар мэдээлэл хийсэн. Гэвч Монголбанкны удирдлага, арилжааны банкууд, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагууд энэ шийдвэрийг янз бүрээр тайлбарлан хэрэгжүүлж байна. Засгийн газрын хуралдааны шийдвэр хүчин төгөлдөр байгаа эсэх талаар мэдээлэл өгнө үү?

5. Монгол улсын Ерөнхийлөгчийн төрөөс өрх бүрд нэг сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх санаачилгыг Засгийн газар дэмжээгүй. Ерөнхий сайд “Бүх зүйлийг Засгийн газар нь шийдэж чадахгүй. Тийм боломж бидэнд байхгүй” гэж тайлбарласан. Хэдхэн сарын өмнө Улсын Их Хурлын сонгуулийн өмнө нэг кг ямааны ноолуурт 20 мянган төгрөгөөр тооцож 178 тэрбум төгрөгийг бэлнээр тараасан Засгийн газар нийтээр хөл хорио тогтоосон эдгээр өдрүүдэд иргэддээ 180 тэрбум олгох боломжгүй гэсэн шалтгаанаа тайлбарлана уу.

6. Монгол Улсын төсвийн орлогын тал хувьд хүрэхүйц буюу 1.7 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний татвар төлөгчдийн асар их хэмжээний хөрөнгө зарцуулсан хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнгийн талаарх тодорхой тайлан гаргаж ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Б. ПҮРЭВДОРЖ

2020000092

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020.10.19 № 25

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол улсын хөгжилд нөлөөлөгч олон хүчин зүйлсийн дотроос гадаад худалдаа, түүний бодлого, зохицуулалт, томоохон байр суурийг эзэлж ирсэн. Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлж, экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг өсгөхөд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдээ бодлогоор дэмжиж, иргэдийн орлого, ажлын байрыг өсгөхөд гадаад худалдааны үүрэг оршино.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус салбарын экспортыг бодитой дэмжих, цаашлаад экспорт, импортын нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд хэрэгжүүлж буй “Монгол экспорт” болон “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын талаар;
2. Гадаад худалдааг дэмжих, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлууд ба цаашид хийгдэхээр төлөвлөж буй ажлуудын талаар;
3. Гадаад худалдааны бодлогын үр дүнг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох урсгал тэнцлийн алдагдал, экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс болон гадаад худалдааны бодлогын хэрэгслийг тодорхойлогч худалдааны гэрээ, хэлэлцээрийн ач холбогдол, хамгаалалтын хэмжүүр зэрэг үзүүлэлтүүд сүүлийн 10 жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн талаар;
4. Япон улстай байгуулсан Чөлөөт худалдааны хэлэлцээр, мөн Европын холбооны Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий системийн үр дүн, үнэлгээ, цаашид анхаарах асуудлуудын талаар;
5. Шинээр байгуулахаар судалж буй болон санал солилцсон Хөнгөлөлтийн ерөнхий систем, Чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийн явц байдал болон баримтлах бодлогын талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛ

2020000071

УИХ-ын 2020 оны намрын чуулганаар хэлэлцсэн гол хуулиудын танилцуулга

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгална. УИХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр нь чуулган юм. Чуулганы нэгдсэн хуралдаан нь долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт, байнгын хороодын хуралдаан Мягмар, Лхагва гарагт явагддаг. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг УИХ-аар хэлэлцэхдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг дагаж мөрддөг бөгөөд хуулийн төслийг 4 үе шаттайгаар хэлэлцдэг.

ХУУЛИЙН ТӨСЛИЙГ 4 ҮЕ ШАТТАЙ ХЭЛЭЛЦЭНЭ
/МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйл/

ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ /ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ХОРООНД ХЭЛЭЛЦЭНЭ

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэж, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах үед гишүүд хууль санаачлагчаас хуулийн төслийн үзэл баримтлалын талаар асуулт асууж, үг хэлж болно.

НЭГДСЭН ХУРАЛДААНААР ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛНА

Гишүүд үг хэлэхий дараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Асуулт асуух **хугацаа 4 минутаас** илүүгүй, нэмэлт хугацаа 1 минут бөгөөд хариулт, тайлбар хангалттай бол 1 минут нэмэлт асуулт асуух, тайлбар авч болно. Асуулт, хариулт дууссаны дараа хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэхээ урьдчилан мэдэгдэж, дараалалд орсон гишүүн **5 минутаас** илүүгүй хугацаагаар үг хэлнэ

ХОЛБОГДОХ БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГЫН ХОРООГООР ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛНА

НЭГДСЭН ХУРАЛДААНААР ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛНА

гэрлэсэн сонгуулийн дараах анхны ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах эсэхийг шийдвэрлэнэ.

Асуулт асуух **хугацаа 4 минутаас** илүүгүй, нэмэлт хугацаа 1 минут бөгөөд хариулт, тайлбар хангалттай бол 1 минут нэмэлт асуулт асуух, тайлбар авч болно. Зарчмын зөрүүтэй саналлын талаар хуулийн төслийг зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй гишүүн **илүүгүй** хугацаанд тайлбарлаж болно

Асуулт асуух **хугацаа 4 минутаас** илүүгүй, нэмэлт хугацаа 1 минут бөгөөд хариулт, тайлбар хангалттай бол 1 минут нэмэлт асуулт асуух, тайлбар авч болно. Зарчмын зөрүүтэй саналлын тойм өдөлөл гаргасан гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй саналлыг тайлбарлаж, Төлөвийг дэмжсэн 3 хүртэл, эсрэг байр суурьтай 3 хүртэл гишүүн тус бүр 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэхий дараа санал хураалт явуулах.

41.3.2.хуралдаан дараалагч зарчмын зөрүүтэй санал тус бүрээр Байнгын хорооны санаагаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санаагаар шийдвэрлэх.

ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛНА

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгатай холбогдуулж асуулт асуулга. Хуулиар заасан 3 үндсэслэгээр санал хураалт явуулж болно

БАЙГУУЛЛАГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛНА

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бэлтгэж, танилцуулга, санал хураалтаас тойм өдөлөгч хамт нийтэлж тараана.

Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүний асуулт асуух **хугацаа 3 минутаас илүүгүй**, нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалттай гэж тухайн гишүүн үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асуух, тайлбар авч болно.

хуулийн төсөлтэй холбогдуулан бичгээр санал гаргасан бол түүнийхээ үндэслэлийг **5 минутаас илүүгүй** хугацаанд тайлбарлаж болно

НЭГДСЭН ХУРАЛДААНААР ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛНА

Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулж, гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн батлагдсанд тооцно

ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЭЦЭСЛЭН БАТЛАНА

Байнгын хорооны хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүнд үндэслэн эцэслэн батлуулах төслийн хувилбарыг бэлтгэж, нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнө гишүүдэд тараасан байна

Танилцуулга, санал, дүгнэлтээ холбогдуулан асуулт асуух болно.

санал хураалтах томьёолол оруулсан бол үг саналыг дэмжсэн 3 хүртэл, эсрэг байр суурьтай 3 хүртэл гишүүн тус бүр 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэхий дараа хуралдаан дэгэлдэч саналын томьёолол тус бүрийг ээлжээ сонгон санал хураалт явуулна.

НЭГДСЭН ХУРАЛДААНААР ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛНА

санал хураалт явуулж дууссаны дараа тухайн хуулийн төслийг эцэслэн батлуулах болгон хэлэлцэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ

Долоо хоногийн Баасан гарагийн 10.00 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна

ЗӨЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
Монгол Улсын Засгийн газар	2020.08.20 - 2020.08.28	Баталсан өдрөөс



Тогтоолын зорилго нь зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувьд хүргэхдээ санхүүжилтийн зардлыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед санхүүгийн зуучлалыг хязгаарлахгүйгээр зээлийн хүүг бууруулахад баримтлах бодлогын чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний эрх зүйн үндсийг тодорхойлж, тогтоолын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий холбогдох байгууллагад үүрэгжүүлэх, хэрэгжилтийг хангаж, хагас жил тутам Улсын Их Хуралд тайлагнаж, үр дүнд парламентын хяналтыг хэрэгжүүлэх явдал юм.

“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
Монгол Улсын Засгийн газар	2020.08.14 - 2020.08.28	Баталсан өдрөөс



“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг Улсын Их Хурлын тогтоолын хавсралтаар баталсан.

Тогтоолд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах, хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх, хөтөлбөрт туссан экспортыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгон иргэдийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засагт нөлөө үзүүлэх 10 томоохон төслийг санхүүгийн боломжит бүх арга хэрэгслийг ашиглан санхүүжүүлэхийг Засгийн газарт даалгалаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах,

байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн 6 бүлгийн 23 тэргүүлэх зорилтод хамаарах зорилт, дэд зорилтуудыг тодорхой тусгалаа.



ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
Монгол Улсын Засгийн газар	2020.09.30 - 2020.11.05	2021.01.01

Улсын Их Хурлын тогтоолын агуулга:

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг энэ онд агшиж, цаашид сэргэх хугацаа одоогоор тодорхой бус хэвээр байна. Энэ нь их хямралаас хойшхи хамгийн огцом уналт болж, улс орон бүр эдийн засгийн хүндрэл, сорилттой нүүр тулж байна. Ковид-19 цар тахал, түүнээс сэргийлэх арга хэмжээний нөлөөгөөр эдийн засагт оролцогчдын хүлээлт өөрчлөгдөж, бизнесийн үйл ажиллагаа хязгаарлагдаснаас эдийн засаг эхний хагас жилд 9.7 хувиар агшаад байна. Энэ үед Монголбанк эдийн засгийн уналтаас иргэд, аж ахуйн нэгж, банкны системийг хамгаалах, үүссэн шокыг зөөлрүүлэх зорилгоор зах зээл дээрх хөрвөх чадварыг дэмжиж санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэх, банкны хяналт шалгалтын журам болон шалгуур үзүүлэлтүүдэд түр тохируулга хийх, өөрчлөлт оруулах, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах зэрэг мөнгөний бодлого, макро зохистой бодлого болон микро зохистой бодлогын багц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь чухал байгаа Монгол банк онцолсон юм. Энэхүү тогтоолын гол агуулга нь:

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд хууль, эрх зүйн орчныг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын зөвлөмжтэй нийцүүлэн боловсронгуй болгох, Монгол Улсын үнэлгээний үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, үндэсний хөтөлбөрийг батлах;
2. Санхүүгийн гэрээ, хэлцэлд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрийн хооронд үүссэн маргааныг шүүхээс богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх, барьцаалагчийн шаардах эрхийг хангуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах;
3. Банкны салбарын актив хөрөнгийг ангилж, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах эрх зүйн зохицуулалтыг олон улсын шилдэг туршлага, зөвлөмж, Монгол Улсын банкны салбарын онцлогт тулгуурлан боловсронгуй болгож, үе шаттайгаар мөрдүүлэх;
4. Олон улсын шилдэг туршлагад үндэслэн орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;
5. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах;
6. Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийн үед импортыг орлох, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн мөнгө, санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх юм.

Тогтоолын төсөл хэлэлцэх үеийн бүлгийн байр суурь:

Эрх баригчид гаргаж буй бодлогын алдаандаа үнэлэлт дүгнэлт өгч засаж сайжруулахын оронд өрсөлдөгч улс төрийн хүчиндээ тохож харлуулах, эсвэл ямар нэгэн зүйлийг онцолж булталдаг буруу зуршлаа энэ удаа ч орхисонгүй. Энэ удаа өмнөх дөрвөн жилд гаргасан алдаа, дутагдал бүхнээ Ковид-19-д наахаар шийджээ. Монголбанкнаас өргөн мэдүүлж буй мөнгөний бодлогыг эрх баригчид алга ташиж хүлээн авч болох ч, ард иргэдийн амьдралд ямар үр нөлөө үзүүлж байгааг анзаарч харахыг Ардчилсан намын гишүүд хүссэн юм.

Мөнгөний бодлогын үндсэн зорилтыг Монголбанк хэрхэн биелүүлж, хэрэгжүүлж чадаж байна вэ? Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино” гэж маш тодорхой заасан байдаг. Харамсалтай нь, нэг ам.доллар аль хэдийн 29 боодол нэгтийн төгрөгтэй тэнцэх хэмжээнд ирлээ. Монгол улсын үндэсний валют болох төгрөгийн ханш сүүлийн дөрөвхөн жилийн хугацаанд дөчин хувиар үнэгүйдэж, суларчээ.

Манай улсын нийт импортын 70 хувийг ам.долларааар хийдэг ба хэрэглээний сагсны 40 хувь нь импортын бараа эзэлдэг. Тиймээс, гадаад валютын ханшийн чангаралт, тэр тусмаа ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн чангаралтаас шалтгаалж импортын болон өргөн хэрэглээний барааны үнэ өсөж улмаар иргэдийн амьдралд, ялангуяа тэтгэврийн насны ахмадууд, дундаас доош орлоготой иргэдийн амьдралд туйлын хүнд цохилт ирж байна. Мөн улс орны хүндийг нуруундаа үүрч яваа бизнес эрхлэгчид, тэр дундаа долларын зээлтэй зээлдэгчдийн хувьд асар хүнд дарамт ирдэг.

Гэтэл Монголбанк өөрөө ханшаа хөөрөгдсөн нь харамсалтай. Зах зээлийн нийгэмд шилжсэн 26 жилийн хугацаанд буюу 2016 оны 3 сард мөнгөний нийлүүлэлт (М2) нь 10.1 их наяд төгрөг байжээ. Гэтэл дөрөвхөн жилийн дотор буюу 2020 оны 9 дугаар сарын эцэст 22.3 их наяд төгрөг болж, зах зээлд хоёр дахин их мөнгө нийлүүлсэн нь эдийн засгийн макро үзүүлэлт ялангуяа ханш огцом хөөрөгдсөн нь харамсалтай. 2016 оны сүүлийн 6 сард 1 тэрбум, 2017 онд 670 сая, 2018 онд 1.5 тэрбум, 2019 онд 2.9 тэрбум, 2020 он гараад 2.3 тэрбум ам.доллар буюу нийтдээ 8 тэрбум 370 сая ам.долларыг интервенцэд зарцуулжээ. Ийм их хэмжээний валютыг олохын тулд Монгол улс алт, мөнгө, зэс, нүүрс, төмрийн хүдэр, цайр, нефть зэрэг үнэт баялгаа бүтэн хоёр жилийн турш олборлож экспортлодог. Нэг гараараа мөнгөний нийлүүлэлтийг огцом ихэсгээд нөгөө гараараа баялгаас олсон валютаа зарж үгүй хийдэг мөнгөний бодлого дэлхий аль ч улсад байхгүй талаар Ардчилсан намын гишүүд шүүмжилж байв.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом суларч, мөнгөний нийлүүлэлт эрс нэмэгдэж, олон улсын санхүүгийн байгууллагуудын хар, саарал жагсаалтад бичигдэж улмаар макро эдийн засгийн тогтвортой байдал эрсдэл дагуулах хэмжээнд хүрснийг дээр дурдсан статистик үзүүлэлтүүд батлан харуулж байна. Монгол Улсын хувьд эдийн засгаа тогтвортой хөгжүүлэх, иргэдэд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох, зээлийн хүүг бууруулах зэрэгт зээлжих зэрэглэл асар чухал. Гэвч манай улсын эдийн засгийн хөрөнгө оруулалтын зэрэглэл “эрсдэлтэй” ангилалд багтаж, зээлжих чадвар сул байгаагаас хөрөнгө оруулалтын зардал өндөр дүнтэй

тогтож байна. Энэ бүхэн өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн Мөнгөний бодлого “бай”-гаа огт оноогүйн тод жишээ юм. Засгийн газар болон Төв банкны хоорондох төсөв, мөнгөний бодлогын уялдаа алдагдаж, тэнцвэртэй нэгдсэн зохицуулалт дутагдаж, арга барилаа эрс шинэчлэх, үгүй болсон төрийн хариуцлагын механизмыг энэ чухал салбарт сэргээх зэрэг улс орны эдийн засгийн амьдралд онц чухал шаардлагатай шийдлүүд бидний өмнө хүлээгдэж байна.

Бэлтгэсэн: Раднаасэдийн Даваадорж
(Эдийн засгийн ухааны доктор, УИХ дахь
Ардчилсан намын бүлгийн ажлын албаны эдийн засгийн зөвлөх)

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
Монгол Улсын Засгийн газар	2020.09.30 - 2020.11.13	2021.01.01

Хуулийн агуулга:

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2021 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулах юм.

Монгол Улсын төсөвт 2021 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 8,737,771.7 сая төгрөг, төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 10,676,615.3 сая төгрөг, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ 2.1 их наяд төгрөг байна.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 1,390,921.0 сая төгрөгөөр санхүүжүүлэх, “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд 266,268.7 сая төгрөгийн эргэн төлөлт хийхээр болжээ.

Төсвийн тогтворжуулалтын санд 2021 оны төсвийн жилд 156,016.9 сая төгрөгийн, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2021 оны төсвийн жилд 1,180,143.1 сая төгрөгийн хэмжээтэй хөрөнгө хуримтлуулахаар тооцоолсон байна.

2021 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлэхээр баталсан.

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	2,348.3
2	Дорнод	1,430.2
3	Өмнөговь	79,029.7
4	Дархан-Уул	2,686.4
5	Улаанбаатар	420,788.2
6	Орхон	27,585.6
	Нийт дүн	533,868.4

Хуулийн төсөл хэлэлцэх үед бүлгийн байр суурь:

МАН-ын олонхиороо хүч түрэн 2021 оны төсвийг 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв баталсан. Хэдхэн сарын өмнө 2020 оны төсвийн тодотголыг 4.8 их наяд төгрөгийн алдагдалтай баталж зөвхөн 2020, 2021 онуудад 7 их наяд төгрөгний өр үйлдвэрлэсэн. 7 их наяд төгрөгөөр 200 мянган өрхийг шинээр байранд оруулж болно. Нэг бог малыг 150 мянган төгрөгөөр тооцвол Монгол улсын нийт малын 65 хувь буюу 46 сая толгой бог малтай дүйцэх хэмжээний их хөрөнгө төсвөөр дамжин хоёрхон жилд үрэн таран болж байна.

Дөрвөн жилийн өмнө Монгол гэдэг айлын төсвийн зарлага 6-7 их наяд төгрөгийн хэмжээнд тогтвортой эргэлдэж байсан бол ирэх онд 14 их наяд төгрөгт хүрч хоёр дахин өссөн. Засгийн газрын өр 1991 оноос 2016 оны 2-р улирлын хооронд 4 тэрбум 785 сая ам.доллар байсан. Гэвч өнгөрсөн дөрвөн жилд 3 тэрбум 106 сая ам.доллараар нэмэгдлээ. Ийм их хэмжээний өрийг өмнө нь аль ч УИХ, Засгийн газар үйлдвэрлэж байсангүй. Монгол улсын гадаад өр улс орны эдийн засаг, тусгаар тогтнолын аюулгүй байдалд аюул занал учруулах хэмжээнд хүрснийг анхааруулаа.

Сүүлийн үед төсвийн хөрөнгө оруулалтад асар их хөрөнгө зарцуулдаг болсон. Тодруулбал, 2016-2020 онд нийт 5 их наяд 945 тэрбум төгрөг зарцуулжээ. 2021 онд улсын төсвөөс 1.6 их наяд, гадаадын зээлээр 1.2 их наяд төгрөгийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр Засгийн газраас өргөн барьсан улсын төсөв тооцоо судалгаагүй тедийгүй Төсвийн тухай хуулийн олон заалтуудтай зөрчилдөж байна. Төсвийн зардлаа танаж, алдагдал багатай батлах, гадаад өрийн дарамтыг эрс багасгах, үр ашиггүй хөрөнгө оруулалтаа эрэмбэлэх зарчим өргөн барьсан төсөлд огт туссангүй.

Засгийн газар гурван жил дараалан 42 сая тн нүүрс экспортолно гэж тооцжээ. Ийнхүү цар тахлын эрсдлийг тооцох нь бүү хэл валют олдог үндсэн түүхий эдийнхээ тооцоо судалгааг ч дорвитой хийж чадаагүй байна. Жилийн жилд биелэхгүй өндөр орлого төлөвлөж байгаа нь төсвийн алдагдлаа бага дүнтэй харагдуулах, өөрсдөдөө ахиухан хөрөнгө хуваарилах халхавч юм.

Манай улсын халамж хавтгайрч, хяналтаас гарчээ. 2021 онд төсвөөс 1 их наяд 650 тэрбум төгрөгийн 73 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг давхардсан тоогоор 2 сая 655 мянган иргэнд өгөхөөр төлөвлөсөн байна. Мөнгө тарааж, ядуурлаас гарсан улс энэ дэлхийд байхгүй, иргэдээ ажлын байраар хангах, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих цогц бодлого хэрэгжүүлэхийг шаардлаа.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг сайжруулах дараах шийдлийг санал болгосон юм. Үүнд:

1. Үндэсний Аудитын газраас төсвийн орлого бүрдэх хүндрэлтэй өнөө цагт тэвчиж болох зардлуудыг 20 хүртэл хувиар бууруулах шаардлагатай гэж дүгнэсэн. Харин бид ийм зардлыг 40 хувьд хүргэх боломж байгааг тооцож гаргалаа. Төсвийн байгууллагын аливаа сургалт семинар, хурал зөвлөгөөн, гадаад дотоод албан томилолт болон төрөөс иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг бүх төрлийн үйлчилгээ, тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулах замаар зардлыг эрс бууруулах бүрэн боломжтой.
2. Хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлж үзэхэд нэн чухал биш 149 төслийг нэг жил царцаахад 405 тэрбум 464 сая төгрөг хэмнэж болохоор байна. Нэмээд уул уурхайгаас төсөвт ордог орлогын 20 хувийг ЖДҮ дэмжих санд төвлөрүүлэх бүрэн боломжтой. Зөвхөн энэ хоёр хэмнэлтээс нэг их наяд төгрөгийг бий болгож импортыг орлох, ажлын байр нэмэгдүүлж буй аж ахуй нэгж, жижиг дунд үйлдвэрлэгчдийнхээ үйл ажиллагааг дэмжих санал гаргасан.
3. Төрийн албан тушаалын хийдэл, чиг үүргийн давхардлыг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор төрийн албыг цомхтгох, ялангуяа дэд сайд, агентлагийн дэд дарга, газрын дарга зэрэг удирдах албан тушаалын давхардлыг арилгах нь эдийн засаг хямарсан үеийн шилдэг арга гэдгийг Ардчилсан нам 2012-2016 онд батлан харуулж чадсан.
4. Монгол улсын ДНБ-ний хэмжээтэй тэнцэх хэмжээний хөрөнгөтэй олон зуун ТӨХК, орон нутгийн болон төрийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагуудын хувьдаа улсын хөрөнгө мөнгө зувчуулж буй асуудалд нэн даруй харицлага тооцож, хувьчлал, үр дүнтэй удирдлагыг тогтолцоог хойш тавилгүй эхлүүлэх ёстой.
5. Монгол улсын 100 орчим сумдад нэг ч төгрөгийн хөрөнгө оруулалт тавиагүй байж, хоёр, гурван сумын баг дээр энэ онд 28 тэрбум, ирэх жил 13.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавьж улсын төсвийг өөрдсийн нэр хүндээ өсгөх хэрэгсэл болгож байгааг таслан зогсоох ёстойг эрх баригчдад анхааруулаа.

Засгийн газар өргөн барьсан төсвийн төслөө эргүүлэн татаж сайжруулж хэлэлцүүлэх шаардлагатай гэдгийг УИХ дахь Ардчилсан намын бүлэг санууллж байсан ч эрх баригчид олонхиороо хүч түрэн сөрөг хүчний санал, дүгнэлтийг хүлээж авсангүй. Энэ нь хойшид Монгол улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх нь гарцаагүй юм.

Бэлтгэсэн: Раднаасэдийн Даваадорж
(Эдийн засгийн ухааны доктор,
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны эдийн засгийн зөвлөх)

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
/Анхдагч хууль/

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
Засгийн газар	2020.09.30 - 2020.11.13	2021.01.01

Хуулийн агуулга:

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлж Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн баталсан.

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах юм.

Малын тоо толгойн албан татварын орлогыг тухайн сум, дүүргийн татварын орлого болон орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуульд тусгаж өгсөн болно.

Албан татварын хэмжээ нь нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байх бөгөөд албан татварын хэмжээг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно. Түүнчлэн Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно. Энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлөхөөр зохицуулсан.

Мэдээлэл бэлтгэсэн: УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуулийн ахлах зөвлөх Л.Дэлгэрмаа

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ
(шинэчилсэн найруулгын төсөл)

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн	2020.04.22-2020.12.24	2021.01.01

Хуулийн агуулга:

Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт орсонтой уялдуулж хуулийн төслийг боловсруулсан бөгөөд орон нутгийн төсөв, санхүүгийн хараат бус, бие даасан байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэхийг зорьсон. Ингэхдээ орон нутгийн сан, өмчийн удирдлага, төсөв, татвар, төлбөр, хураамж, болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудалд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэхээр, мөн багийг аравтын зохион байгуулалтад, хороог хэсгийн зохион байгуулалтад оруулахаар тусгажээ.

Анхаарал татсан зарим зохицуулалтаас дурдвал, Засаг даргад нэр дэвшигчийг дээд шатны Засаг дарга болон Ерөнхий сайд нэр дэвшүүлэх санал гаргаж болохоор, Ерөнхий сайд нэр дэвшигчийг томилохоос татгалзвал өөр хүний нэрийг дэвшүүлэх, нутгийн өөрийн удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэж, үүний төлөө хариуцлага хүлээхээр, мөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлэхийг хязгаарлахын зэрэгцээ, бүх шатны Засаг даргыг нутаг дэвсгэрийнхээ нийгэм, эдийн засаг, хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон Ерөнхий сайд, дээд шатны Засаг даргын өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл хариуцлага тооцох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хууль хэлэлцэх үеийн бүлгийн байр суурь:

Аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг дээд шатны Засаг дарга томилдог байв. Гэтэл шинээр батлагдсан хуулиар иргэдийн Нийтийн Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас санал болгосон нэр дэвшигчийг дээд шатны Засаг дарга болон Ерөнхий сайд тодорхой үндэслэл, шалтгаангүйгээр буюу “өөрийн үзэмжээр” томилохоос татгалзах эрхтэй болгосныг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд эсэргүүцэж байв

ХУУЛИЙН ТӨСӨЛ	ҮНДСЭН ХУУЛЬ
“56.5. Засаг даргад нэр дэвшүүлэх ажиллагааг дараах журмаар явуулна: 56.5.1.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь нам, эвслийн бүлэг, түүнчлэн иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтарч энэ хуулийн 56.3, 56.4-т заасан шаардлага хангасан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлэхээр санал гаргана. Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 56.3, 56.4-т заасан шаардлага хангасан хүнийг тухайн Хуралд санал болгож болно;”	Жардугаар зүйл 2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, … дөрвөн жилийн хугацаагаар томилно. Гуравдугаар зүйл 1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.

ХУУЛИЙН ТӨСӨЛ	ҮНДСЭН ХУУЛЬ
“56.7. Дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд тухайн нэр дэвшигчийг томилохоос татгалзаж болно.”	Жаран хоёрдугаар зүйл 2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно.
“56.8. Энэ зүйлийн 56.7-д зааснаар томилохоос татгалзсан тохиолдолд Хурал энэ зүйлийн 56.5-д заасан журмаар өөр хүний нэрийг дэвшүүлнэ.”	Жардугаар зүйл 3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална.

Иргэдийн сонгох, төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийн үйл хэрэгт оролцох эрхийг боомилсон, нэг намын дарангуйлал тогтоох нөхцөлийг бүрдүүлсэн нь Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.” хэмээн нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байхаар маш тодорхой, хоёрдмол утгагүй хуульчлан баталгаажуулсныг илтэд зөрчсөн үйлдэл мөн хэмээн үзэж буйгаа илэрхийлж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Үндсэн хуулийн цэцэд хандахаа мэдэгдсэн.

Мэдээлэл бэлтгэсэн:
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуулийн зөвлөх Б.Ганхөлөг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ Шинэчилсэн найруулга /

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан нарын гишүүд	2019.09.03 - 2020.12.24	Ердийн журмаар

Хуулийн агуулга:

Сонгуулийн тухай хуулийг 2015 онд баталж Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоотой бүхий л харилцааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах болсон. Энэ нь хууль хэрэглээний болон зохион байгуулалтын хүндрэлтэй нөхцөл үүсгэсэн төдийгүй, зөвхөн тухайн сонгуульд үүсэх онцлог харилцааг зохицуулах тусгайлсан зохицуулалт шаардлагатай гэж үзсэн.

Энэхүү төсөл нь 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой харилцааг зохицуулсан суурь зохицуулалтуудад үндэслэн боловсруулсан байна. Хуулийн төсөл нь 11 бүлэг, 80 зүйлтэй.

Хуулийн төсөлд Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгуулийн хороодын бүрэн эрх, ажлын зохион байгуулалттай холбогдсон харилцааг бусад сонгуулийн хуультай нийцүүлэн боловсронгуй болгосоноор Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулах эрх зүйн орчин боловсронгуй болж, хууль хэрэглээний болоод зохион байгуулалтын хувьд нэг мөр, ойлгомжтой болохоос гадна хууль хоорондын уялдаа хангагдаж, хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн.

Хуулийн төслийн ажлын хэсэгт УИХ дахь Ардчилсан намын бүлгээс УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн ажиллаж өөрийн болон бүлгээс гарсан зарчмын зөрүүтэй саналуудаа дэмжүүлэн ажиллаа.

Хуулийн төсөл хэлэлцэх үеийн бүлгийн байр суурь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл өмнөх сонгуулийн тухай хуулиас хуулбарласан, хууль зүйн техникийн алдаа ихтэй, утга найруулга ойлгомжгүй зүйл заалттай, хоорондоо зөрчилдсөн заалт олонтой байсан. УИХ дахь Ардчилсан намын бүлэг зарчмын зөрүүтэй олон санал гаргаж дэмжүүлснээс дурдвал:

- Санал өгсөн сонгогчийн хуруунд бэхэн тэмдэглэгээ хийх,
- Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэд санал өгөхөөр бүртгүүлэх, санал өгөх зэрэг үйл ажиллагааг хүндрэлгүй зохион байгуулах үүднээс шуудан, цахим шуудан, факсаар сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлэх,
- Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчийг цахим хуудаст байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчдын мэдээлэлтэй танилцах боломжоор хангах,
- Хандивын асуудал дээр хандив өгч байгаа этгээдийн хуульд заасан шаардлага

хангаагүйгээс үүдэж хариуцлага хүлээх бол хандивлагч хариуцлага хүлээх,

- Сонгуулийн сурталчилгааг хэвлүүлэх сонин, сэтгүүл нь сүүлийн 12 сарын турш тогтмол дугаар гарсан байх бөгөөд түүнд нийтлүүлэх сурталчилгааны төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн үнийн дунджаас хэтрэхгүй байх заалт нэмэх,
- Сонгуулийн зардлын дансанд төвлөрөх хөрөнгийн хэмжээнд хязгаар тогтоохгүй бөгөөд сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээнээс сонгуулийн зардлыг хэтрүүлэхгүй байх,
- Ажиглагч нь сонгогчийн бүртгэлийн мэдээлэл болон сонгогчийн сонгуульд оролцсон эсэхийг хянан ажиглах боломжоор бүрэн хангагдсан байх бөгөөд хэсгийн хорооны хуулийн дагуу явагдаж байгаа үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр, түүнчлэн сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхийг хөндөхгүйгээр эргэлзээтэй үйл, баримтыг ойртон харах, нягтлах эрхтэй байх саналуудыг гаргаж дэмжүүлж чадлаа.

Мэдээлэл бэлтгэсэн:
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуулийн
ахлах зөвлөх Л.Дэлгэрмаа

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
/ Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль/

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
Монгол Улсын Засгийн газар	2020.12.01 - 2020.12.31	Ердийн журмаар

Хуулийн агуулга:

Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага.

Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор УИХ 6 жил томилдог байсан. Харин хуулийн төслөөр Авлигатай тэмцэх газрын зөвхөн дэд даргыг Авлигатай тэмцэх газрын дарга томилдог байхаар өөрчлөлт оруулж ирсэн.

Хууль санаачлагч төрийн албаны захирах захирагдах ёсыг хэрэгжүүлэх, мөн УИХ-аас даргын нь томилдог байгууллагын жишгээр томилдог болгох шаардлагаас гадна дарга, дэд дарга хоёр нэг байгууллагаас томилогддог нь төрийн байгууллагад захирах, захирагдах ёс алдагдаж байна гэжээ. Гэтэл хуулийн төсөл хэлэлцүүлгийн явцад эрх баригчид үзэл баримтлалаасаа хазайж Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилдог болгон өөрчлөн баталсан.

Хуулийн төсөл хэлэлцэх үеийн бүлгийн байр суурь:

Хуулийн төсөл нь хууль зүйн техник алдаатай, харилцааг дутуу зохицуулсан төсөл байсан бөгөөд УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд хууль санаачлагч нь хуулийн төсөл өргөн барихдаа алдаагүй, нэг мөр ойлгогдох хуулийн төсөл боловсруулж өргөн барих шаардлагатай байгааг анхааруулсан.

Хуулийн төсөл хэлэлцүүлгийн явцдаа хуулийн төслөөр зохицуулаагүй байсан Авлигатай тэмцэх газрын даргын асуудлыг хөндсөн бөгөөд хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага байхаар хуульчилсан, тийм ч байх ёстой Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий сайд буюу улс төрийн намын даргын саналаар томилох тухай Авлигын эсрэг хуулийн энэ өөрчлөлт нь Монголын ард түмнийг авлигачдын өмнө бөхийлгөж, Монгол төрийг авлигачиддаа бүрэн бууж өгөхөд хүргэж байна.

Авлигын эсрэг Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн” гэж заасан бөгөөд Монгол Улсын Авлигатай тэмцэх газар нь “олон талт зорилго бүхий хууль сахиулах эрх мэдэлтэй, урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллага”-ын загвараар байгуулагдсан төрийн тусгай байгууллага юм.

Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын албан тушаалтнууд, төрийн өндөр албан тушаалтнууд л авлигын хэрэгт холбоотой байх нь элбэг, гэтэл тэдгээр гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын харьяа байгууллагуудын төрийн өндөр албан тушаалтан, төрийн байгууллагын дарга, албан тушаалтнуудын авилгын хэргийг шалгах байгууллагын даргыг Гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн томилох нь авлигатай тэмцэх биш эсрэгээрээ авлигыг хэргийг шалгахгүй, хянахгүй болох юм.

Тиймээс Авлигатай тэмцэх газрын удирдлагыг томилох асуудлыг хуульчлахдаа ийм онцлог бүхий байгууллагын удирдлагыг томилоход баримталдаг “институцийн оролцоог жигд хангах” олон улсын туршлага, тогтсон гол арга замаас Монгол Улс ухарч огт болохгүй бөгөөд харин ч эсрэгээр улам төгөлдөржүүлж, боловсронгуй болгох нь зөв гэж УИХ дахь Ардчилсан намын бүлэг үзлээ.

Мэдээлэл бэлтгэсэн:
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуулийн
ахлах зөвлөх Л.Дэлгэрмаа

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ / Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
Монгол Улсын Засгийн газар	2020.12.17 - 2020.12.31	Ердийн журмаар

Хуулийн агуулга:

Дэлхий дахинаа тархаад байгаа Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор УИХ-аас 2020 оны 4 дүгээр сард Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль баталсан. Энэ хуулийн үйлчлэл 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусаж байгаа боловч цар тахал хумигдаагүй, дотоодоо халдварыг алдаж өдрөөс өдөрт нэмэгдэж, нийгэм, эдийн засаг хүнд байдалд орж байгаа тул уг хуулийн үйлчлэлийн хугацааг сунгах, хуулиар дутуу зохицуулсан харилцааг нэмж зохицуулах, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаатай холбогдох Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын Онцгой Комиссын үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох, иргэн, хуулийн этгээдийн үүргийн талаар нэмж оруулах, бусад хуультай давхардсан зохицуулалтыг хүчингүй болгож, зарим зохицуулалтыг хуульд нийцүүлэн өөрчлөн найруулсан байна.

Хуулийн төсөл хэлэлцэх үеийн бүлгийн байр суурь:

УИХ дахь Ардчилсан намын бүлэг Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачлан 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Засгийн газраас санал авч УИХ-д өргөн барихаар цаг товлохоор хандсан боловч МАН гацааж, улс төржүүлж байгаад харамсаж байна.

Цар тахлаар улс төржихийн оронд Засгийн газар болон Ардчилсан намын бүлгийн санаачилсан хоёр хуулийн төслийг нэгтгэн хэлэлцүүлж хэрэгтэй амьдралд хэрэгтэй зүйл, заалтуудаа баталсан бол иргэд, аж ахуйн нэгж болоод нийгэм, эдийн засагт чухал байх байлаа.

Засгийн газрын өргөн барьсан хуулийн төсөл иргэдийн эрхийг зөрчиж байгаа, халдвар авсан иргэн, түүний гэр бүлийн нэр хүндийг хамгаалах, цар тахлын улмаас сурч боловсрох эрх нь хязгаарлагдаж байгаа Бүх шатны сургалтын байгууллагын оюутан, сурагчдын сургалтын төлбөрийн асуудал, оюутан, сурагчдын дотуур байрны төлбөрийн асуудлыг зохицуулаагүй байгааг шийдвэрлэх шаардлагатай, мөн Монгол Улсын иргэд эх орондоо буцаж ирэхэд үүсэж байгаа хүндрэлийг цаг алдалгүй шийдвэрлэх, эх орондоо буцаж ирэх хүсэлт гаргасан Монгол Улсын иргэдийг цар тахлын нөхцөл байдлыг үл харгалзан татан авах ажлыг шуурхай зохион байгуулах шаардлагатай байгааг анхааруулаа.

Мэдээлэл бэлтгэсэн:
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуулийн
ахлах зөвлөх Л.Дэлгэрмаа

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ Шинэчилсэн найруулга /

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
Монгол Улсын Засгийн газар	2020.04.10 - 2021.01.15	2021.03.01

Хуулийн агуулга:

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд тусгасан Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журам, шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болох зохицуулалтыг уг хуульд нийцүүлэн зохицуулах шаардлага үүссэн. Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгаж зохицуулсан.

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим, Монгол Улсын шүүхийн тогтолцоог Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн тодорхойлох, шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий Шүүгчдийн зөвлөлийг ажиллуулах, бүх шатны шүүхийн болон шүүгчийн болон ерөнхий шүүгчийн бүрэн эрх, Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнтэй холбоотой зохицуулалт, Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан, Ерөнхий шүүгчийн бүрэн эрхтэй холбоотой асуудлыг, бүх шатны шүүх, түүний бүрэн эрхийг, шүүгчид тавих болзол, шаардлагыг, сонгон шалгаруулах томилох, шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах баталгаа, хүлээлгэх хариуцлага, сахилгын шийтгэлийн төрлүүд, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тусгаж, иргэдийн хяналтыг сайжруулах, оролцоо итгэлийг нэмэгдүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх үүднээс иргэдийн төлөөлөгчийн тоог нэмэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр ялгаатай нэрлэгдэж байгааг /дүгнэлт, санал/ нэг мөр болгох, иргэдийн төлөөлөгчийн хөлс олгох журамд албан томилолт, замын зардалыг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, ерөнхий зөвлөлийн 10 гишүүдийг нэр дэвшүүлж томилж, Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, сахилгын хороог бие даан ажиллуулах болон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх зэрэг зохицуулалтуудыг боловсронгуй болгож зохицуулсан.

Хуулийн төслийн ажлын хэсэгт бүлгээс УИХ-ын гишүүн Ш.Адьшаа ажиллаж өөрийн болон бүлгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналуудыг дэмжүүлж ажиллаа.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэгтэй ажлын хэсэг хуулийн төслийн 70 гаруй хувьд өөрчлөлт оруулж, сайжруулж УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Монгол Улсын шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай тусдаа хуулиудыг 2012 онд батлан дагаж мөрдөж байсныг хууль тогтоомжийг нэгтгэн Монгол Улсын Шүүхийн тухай багц хуулийг боловсруулан батлуулсан.

Хуулийн төсөл хэлэлцэх үеийн бүлгийн байр суурь:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар цаг хугацааны хувьд нэг зэрэг өргөн барьсан. Энэ 2 төслөөс Засгийн газрын өргөн барьсан төслийг суурь болгож Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн төслөөс боломжтой хувилбаруудыг тусгаад явах нь зөв гэж бүлэг дүгнэсэн. Шүүхийн тухай хууль батлагдахад дараах асуудлуудыг дэмжихгүй.

- Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан, УИХ-ын гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулж, санал болгох замаар УИХ-аас томилох тухай заасан хуулийн зохицуулалтууд нь шүүхийн боловсон хүчний бодлого болон шүүхийн сахилга хариуцлагын асуудалд улс төрийн нөлөө шууд орох, шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бүрэн алдагдуулах гол үндсийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг Улсын Их Хурал буюу угтаа төрийн эрх баригч нам, түүний гишүүн улс төрчид өөрөө сонгож, өөрөө томилох замаар Үндсэн хуулийн байгууллагуудыг эрхшээл, нөлөөлөлдөө бүрэн авч байгаа нь шүүгчийг томилох, шүүгчид хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаанд нөлөөлөн оролцох нөхцөлөө бүрдүүлсэн хэрэг болж байна.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр “эрх зүйч” этгээд ажиллах боломжийг тусгасан нь зүйд нийцэхгүй бөгөөд тус байгууллагуудад эрх зүйн байдлаараа адил биш, ялгамжтай бүрэлдэхүүн ажиллахаар болж байгааг дэмжих боломжгүй.
- Эрүү, иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийг тухайн шатанд нь дахин нэгтгэж, дотор нь эрүү, иргэний хэргийн чиглэлээр танхимтай байж болох агуулга бүхий зохицуулалт тусгасан нь нэгэнт хүрсэн ололтоос ухарч буй буруу шийдэл гэж үзэж байна. Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулах нь иргэн зөрчигдсөн эрхээ тухайн маргааныг харьяалах дагнасан шүүх, мэргэшсэн шүүгчээр шүүлгэх замаар хууль ёсны шүүхээр шүүлгэх эрхээ эдлэх боломж бөгөөд энэ талаар хүрсэн түвшин, олсон ололтыг бууруулж болохгүй гэдэг хатуу байр суурьтай байна.
- Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчээс бусад шүүхийн ерөнхий шүүгч, танхимын тэргүүнийг тухайн шатны шүүхийн болон танхимын шүүгчид дотроосоо сонгодог байхаар зохицуулсан нь шүүгчдийг эрх ашгаар нэгдсэн бүлэглэл фракцуудад хуваагдах, өрсөлдөх, хуйвалдан тэмцэлдэх нөхцөл рүү түлхэж, шүүхийг өнөөгийн улс төрийн намуудаас өөрцгүй хэмжээнд ортол нь улам дордуулах бодит эрсдэлийг бий болгох бөгөөд үүнийг зөвшөөрч даамжруулбал Улсын дээд шүүхийн шүүгчдээс анхан шатны шүүхийн шүүгчид хүртлээ ашиг сонирхлоор сүлбэлдсэн, талцаж хуваагдсан тодорхой бүлэглэл фракцуудыг хуулиар байгуулж, Ерөнхий шүүгчдийг авч, ноёрхлоо тогтоосон бүлэглэл нь хонгил байгуулах, түүнийгээ удирдах хууль ёсны мэт зүй бус систем тогтоох аюултай гэж дүгнэж байна.

- Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг шүүгч гишүүн, шүүгч бус гишүүн гэж ангилж буй нь буруу бөгөөд орон тооны гишүүн тул ямар нэгэн ангилалгүйгээр хэрэг хуваарилах журмын дагуу маргааныг шийдвэрлэх үүрэгтэй. Энэ үүднээс Шүүхийн сахилгын хорооны гишүүн томилогдсоноор тангараг өргөх эрх зүйн зохицуулалтыг шинээр хуульд тусгах шаардлагатай гэдгээ илэрхийлсэн.

Мэдээлэл бэлтгэсэн:
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуулийн
ахлах зөвлөх Л.Дэлгэрмаа

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ Шинэчилсэн найруулга /

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
УИХ-ын гишүүн Н.Учрал нарын гишүүд	2018.03.26	Батлагдсан өдрөөс

Хуулийн агуулга:

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өргөн барьсан бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар, 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж үзэл баримтлалын хүрээнд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Ажлын хэсэг шинэчлэгдэн байгуулагдаж УИХ-ын гишүүдээс, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон төрийн бус байгууллагаас бичгээр ирүүлсэн саналыг хэлэлцэж 105 зарчмын зөрүүтэй саналын томьёолол бэлтгэж байнгын хороогоор хэлэлцүүлсэн. Хуулийн төсөлд хамтын гэрээ болон хамтын хэлэлцээрийн зааг ялгааг тодруулж, үйлчлэх хүрээг зааглаж, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хамтын гэрээ байгуулахад олон үйлдвэрчний эвлэлтэй тохиолдолд хэрхэн төлөөлөхийг нарийвчлан тусгаж өгсөн. Хөдөлмөр тухай хуулийн гол зохицуулах хэсэг нь хөдөлмөрийн гэрээтэй холбоотой зохицуулалт юм. Иймээс хөдөлмөрийн гэрээтэй холбоотой бүлгийг ажил олгогч, ажилтнуудад хэрэглэхэд хялбар, ойлгомжтой болгох үүднээс хөдөлмөрийн гэрээгээр зохицуулах нийтлэг харилцаа, хөдөлмөрийн гэрээний хэлбэр, агуулга, хугацаа, хөдөлмөр гэрээнд шаардах бичиг баримт, гэрээнд өөрчлөлт оруулах зэрэг нөхцөлийг тодорхой болголоо. Үүнээс гадна хөдөлмөрийн гэрээний төрлүүдийг дэд бүлэг болгож, тухайн хөдөлмөрийн гэрээний онцлог зохицуулалтыг энэ бүлэгт нарийвчлан тусгаж өгсөн. Хуулийн төсөлд иргэд хоорондоо байгуулж байгаа хөдөлмөрийн гэрээнд тусгайлсан зохицуулалт шинээр нэмэх шаардлагатай бөгөөд зарим хэм хэмжээг уян хатан болгоно. Тухайлбал, ажилтан өөрөө хүсвэл хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлэх, хөдөлмөрийн харилцааг хүсэлт гаргаснаас хойш 15 хоногийн дараа дуусгавар болгох эрхтэй байх, Ажилтанд түүний цалин хөлс, хуулийн дагуу хийсэн суутгал зэрэг цалин хөлсний талаар

мэдээллийг сар бүр бичгээр өгч байхаар ажил олгогчид үүрэг болгосон.

Түүнчлэн жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа ажилтнууд болон албан бус салбарт ажиллаж байгаа ажилтны цалин хөлс, ажил амралтын цаг зэрэг хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хуулиар зохицуулж, тэдний эвлэлдэн нэгдэх, ялгаварлан гадуурхахаас ангид байх, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид байх зэрэг суурь эрхийг хамгаалахаар төсөлд тусгасан. Түүнчлэн албадан хөдөлмөрт ямар ойлголт хамаарах талаар нарийвчлан тусгалаа. Туслах малчин, гэрийн үйлчлэгч, жасаагаар /уртын ээлжээр/ ажиллах талаар цоо шинэ зохицуулалтыг хуульчлахыг зорьж байна.

Хуулийн төсөл хэлэлцэх үеийн бүлгийн байр суурь:

Ажлын хэсэг анх өргөн барьсан хуулийн төслийн 70 орчим хувьд зарчмын зөрүүтэй өөрчлөлт оруулж, урьд өмнө нь зохицуулагдаж байгаагүй шинэ асуудлыг тусгах, нийт ажилтны хөдөлмөрлөх суурь эрх хангагдах бололцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас ангид байх, эвлэлдэн нэгдэн суурь эрхийг хамгаалах чиглэлээр маш сайн өөрчлөлт орсон. Гэхдээ хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтны зохистой тэнцвэрт байдлыг бий болгох чиглэлээр засан сайжруулсан гэх боловч ажил олгогчийг торгоно, шийтгэнэ гээд улсын эдийн засаг, төсөв, татвар бүрдүүлэлтэд чухал үүрэг бүхий хэсгүүддээ халтай зүйл заалтууд байгааг засах, өөрчлөн найруулах шаардлага байна. Тухайлбал, Хуулийн төслийн 62 дугаар зүйлийн 62.8. Ажил олгогч нэг хүнийг дагалдуулан сургаж, ур чадвар эзэмшүүлэх, туршлагатай ажилтныг дагалдан ажиллуулж байгаа дагалдан ажилтанд цалингийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, олговор олгох нь ажил олгогчид хохиролтой. Учир нь ажил олгогч өөрөө тухайн дагалдан этгээдийн сургана, дагалдангаар ажиллахад шаардлагатай нэмэлт зардлуудыг гаргана дээр нь нэмээд нэмэгдэл цалин, олговор олгох үүрэг хүлээх болж байна. Хуулийн төслийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэгт зааснаар ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байхдаа өөрийн буруугаас хохирол учруулсан бол уг ажилтны нэг сарын дундаж цалингаас хэтрэхгүйгээр хариуцлага хүлээлгэнэ гэсэн нь түүнээс илүү хохиролтой тохиолдолд ажил олгогч хохироод үлдэх нөхцөл үүсэж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийг дагалдаж оруулж ирсэн Зөрчлийн тухай хуулиар ажил олгогчийг маш олон зүйл заалтаар торгоно, шийтгэнэ гэсэн зохицуулалт байна. Манай улсын эдийн засгийн тодорхой хэсгийг нуруундаа үүрч яваа ажил олгогчдоо жаахан ч гэсэн дэмжиж, тэднийг зүй зохистойгоор эрх ашгийг нь хамгаалах ямар зохицуулалт байх талаар үндэслэл бүхий зохицуулалт шаардлагатай. Хуулийн төсөл батлагдсанаар нийт ажилтны хөдөлмөрлөх суурь эрх хангагдах бололцоо бүрдэх ба хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтны зохистой тэнцвэр бий болох боломжтой бөгөөд хөдөлмөр, нийгмийн асуудлыг аж ахуй нэгж, байгууллага дотроо харилцан зөвшилцөн шийдвэрлэх боломжтой болж хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөө сайжирна гэж дүгнэж байна.

Мэдээлэл бэлтгэсэн:
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуулийн
ахлах зөвлөх Л.Дэлгэрмаа

ХУВИЙН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
/Анхдагч хуулийн төсөл/

Хууль санаачлагч	Өргөн барьсан болон баталсан огноо	Дагаж мөрдөх хугацаа
УИХ-ын гишүүн Н.Учрал нарын гишүүд	2020.05.13	Ердийн журмаар

Хуулийн агуулга:

Нийгмийн даатгалын сангийн тухай хуулиар ажилтан болон ажил олгогчийн төлөх шимтгэлээс нийт 4 хувийг нь хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийн байгуулсан санд мөнгөн хэлбэрээр тушаахтай холбоотой харилцааг зохицуулах юм.

Хуулийн төслөөр тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд тэтгэврийн сан байгуулах, тэтгэврийн санг үүсгэн байгуулагчид тавих шаардлага, тэтгэврийн сангууд жилд нэгээс доошгүй удаа олон улсад нэр хүнд бүхий гадаадын аудитын байгууллагаар санхүүгийн тайлан мэдээгээ баталгаажуулах, сан байгуулсан этгээдийн захиргааны буюу урсгал зардал, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын зардал, гадаадын аудитын байгууллагын маш өндөр зардал, тэтгэврийн хөрөнгийг хадгалах кастодион компани, хөрөнгө оруулалтын менежментийн компани, хууль зүйн үйлчилгээ үзүүлэх этгээдүүдэй гэрээ байгуулах зардал, хөрөнгийн менежментийн хөлс, гүйцэтгэлийн үр дүнгийн хөлс гэх мэт зардлуудыг уг сангийн хөрөнгөөр төлөхөөр зохицуулсан байна.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлээр тэтгэврийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх талаар зохицуулсан. Энэ зохицуулалтаар иргэдийн тэтгэврийн хуримтлалаар үнэт цаас авах, гадаадын холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан хөрөнгө оруулатын санд хөрөнгө оруулах, ийнхүү хөрөнгө оруулахдаа хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хамтран ажиллах зохицуулалт орсон.

Шимтгэл төлөгч сангаа 3 жилд нэг удаа сольж болох боловч ийнхүү сольж шилжүүлсэн тохиолдолд өмнөх сан хөрөнгийг шилжүүлэхдээ захиргааны зардлаа суутгаж шилжүүлэхээр заасан байна.

Хуулийн төсөлд тэтгэвэр олгоход тавигдах шаардлага, тэтгэвэр авахад бүрдүүлэх материал, өргөдөл шийдэх, тэтгэвэр олгох гэх мэт зохицуулалт тусгасан байна.

Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг Нийгмийн бодлогын байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжиж шийдсэн.

Хуулийн төсөл хэлэлцэх үеийн бүлгийн байр суурь:

Энэ хуулийн төсөл нэр болоод тэтгэвэр өвлөнө гэдэг санаа нь зөв боловч үндсэн гол агуулгаараа үзэл баримтлалтайгаа зөрчилдөж байна.

Тодруулбал, тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь иргэдийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хуримтлалаар алдагдал тооцож болох, шимтгэл төлөгчийн хөрөнгөөс тус сангийн урсгал зардал, нягтлан бодох бүртгэл болон аудитын зардал зэргийг тооцож авна, дээр нь тухайн хуримтлагдсан хөрөнгөөс тухайн сан өөрсдийн ашигтай гэж тооцоолсон хөрөнгө оруулалтыг хийхээр хуримтлалыг ашиглах, сан шимтгэл төлөгчид баталгаатай гэх нэрээр өгөөж амлаж байгаа зэрэг зохицуулалтууд

нь Монгол улсад 2005-2008 онд маш хүчтэй гарч ирж олноор дампуурч иргэдийг хохироосон хадгаламж зээлийн хоршооны нэг адил эрсдэл дагуулж болзошгүй байна.

Энэ хуулийн зорилго нь шимтгэл төлөгчид тэтгэврийн хуримтлал үүсгэнэ гэх боловч сан байгуулсан этгээдийн олон төрлийн захиргааны зардлуудыг тэтгэврийн гэрээнд тусгах замаар суутгах, сангийн 9-өөс доошгүй гишүүнтэй удирдах зөвлөлтэй, тэдний ашигтай гэж үзсэн хөрөнгө оруулалтад шимтгэл төлөгчдийн хөрөнгийг оруулах, иргэдийн тэтгэврийн хуримтлалаар үнэт цаас авах, гадаадын холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах, амжилттай бол ашиг хуваарилж, амжилтгүй бол алдагдал хүлээх асуудлыг оруулсан байна. Энэ хуулийн үндсэн зорилго маш эргэлзээтэй, сан байгуулсан хэдэн этгээдийн хөрөнгө оруулалтыг дэмжих үйлдэл үү, хэдэн хүнийг цалинтай, ажилтай байлгах оролдлого уу гэдэг нь тодорхойгүй.

Мөн Шимтгэл төлөгч сангаа 3 жилд нэг удаа сольж болох боловч ийнхүү сольж шилжүүлсэн тохиолдолд өмнөх сан хөрөнгийг шилжүүлэхдээ захиргааны зардлаа суутгаж шилжүүлэж болох, нэг удаагийн багц тэтгэвэр гэх шимтгэл төлөгч нь тэтгэврийн насанд хүрээд тэтгэврийн хуримтлалаасаа нэг удаа бөөнөөр мөнгөө авах талаар зохицуулсан байна. Хэрэв тэтгэвэр авагч амьдралын аливаа асуудал, сэтгэл хөдлөлөөс шалтгаалан хуримтлуулсан хөрөнгөө нэг удаа аваад хэрэглэвэл өдөр тутмын амьдралын зардалаа хэрхэн зохицуулах талаар хүндрэл үүснэ. Өөрөөр хэлбэл хэдийгээр НДСангаас тэтгэврээ авах боловч шимтгэлээ хуваааж төлсөн учир тэр хэмжээгээр тогтоолгох тэтгэвэрийн хэмжээ буурна, шимтгэл төлөгч хуримтлуулсан хөрөнгөө нэг удаа авч хэрэглээд цаашид амьдралын наад захын хэрэгцээгээ хангахад үндсэн тэтгэвэр нь хүрэлцэхгүй өдөр хоногийн өнгөрөөх өндөр настнуудын тоо нэмэгдэх эрсдэлтэй.

Монгол улсад хувийн тэтгэврийн сан байгуулах нийгэм, хууль эрх зүйн боломж бүрдээгүй, өнөөдрийн байлаар тэтгэвэр, халамж төр хариуцаж байх нь эрсдэлгүй юм. Харин хамтын тэтгэврийн тухай хууль бол төр хариуцана, тэтгэвэр өвлөгдөнө гээд зүй зохистой зохицуулалт бүхий хууль байсныг МАН хүч түрэн хүчингүй болгосонд харамсалтай.

Энэ хуулийн төсөл нь Монгол улсад олноор байгуулагдаж олон хүнийг хохироосон хадгаламж зээлийн хороошооны үйл ажиллагаатай нэн төстэй, цаашид гарах үр дагвар нь тэдгээр дампуурсан хадгаламж зээлийн хоршоодтой адил харагдаж байна. Иймд энэ хуулийн төслийг дэмжих боломжгүй хуулийн төсөл байх тул хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэж дүгнэлээ.

Мэдээлэл бэлтгэсэн:
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуулийн
ахлах зөвлөх Л.Дэлгэрмаа

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР БАТЛАГДСАН ХУУЛЬ, УИХ-ЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ЖАГСААЛТ

2021.01.29

№	Батлагдсан хууль тогтоомжийн нэр	Хуулийн мэдээлэл			Тайлбар
		Хууль санаачлагч	Төлөв	Батлагдсан огноо	
1	Малын тоо толгойн албан татвараас тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.11.13	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийг дагаж батлагдсан.
2	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.11.13	
3	Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.11.13	
4	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.11.13	
5	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.12.04	2020 оны 12-р сарын 04-ний өдрөөс 2021 оны 7 сарын 1-ний өдөр хүртэл хэрэгжинэ.
6	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.12.04	
7	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай	УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан нарын гишүүд	Анхдагч хууль	2020.12.24	
8	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн	Анхдагч хууль	2020.12.24	
9	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай/ Шинэчилсэн найруулга	УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн нарын гишүүд	Шинэчилсэн найруулга	2020.12.24	
10	Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.12.25	
11	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.12.31	
12	Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2020.12.31	

13	Монгол Улсын шүүхийн тухай	Засгийн газар	Шинэчилсэн найруулга	2021.01.15	Монгол Улсын шүүхийн тухай багц хуулийн шинэчилсан найруулга батлагдсантай холбогдуулж дараах хуулиудыг хүчингүй болгосон. - Монгол Улсын шүүхийн тухай хууль - Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль - Шүүхийн захиргааны тухай хууль - Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль. /2021.01.15/
14	Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2021.01.15	
15	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2021.01.15	
16	Музейн тухай хууль	Засгийн газар	Анхдагч хууль	2021.01.29	
17	Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай	Засгийн газар	Анхдагч хууль	2021.01.29	
18	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн С.Бямбацогт	Нэмэлт өөрчлөлт	2020.11.06	
19	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022- 2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.11.13	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулиудыг дагаж орж ирсэн хуулиуд юм.
20	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.11.13	
21	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.11.13	
22	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт		
23	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.11.13	
24	Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.11.13	

25	Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.11.13	
26	Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ	Нэмэлт өөрчлөлт	2020.12.04	Үндсэн Хуулийн Цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн холбогдох заалтуудыг өөрчилсөн.
27	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.24	
28	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.24	
29	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.25	2021 оны 1 сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 сарын 1 хүртэл хэрэгжинэ.
30	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	
31	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж батлагдсан хуулиуд.
32	зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	
33	зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	
34	Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	
35	Гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	
36	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	

37	Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	
38	Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2020.12.31	
39	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	Монгол Улсын Шүүхийн шинэчилсэн найруулгын багц хуулийг дагаж батлагдсан хууль.
40	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
41	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
42	Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
43	Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
44	Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
45	Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
46	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
47	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
48	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
49	Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
50	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
51	Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.15	
52	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн Б.Баттөмөр нарын гишүүд санаачилсан	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж орж ирсэн хуулиуд

53	Банкин дахь мөнгөн хадгаламжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн Б.Баттөмөр нарын гишүүд санаачилсан	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж орж ирсэн хуулиуд
54	Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай		Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	
55	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	
56	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	
57	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	Музейн тухай хуулийг дагаж батлагдсан хуулиуд
58	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	
59	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	
60	Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	
61	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж батлагдсан
62	Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	
63	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	Газрын тосны боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийг дагаж батлагдсан
64	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж, Г.Тэмүүлэн	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	

65	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн Ц.Туваан нарын 11 гишүүн, Х.Булгантуяа нарын 2 гишүүн, М.Оюунчимэг нарын 4 гишүүн	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	4 хуулийг нэгтгэн хэлэлцсэн
66	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн Д.Ганбат	Нэмэлт өөрчлөлт	2021.01.29	
67	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх томилох тухай		УИХ-ын тогтоол Дугаар 29	2020.10.08	
68	Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай		УИХ-ын тогтоол дугаар 30	2020.10.23	
69	Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай		УИХ-ын тогтоол дугаар 31	2020.10.29	
70	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай		УИХ-ын тогтоол дугаар 32	2020.10.29	
71	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай		УИХ-ын тогтоол дугаар 34	2020.11.06	
72	Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 9 дүгээр дүгнэлтийн тухай		УИХ-ын тогтоол дугаар 35	2020.11.19	
73	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай		УИХ-ын тогтоол дугаар 36	2020.12.03	
74	Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай		УИХ-ын тогтоол дугаар 37	2020.12.03	
75	Ерөнхийлөгчийн хоригийн тухай		УИХ-ын тогтоол дугаар 38	2020.12.04	
76	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай		УИХ-ын тогтоол дугаар 39	2020.12.04	

77	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай		УИХ-ын тогтоол дугаар 40	2020.12.10	
78	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойргийн нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай		УИХ-ын тогтоол дугаар 41	2020.12.10	
79	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийн зардлын тухай		УИХ-ын тогтоол дугаар 42	2020.12.10	
80	Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай		УИХ-ын тогтоол дугаар 43	2020.12.10	
81	Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай		УИХ-ын тогтоол дугаар 44	2020.12.10	
82	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай		УИХ-ын тогтоол дугаар 45	2020.12.10	
83	Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай		УИХ-ын тогтоол Дугаар 48	2020.12.25	
84	Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай		УИХ-ын тогтоол Дугаар 01	2021.01.07	
85	Үндсэн хуулийн цэцийн 202С оны 12 дугаар дүгнэлтийн тухай		УИХ-ын тогтоол дугаар 02	2021.01.07	
86	Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай		УИХ-ын тогтоол дугаар 03	2021.01.14	
87	Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай		УИХ-ын тогтоол дугаар 04	2021.01.14	
88	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 ны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай		УИХ-ын тогтоол дугаар 07	2021.01.20	

89	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай		УИХ-ын тогтоол дугаар 08	2021.01.20	
90	Үндэсний статистикийн хорооны даргыг томилох тухай		УИХ-ын тогтоол дугаар 09	2021.01.20	
91	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай		УИХ-ын тогтоол дугаар 10	2021.01.21	
92	Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай		УИХ-ын тогтоол дугаар 11	2021.01.21	
93	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай		УИХ-ын тогтоол дугаар 12	2021.01.22	

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит намрын чуулганы нэгдсэн хуралдаан 82 хоногийн турш 131 удаа, Байнгын хороо, ажлын хэсгийн хуралдаан 114 удаа хуралдаж, нийтдээ 87 хууль, УИХ-ын 45 тогтоолын төсөл хэлэлцэн эцэслэн баталжээ.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН
БҮЛГИЙН АЖЛЫН АЛБА

2020 оны макро эдийн засгийн үзүүлэлт

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол Улсын ДНБ-ний хэмжээ энэ оны эхний 3 улирал (-10.7, -9.7, -7.3) дараалан буурлаа. Ийнхүү жилийн эцэст эдийн засаг агших нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс эдийн засгийн хямралд өртсөн дүн гарч байна.



Эх сурвалж: ҮСХ

Жич: Эдийн засгийн хэмжээг ДНБ хэмждэг. ДНБ нь тухайн улс орны нутаг дэвсгэр дээр (дотор) үйлдвэрлэж бий болгосон нийт бараа, бүтээгдэхүүн баялагыг хэмжих эдийн засгийн хэмжүүр юм. ДНБ өсөлттэй байх нь тухайн улс орны эдийн засаг өсч, сэргэж буйг харуулах бол, эсрэгээрээ бууралтай байгаа тохиолдолд эдийн засаг саармаг, эргэлт багатай, уналттай байгааг илэрхийлнэ. Эдийн засаг гурван улирал дараалан агшвал эдийн засгийн хямрал болж байна гэж үздэг.

Инфляц

Инфляц (Үнийн өсөлт, мөн Мөнгөний үнэгүйдэл) нь хэрэглээний сагсыг бүрдүүлж буй бараа үйлчилгээний үнийн ерөнхий түвшний өөрчлөлтийг хэмжих нэгж юм. 2020 онд эдийн засгийн хямрал бий болсонтой холбоотой эдийн засгийн идэвхжил суларчээ. Иргэдийн орлого багасч худалдан авалт эрс буурсан нь ийнхүү инфляцид нөлөөлжээ.



Эх сурвалж: ҮСХ

Жич: Үндэсний статистикийн хорооноос (ҮСХ) айл өрхүүдийн хэрэглээ, түүний хэв маягт судалгаа хийсний үндсэн дээр хэрэглээний барааны сагсны бүтцийг тодорхойлдог. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэрэглээний саг нийт 12 бүлгийн 329 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна. Хэрэглээний саг жилд өөрчлөгдөж болдог.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эцэст урьдчилсан гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 9.4 их наяд төгрөг байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 14.0 их наяд төгрөг болж, нийт тэнцэл 4.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Монгол Улс түүхэндээ ийм их алдагдалтай төсөвтэй байсангүй. Энэ алдагдлыг зөвхөн гадаад, дотоодын өр зээлээр нөхнө.

Татварын нийт орлого 8.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (13.4%) их наяд төгрөгөөр буурахад дараах орлогууд буурсан нь нөлөөлсөн байна. Үүнд:

- Орлогын албан татвар	442.5 тэрбум төгрөг (21.8%) ↓
- Нийгмийн даатгалын орлого	335.8 тэрбум төгрөг (13.1%) ↓
- Нэмэгдсэн өртгийн албан татвар	281.0 тэрбум төгрөг (11.3%) ↓
- Бусад татвар, төлбөр хураамжийн орлого	117.0 тэрбум төгрөг (12.8%) ↓
- Онцгой албан татвар	86.5 тэрбум төгрөг (10.0%) ↓
- Гадаад үйл ажиллагааны орлого	49.4 тэрбум төгрөг (6.3%) ↓

Гадаад худалдаа



Монгол Улс 2020 оны онд нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум америк доллар, импорт 5.3 тэрбум америк доллар боллоо. Гэхдээ валют олдог экспорт төдийлэн бууураагүй ба 43.3(0.6%) сая америк доллараар буурчээ.

Мөнгөний нийлүүлэлт




Тодорхой цаг хугацаанд гүйлгээнд эргэж байгаа нийт мөнгөний тоо хэмжээг мөнгөний нийлүүлэлт гэнэ. Нэг жилийн хугацаанд буюу 2020 онд 3.4 их наяд төгрөгөөр нэмэгджээ. Монголбанк хадгаламж нэмэгдсэн учраас гэж тайлбарлаж байгаа боловч коронавирусын хүнд жилд хадгаламж нэмэгдэх ямарч үндэслэлгүй юм.

Валютын ханш

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2020 оны 1 сарын 1 өдөр 2734.33 төгрөг байсан бол 2020 оны 12 дугаар сард 2849.55 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар суларсан.

Монгол банкнаас зарласан дундаж ханш



Валютын ханш

Жич: 2020 онд 3 тэрбум ам.долларын интервенц хийсэн нь манай нийт экспортын орлогын бараг тал хувь юм. Манай гадаад худалдаа эерэг гарсан, урд жилүүдэд байгаагүй их хэмжээний алт(23.5 тн) авсан байхад ханшаа алдаж нэмээд их хэмжээний валют интервэнцэд зориулах ёсгүй юм.

Монгол Улсын гадаад өр

Дөрөвхөн жилийн дотор Засгийн газрын өр хоёр Чингис бондын хэмжээтэй нэмэгджээ. Зах зээлд хөл тавьсан 1991 оноос 2016 оны хооронд Монгол улсын Засгийн газрын өрийн хэмжээ 4 тэрбум 785 сая ам.доллар байжээ. Гэтэл өнгөрсөн дөрвөн жилд энэ хэмжээ 8 тэрбум ам.доллар давж, даруй 3 тэрбум 266 сая ам.долларaар нэмэгдээд байна.

Нийт гадаад өрийн статистик /Сая ам.доллар/

	6/30/2012	6/30/2016	09/30/2020	Өөрчлөлт 2016/2020
Засгийн газар	2,010	4,786	8,052	+3,266
Төв банк	264	1,758	2,154	+396
Хадгаламжийн байгууллга	779	2,215	1,769	-446
Бусад салбарууд	2,691	8,304	8,016	-288
Шууд хөрөнгө оруулалт /компани хооронд зээл/	7,416	7,195	11,199	+4,004
Нийт гадаад өр	**13,161**	**24,259**	**31,192**	**+6,933**

Эх сурвалж: Монгол банк

ДҮГНЭЛТ:

Монгол Улсын ДНБ-ний хэмжээ энэ оны эхний 3 улирал (-10.7, -9.7, -7.3) дараалан буурлаа. Ийнхүү жилийн эцэст эдийн засаг агших нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс эдийн засгийн хямралд өртчихөөд байна. Хямралыг үндэсний нийт бүтээгдэхүүн буурах төдийхнөөр төсөөлж болохгүй. Үйлдвэр, аж ахуй нэгжүүд дампуурч ажилгүйдэл эрс нэмэгдэх бөгөөд хүн амын амьжиргааны түвшин огцом буурах зэрэг сөрөг үр дагавар сүүдэр мэт дагалддаг. Бизнесийн үйл ажиллагаа доголдохтой зэрэгцээд улсын төсөвт орох ёстой татварын мөнгө ч дутна. Засгийн газар, төрийн үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд гадна дотноос зээл тусламж нэмж авахаас өөр гарцгүй болно. Гадаад өрийн хэмжээ зохих түвшнээс дээш гарах тохиолдолд эдийн засгийн макро үзүүлэлтүүд буурч, нийгмийн тогтворгүй байдал нэмэгдэн, улс төрийн нөхцөл байдал хурцдах нөхцөл үүсдэг. Тиймээс хямралыг өдөөхгүй байх нь аливаа улс, орныг залж яваа удирдлагын багийн анхаарлын төвд байдаг хамгийн чухал асуудал юм.

Монгол Улс уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч орон. Тиймээс дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, ханшийн хэлбэлзлээс шалтгаалж эдийн засаг хямрахдаа амархан. Үүн дээр улс орны удирдлагын буруу бодлогыг нэмчихвэл Монгол улс байнга шахам хямралтай байдаг үндсэн шалтгаан тодорч ирнэ. Дөрвөн жилийн мөчлөгтэй Ерөнхийлөгч, УИХ-ын сонгууль нь эдийн засгийн хямралын бас нэгэн өдөөгч хүчин юм. Энэ нь сонгуулийн өмнө манай улсын төсвийн зардал огцом нэмэгдэх байдлаар илэрдэг. Үүнийг 2008, 2012, 2016, 2020 онуудын УИХ-ын сонгуулийн жилүүдэд нийгмийн халамжийн зардал, улсын хөрөнгө оруулалт, төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийн зардал огцом өссөн дүнгээс харж болно. Дэлхийн банк, манай улс уул уурхайн орлогынхоо 56 хувийг төсвийн хөрөнгө оруулалт, 28 хувийг нийгмийн халамж, 16 хувийг цалин, тэтгэвэр нэмэхэд зарцуулдаг гэсэн тооцоо хийжээ. Энэхүү огцом нэмэгдсэн зарлагаа уул уурхайн орлогоос гадна гадаадын зээлээр санхүүжүүлдэг болсон билээ.

Монгол Улсын төсвийн алдагдал болон гадаад өрийн хэмжээ маш их, хөрөнгө оруулалт нь үр ашиггүй, эрх мэдэлтнүүдийн халаас зузаатгах хэрэгсэл болон хувирсан байдаг. Ердөө 4 жилийн өмнө Монгол гэдэг айлын төсвийн зарлага 6-7 их наяд төгрөгийн хэмжээнд эргэлдэж байсан бол 2020 онд 13 их наяд 872 тэрбум, 2021 онд бараг 14 их наяд төгрөгт хүрч хоёр дахин өссөн байна. Сүүлийн 8 жилийн дунджаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнд эзлэх урсгал зардал 74.0 хувиас буурахгүй байгаа нь төсвийн зардал үрэлгэн, төсвийн бүтэц оновчгүй, төсвийн удирдлагын бодлогыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн
Ажлын албаны зөвлөх,
Эдийн засгийн ухааны доктор Р.Даваадорж

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын алба



Ажлын алба нь УИХ дахь Ардчилсан намын бүлгийг бодлогоо тодорхойлоход нь зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй.

УИХ дахь Ардчилсан намын ажлын алба бүтцийн хувьд гурван хэсгээс бүрдэж байгаа бөгөөд дараах чиг, үүрэгтэйгээр ажиллаж байна.

- **Бодлого судалгааны хэсэг**

УИХ-ын чуулган, байнгын хороодоор хэлэлцэхээр тогтсон хууль, шийдвэрийн төслүүд, Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцид нийцэж буй эсэх талаар судалгаа, санал дүгнэлт боловсруулах.

- **Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэсэг**

Бүлгийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах үндсэн чиг үүрэгтэй. Энэ үүргийнхээ хүрээнд бүлгийн хуралдааны тойм, мэдээллийг бэлтгэх, бүлэг бүлгийн гишүүдийн байр суурийг олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

- **Дотоод зохион байгуулалтын хэсэг**

Бүлгийн хуралдааны бэлтгэл хангаж, зохион байгуулах, ирцийг бүрдүүлэн ажиллана. Мөн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хорооны хуралдааны ирцийг хангана. Бүлгийн хуралдааны тэмдэглэл хөтлөх, архивлах зэрэг чиг үүрэгтэй.

Нэрс	Албан тушаал
Д.Амарбаясгалан	Ажлын албаны дарга
Л.Дэлгэрмаа	Хуулийн ахлах зөвлөх
Б.Оюунтуяа	Зохион байгуулалтын хэсгийн ахлах зөвлөх
М.Алтанцэцэг	Олон нийттэй харилцах хэсгийн ахлах зөвлөх
Р.Даваадорж	Эдийн засгийн зөвлөх

Нэрс	Албан тушаал
Б.Ганхөлөг	Хуулийн зөвлөх
Б.Батбаяр	Ажилтан
Б.Тогоодорж	Ажилтан
Д.Мөнхгэрэл	Ажилтан
Б.Цэдэвсүрэн	Ажилтан



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлд Ардчилсан намын бүлгээс өгөх санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн танилцуулав.



Баянхонгор аймагт өвөлжилт, хаваржилт хүндрэх төлөвлтэй байгаа тул өвс, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх талаар ХХААХҮЯ-ны удирдлагуудтай санал солилцож, дэмжлэг хүсэв.



Эрдэнэбүрэн сумын иргэн, аймгийн сайн малчин, аймгийн алдарт уяач, Алтан унаганы эзэн Н.Лхагвасүрэнгийнд зочилж малчдын аж амьдралын талаар ярилцлаа.



Бүгд Найрамдах Турк Улсын хамтын ажиллагааны агентлаг (ТИКА)-ын Улаанбаатар дахь хөтөлбөрийн зохицуулагч Эмрах Устаомертай уулзав.



“Эмээгийн цайны газар”-таа очив.



Даланзадгад сумын иргэдтэй уулзалт хийж шагнал гардуулав. 2020.10.11



2020 онд аймгийнхаа бүх сумдаар хоёр удаа тойрч иргэд сонгогчидтойгоо уулзлаа.



УИХ дахь Ардчилсан намын бүлэг даваа гариг бүр ээлжит хуралдаанаа хийж, гаргасан шийдвэрээ олон нийтэд танилцуулдаг уламжлалтай.



Баян-Өлгий аймгаас төрсөн алдартнуудын хамт



ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ёорн Розенбергийн хамт Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлэгт



Ахмад настны тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх хуулийн төслийг танилцуулав.



Америкийн Бүгд найрамдахчуудын хүрээлэн (IRI)-гийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.



УИХ-ын гишүүн С.Одонтуяагийн гадаадад гацсан иргэдийнхээ төлөөх суултыг дэмжиж байгаагаа илэрхийллээ.




Төрийн одон медаль хүртсэн Сүхбаатар аймгийн иргэддээ баяр хүргэв.



С.Одонтуяа гадаадад гацсан иргэдээ яаралтай эх оронд нь авч ирэх, ирж чадахгүйд нь мөнгөн тусламж үзүүлэхийг УОК-т шаардаж суулт зарлав.



УИХ-ын дэд дарга С.Одонтуяа Монгол Улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын хувьд хэлмэгдэгсдийн хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүллээ.



Б.Пүрэвдорж ард иргэдийн амьдралд тулгамдаж буй асуудлыг шийдэх 10 хуулийн төсөл боловруулж, заримыг нь өргөн бариад байна.



Аян замд нутгийн ах нартай



Төв аймгийн Сүмбэр сумын иргэдтэй уулзав. 2020.10.03



“Туваан” сангаас зарласан оюутны сургалтын тэтгэлэгт 35 оюутныг хамруулав
2020.08.25



Увс аймгаас ирсэн иргэдийн төлөөллийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.



Шинэ эдийн засаг-Увс уулзалтын үеэр. 2020.09.19



“Сонгууль шударга явагдаж үр дүнг нийтээрээ хүлээн зөвшөөрөх нь ардчиллын том шалгуур юм” гэж СЕХ-ны удирдлагуудтай уулзах үеэрээ онцоллоо.



Гишүүд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай танилцлаа. Уг чиглэлд нийт 414.6 км төмөр зам барьж байна.



Бүлгийн гишүүд УИХ-ын дарга Г.Занданшатарт дахин сонгогдсонд баяр хүргэв. Парламент дахь сөрөг хүчний хувьд хяналт тавьж, хамтран ажиллана гэдгээ илэрхийллээ.



Чуулган танхимд



Баянхонгор аймагт өвөлжилт хүндэрч байгаатай холбоотой өвс тэжээлийн нөөцийн асуудлаар холбогдох албаны хүмүүст хүсэлт хүргүүлэв.



УИХ дахь Ардчилсан намын бүлгийн хуралдааны дараах хэвлэлийн мэдээллийн цаг

Тэмдэглэл

Тэмдэглэл

